




МАНДАЛ
даатгал

10

ХАМГИЙН ТОМ ДААТГАГЧ БОЛСОН 10 ЖИЛ



Жилийн тайлан
2020

ТАВТАЙ МОРИЛ

Бидний амьдарч буй дэлхий ертөнц гайхамшгийн өлгий билээ. Хайртай бүхэнд минь хамгаалал, өмгөөлөл, аврал, энэрэл хэчнээн их хэрэгтэй болдгийг мэдрэх бүр бид тэдгээр гайхамшгуудын тухай санах учиртай. Бид сайн сайхан бүхнээр хүрээлэгдэн амьдарч байгаагийнхаа адилаар болзошгүй аюул осол, гэнэтийн эрсдэл дунд оршин байдаг. Тэдгээр эрсдэл бидний амьдралын нэг хэсэг болжээ.

Монгол Улс зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралтынхаа тоогоор хөгжингүй орнуудаас даруй зургаа дахин их, элэгний хорт хавдрын өвчлөлөөр дэлхийд 1-т, ходоодны хорт хавдраар 2-т жагсаж байна. Өдөр бүр дунджаар хоёр хүн зам ослоос болж, 13 хүн хорт хавдрын улмаас амь насаа алддаг гэсэн харамсалтай үзүүлэлт бий. Гэхдээ эрсдэл зөвхөн эрүүл мэнд, зам тээврийн ослоор хязгаарлагдахгүй, бидний алхам тутамд дохиолох боломжгүй олон эрсдэл тохиолдож, Монгол хүний амьдрах орчин улам доройтсоор байна.

Эрсдэл хэнийг ч тойрохгүй. Харин хүн эрсдэлийг тойрон гарч, эсвэл урьдчилан тооцож болдог. Амьдрал дахь эрсдэлүүдийг бууруулдаг тэрхүү гайхамшгийг бид даатгал гэж нэрлэдэг билээ. Мандал даатгал үүсгэн байгуулагдсан цагаасаа Монгол хүний эргэн тойронд амь бөхтэй оршиж байгаа энэ их эрсдэлийг бууруулахын төлөө шамдан ажилласаар ирлээ. Монгол Улсын эдийн засгийг нуруун дээрээ үүрч явдаг 70 мянга гаруй компани, тэдгээрт ажиллаж буй олон зуун мянган иргэний бизнесийн болон нийгмийн орчны эрсдэлийг удирдаж, бууруулахад хувь нэмрээ оруулах нь бидний зорилго юм.

Нийгмийн эрсдэлийг бууруулах үйл хэрэг нь зөвхөн нэг компанийн үүрэх хариуцлага биш боловч бид 10 жилийн турш энэхүү хүнд ачааг нэр төртэй үүрэлцсэн байна. Нийгэмдээ эерэг нөлөө бий болгох бидний хүсэл эрмэлзэл, хичээл зүтгэл бизнесийн маань суурь болж, түүн дээрээ итгэлтэй, тогтвортой даатгалын тогтолцоог бүтээн босгож чаджээ.

Энэхүү тайлангаас та Мандал даатгалын 10 жилийн түүхэн амжилтууд, санхүү болон үйл ажиллагааны үр дүнгүүд, аудитлагдсан санхүүгийн дэлгэрэнгүй тайлан зэрэгтэй танилцах болно.

Бидний түүхийг хамтдаа цааш үргэлжлүүлэх хүн бүхэнд зориулав.

Компанийн мэдээлэл

Компанийн нэр	Мандал даатгал ХК
Үйл ажиллагаа	Ердийн даатгал
Байгуулагдсан огноо	2011 оны 4 сарын 26
Гүйцэтгэх захирал	Батсайханы Жавхлан
Ажилтны тоо	150
Цахим хуудас	www.mandal.mn

01

Мандалын ТОЙМ

Хуудас 06

10 жилийн онцлох үзүүлэлтүүд

Түүхэн товчоон

Зах зээлийн нөхцөл байдал

Удирдлагын мэндчилгээ

02

Стратегийн тайлан

Хуудас 22

Санхүүгийн үр дүн

Андеррайтингийн үйл ажиллагаа

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа

Борлуулалт, бизнес хөгжил

Үйлчилгээ, нөхөн төлбөр

Үйл ажиллагаа - Back office

Эрсдэлийн удирдлага

03

Нийгмийн хариуцлага

Хуудас 80

Оюуны томоохон хөрөнгө оруулалтууд

Эрсдэлийн боловсрол

04

Мандалын засаглал

Хуудас 85

Корпорацын сайн засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл

Гүйцэтгэх удирдлага

05

Аудитлагдсан санхүүгийн тайлан

Хуудас 100

10 ЖИЛИЙН

Даатгалын хамгийн том компани

1

Мандал даатгал ХК нь 10 жилийн босгон дээрээ санхүүгийн бүхий л үзүүлэлтүүдээрээ тэргүүлдэг, даатгалын салбарт шинэ стандарт, шинэлэг ёс суртахууныг нэвтрүүлэгч ТОП компани болж чадлаа.

2020 оны байдлаар нийт хөрөнгө 55.2 тэрбум, мөнгөн хөрөнгө 33.6 тэрбум төгрөгт тус тус хүрч, эрсдэл даах чадвараараа салбартаа тэргүүлж байна. Түүгээр ч зогсохгүй ашигт ажиллагааны түвшингээр салбараа манлайлж, ашгийн хэмжээгээр сүүлийн 3 жил тасралтгүй тэргүүлсэн юм.

Эрсдэлийн боловсролын түүчээ

2

Мандал даатгал нь ашиг орлогоос илүүтэй нийгэм, улс орондоо оруулах хувь нэмэртээ илүү их анхаарал хандуулж ирсэн нь амжилтын гол түлхүүр байлаа. Тиймдээ ч бид нийгэмд эрсдэлийн боловсролыг түгээх чиглэлд урьд өмнө нь ямар ч компанийн хийж чадаагүй их ажлыг нугалж, олон тооны төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж чадсан юм.

Тухайлбал, бидний анх санаачлан, жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг **Эрсдэлийн Удирдлагын Форум**аар салбар бүрийн мэргэжилтнүүд уулзаж, эрсдэлийн талаар хэлэлцэж заншсан нь Монголын хамгийн том арга хэмжээ болжээ.

Салбарын сэтгэлгээний манлайлагч

3

Олон нийтийн эдийн засаг, санхүү, эрүүл мэндийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлд олон төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжүүлэн, салбартаа сэтгэлгээний манлайлагчийн үүргээ үлгэр жишээ гүйцэтгэж байна. Эдгээрийн тод жишээнээс дурдвал: "Purplebook" сэтгүүл, "Checklist manifesto", "Эрсдэлийг удирдахуй" номнууд, Хүүхдийн эрсдэлийн сургууль, "eDoctor.mn" платформ зэргийг нэрлэж болно.

Үлгэр жишээ корпорацийн засаглал

4

Мандал даатгал нь нээлттэй компани болсны дараа ямарваа нэг нэгдмэл сонирхолтой этгээд компанийн нийт хувьцааны 51-ээс дээш хувийг эзэмшихгүй байгаа нь хөрөнгийн зах зээл дээр корпорацийн засаглал сонгодог утгаар хөгжих анхны жишээ болж, ирээдүйн жишиг компанийг илэрхийлж байна.

Түүнчлэн, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа улирал бүр цаг алдалгүй олон нийт, хөрөнгө оруулагчдадаа танилцуулж, хувьцаат компаниудын дунд "шилэн тайлагналын" шинэ хэм хэмжээг тогтоон ажиллаж байна.

Хамгийн COOL хамт олон

5

Мандал даатгалын хүний нөөцийн бодлого Creative (Бүтээлч), Opportunity given (Боломж олгогч), Online (Цахим) бөгөөд Learning (Суралцагч) байхыг дэмжин ажилладаг. Иймдээ ч, Мандалчууд үргэлж шинийг эрэлхийлдэг, өсөж дэвжих орон зайгаар хангагдсан, цахим шилжилтийг дэмжсэн COOL хамт олон байж чаддаг.

10 АМЖИЛТ

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар

Мандал даатгал нь 2020 олон улсын үнэлгээний "AM Best" агентлагаас санхүүгийн чадавх болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ авсан анхны Монгол компани боллоо.

"AM Best" агентлаг Мандал даатгалын ерөнхий санхүүгийн чадавхыг "B", урт хугацааны зээлжих зэрэглэлийг "BB+" гэж тус тус үнэлсэн бөгөөд цаашдын төлөвийг нь "Тогтвортой" хэмээн дүгнэжээ.

Салбарын "мөс зүсэгч"

Мандал даатгал нь байгуулагдсан цагаасаа эхлэн бусадтайгаа өрсөлдөх биш, харин манлайлах байр сууринд явж ирэв. Даатгалын зах зээл дээр нэгэнт тогтож хэвшсэн арга барилыг биш, цоо шинэ хэв загварыг хэрэглэхийн төлөө чармайж ирлээ. Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, амьдралд ойрхон бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан шинэ хэрэглэгчдийн бааз суурийг бүрдүүлж, даатгалын зах зээлийг тэлэх зарчмыг баримтлан ажиллав.

Энэ зарчмын хүрээнд сүүлийн 10 жилийн хугацаанд даатгалын зах зээл дээр олон шинэ, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн, сайн дурын даатгалтай хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж чадлаа.

Тогтвортой менежмент, тогтвортой өсөлт

Тогтвортой, ур чадвартай, банк, санхүү, даатгалын салбарт мэргэшсэн, олон жилийн туршлагатай менежментийн багийг бүрдүүлсэн.

Даатгалын бизнесийг олон улсын жишигт

Монголчуудын хувьд даатгал нь харьцангуй шинэлэг ойлголт боловч орчин үеийн хэлбэр нь 350 гаруй жилийн түүхтэй, нарийн стандарт, тогтолцоотой, шинжлэх ухаанд суурилсан нэн онцлог бизнес юм. Бид даатгалын салбарын тэргүүлэгчийн хувьд энэхүү Олон Улсын стандартыг нэвтрүүлэх, даатгалын үйлчилгээг шинэ түвшинд гарган хөгжүүлэх үүрэгтэй.

Өсөлтөө бусадтай хуваалцагч

2018 онд бид өөрсдийн бизнесийг нээж, ирээдүйн өсөлтөө олон нийттэй хуваалцах зорилгоор нээлттэй компани болох аяныг өрнүүлсэн. Энэ нь даатгалын салбарын түүхэнд шинэ хуудсыг нээж, даатгалын анхны IPO-г амжилттай хэрэгжүүлж, компанийнхаа нийт хувьцааны 25 хувийг олон нийтэд эзэмшүүлсэн.

Нээлттэй компани болсон цагаас жил бүр ногдол ашиг олгож байгаа бөгөөд 2019 болон 2020 оны цэвэр ашгаас тус бүр 43 болон 41 хувийн ногдол ашиг олгох шийдвэр гаргаад байна.



“ЭРСДЭЛ МИНИЙ НҮДЭЭР” зургийн уралдаан,
Мандал Эрсдэлийн Сургуулийн сурагч Т.Намуун, 12 настай



01

МАНДАЛЫН
ТОЙМ


2020 ОНЫН ОНЦЛОХ 10 ЖИЛИЙН ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын хамгийн том даатгагч болсон **10 жил**

НИЙТ ХӨРӨНГӨ, тэрбум төгрөг

55.2 тэрбум


Дундаж өсөлт*: 27%



МӨНГӨН ХӨРӨНГӨ, тэрбум төгрөг

33.6 тэрбум


Дундаж өсөлт: 21%



ХУРААМЖИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг

33.2 тэрбум


Дундаж өсөлт: 59%



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО*, тэрбум төгрөг

5.5 тэрбум


Дундаж өсөлт: 38%



НӨХӨН ТӨЛБӨРИЙН НӨӨЦ САН, тэрбум төгрөг

6.4 тэрбум

Дундаж өсөлт: 66%




80 жилийн түүхтэй Монголын даатгалын салбарт шинэчлэл, шинэ стандарт, шилдэг менежментийг нэвтрүүлэх замаар даатгуулагчид, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд болон нийгэмдээ урт хугацааны үнэ цэнэ бий болгох хүчирхэг бизнесийг цогцлоох аяны **эхний арванг** амжилт дүүрэн үдэж байна.

НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР, тэрбум төгрөг

7.9 тэрбум


Дундаж өсөлт: 69%



ЦЭВЭР АШИГ, тэрбум төгрөг


4.5 тэрбум

Дундаж өсөлт: 33%




НИЙЛМЭЛ ХАРЬЦАА*, хувиар

95%



ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА, хувиар

161%



Дундаж өсөлт: Жилүүдийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR). Нийт хугацааны туршид жил тутамд дунджаар хэдэн хувиар өссөн болохыг хэмжих үзүүлэлт.

2020 оны хөрөнгө оруулалтын орлого: Хөрөнгө оруулалтын орлогод валютаар хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой ханшийн бодит олзыг багтаасан болно.

Нийлмэл харьцаа: Үйл ажиллагааны зардал болон цэвэр нөхөн төлбөрийг орлогод тооцсон хураамжид харьцуулан тооцдог үзүүлэлт.

ОН ЦАГИЙН ТОВЧООН

2011 04

Тусгай зөвшөөрөл

Санхүүгийн Зохицуулах
Хорооноос (СЗХ) ердийн
даатгалын үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлөө авав.



06

11

2012 09

Bancassurance Монголд

Хаан Банктай хамтран
Монголд анх удаа даатгалын
зуулчлалын үйл ажиллагааг
нэвтрүүлж, даатгалын
хүртээмжийг нэмэгдүүлэх
үндэс суурийг тавив.



Бидний эхлэл

Канадын хөрөнгө оруулалттай Mongolia Growth Group
компанитай хамтран, АНУ болон Канадын хөрөнгийн
бирж дээр хөрөнгө босгон Мандал даатгал ХХК-ийг
үүсгэн байгуулав.



Эрсдэлийн Удирдлагын Форум

Монгол Улсын хэмжээнд
бодитоор оршиж буй
эрсдэлүүдийг судалж шинжлэн
илрүүлэх, тэдгээрийг удирдах
арга замуудыг мэргэжлийн
байгууллагуудын оролцоотойгоор
хэлэлцэж боловсруулах
зорилготой "Монгол Улсын
Эрсдэлийн Удирдлагын Форум"
арга хэмжээг санаачлан,
хэрэгжүүлж эхлэв.



08

2014

Голомт Файнэншил Групп

"Голомт Файнэншил Групп" ХХК Мандал
даатгалын стратегийн хөрөнгө оруулагч
болж, санхүүгийн салбарт синержи үүсгэх
боломж бүрдэв.



2015 10


Жаргалан даатгал

Монголын анхны дотоодын хувийн эрүүл мэндийн даатгал болох Жаргалан даатгалыг зах зээлд нэвтрүүлэв.

2017 04

Оюу Толгой төслийн даатгагчаар шалгарав

Монгол Улсын хамгийн том татвар төлөгч компани болох Оюу Толгой ХХК-ийн 2,400 ажилтны Эрүүл мэнд, Гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг үзүүлэх даатгагчаар шалгарав.



2019 01

ТОП 20 ИНДЕКС

Мандал даатгалын хувьцаа Монголын Хөрөнгийн Биржийн ТОП 20 индексийн багцад оров.



2016 12

ТОП III

Санхүүгийн голлох үзүүлэлтүүдээрээ даатгалын салбарын ТОП 3 компанийн эгнээнд элсэв.

2018 09


IPO

Монголын даатгалын салбарын түүхэнд шинэ хуудас нээн, анхны IPO-г амжилттай хийж, нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгосноор нийт 7.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэв.

2019 07

Азийн шилдэг даатгалын компани

Азийн шилдэг даатгалын компаниудыг шалгаруулдаг INSURANCE ASIA AWARDS шагнал гардуулах ёслолоос “Дотоодын шилдэг даатгалын компани” өргөмжлөлийг хүртэв.



05 2020

82,000 харилцагчаа КОВИД даатгалд үнэ төлбөргүй хамруулав

Дэлхий нийтийг цочроосон Ковид-19 цар тахлын улмаас ард иргэдэд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор, нийгмийн хариуцлагын хүрээнд КОВИД санхүүгийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, өөрийн 82,000 даатгуулагчийг үнэ төлбөргүй хамруулав.



12

AM Best BB+ үнэлгээ авав

Олон улсын үнэлгээний “AM Best” агентлагаас санхүүгийн чадавх болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ авсан анхны Монгол компани болов. AM Best агентлаг Мандал даатгалын ерөнхий санхүүгийн чадавхыг “B”, урт хугацааны зээлжих зэрэглэлийг “BB+” гэж тус тус үнэлсэн бөгөөд цаашдын төлөвийг нь “Тогтвортой” хэмээн тодорхойлов.



2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- Мандал даатгал ХК нь олон улсын үнэлгээний “AM Best” агентлагаас санхүүгийн чадавх болон зээлжих зэрэглэлийн үнэлгээ авсан анхны Монгол компани боллоо. “AM Best” агентлаг Мандал даатгалын ерөнхий санхүүгийн чадавхыг “B”, урт хугацааны зээлжих зэрэглэлийг “BB+” гэж тус тус үнэлсэн бөгөөд цаашдын төлөвийг нь “Тогтвортой” хэмээн үзжээ. Энэхүү зэрэглэлийг гаргахдаа компанийг олон талаас нь судалж, санхүүгийн үзүүлэлтүүд болон өмнөх хугацааны гүйцэтгэлийг “Strong” хэмээн тодорхойлсон байна. Даатгалын салбараар мэргэшсэн үнэлгээ хийдэг олон улсын цор ганц байгууллагаас ийм өндөр үнэлгээ авсан нь Мандал даатгалын андеррайтинг, хөрөнгө оруулалт, эрсдэлийн үнэлгээний үйл ажиллагаа олон улсын стандартын дагуу явагддагийн тод илрэл юм.
- 2020 онд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 14.7 тэрбум төгрөгөөр өсч 55.2 тэрбум төгрөгт, мөнгөн хөрөнгийн хэмжээ 33.6 тэрбум төгрөгт тус тус хүрч түүхэн дээд хэмжээндээ хүрлээ. Ингэснээр, Мандал даатгал нь Монголын даатгалын салбарын хамгийн том компани гэсэн байр сууриа баталлаа.
- Хөрөнгө оруулалтын орлого 5.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 47 хувиар өссөн ба хөрөнгө оруулалтын өгөөж салбарын дундаж өгөөжөөс даруй 7.4 хувь нэгжээр илүү үзүүлэлттэй байна.
- Ковид цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт буурсан, их сорилтын жил байсан ч 2020 онд 4.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, ашигт ажиллагааны үзүүлэлтээр салбартаа дахин тэргүүлээ.
- 2020 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн (ТУЗ) шийдвэрээр компанийн 2019 оны цэвэр ашгаас нийт 2.49 тэрбум төгрөг буюу компанийн нэгж хувьцаанд дөрвөн төгрөгийн ногдол ашгийг хуваариллаа. Түүнчлэн, 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд гурван төгрөг буюу нийт 1,87 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлээд байна.
- Мандал даатгалын зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд цар тахлын улмаас ард иргэдийн нуруун дээр ирэх санхүүгийн ачааллыг хөнгөлөх зорилгоор “КОВИД” санхүүгийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, өөрийн 82,000 даатгуулагчийг үнэ төлбөргүй хамруулав. “КОВИД” нэртэй энэхүү даатгал нь харилцагч Ковид-19 өвчин тусах буюу уг вирус идэвхтэй байдлаар анх удаа оношлогдсон тохиолдолд 500,000 - 3,000,000 төгрөгийн мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгох нөхцөлтэй шинэлэг даатгалын бүтээгдэхүүн юм.

ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЭДИЙН ЗАСГИЙН СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

2020 он дэлхий нийтээр цар тахалтай тэмцсэн, эдийн засаг уналтанд орсон, иргэдийн амьжиргаа буурсан тун хүндхэн жил болж өнгөрлөө. Олон улсын валютын сангийн судалгаагаар тус онд дэлхийн эдийн засаг 3.5 хувиар агших төлөвтэй байсан бол манай улсын хувьд эдийн засаг 5.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнд голлон нөлөөлсөн салбаруудыг авч үзвэл, хаврын саруудад вирустэй холбоотойгоор манай улс нүүрсний экспортоо зогсоосон нь уул, уурхайн салбарт том цохилт өгчээ. Улмаар 2020 онд уул уурхайн салбарын өсөлт өмнөх оноос 9.4 орчим хувиар буурчээ.

Уул уурхайн салбарын уналтаас үүдэн тээврийн салбар 20.1 хувиар буураад байна. Мөн оны сүүл хагаст хатуу хөл хорио тогтоосон нь үйлчилгээний салбаруудыг 0 зогсолт хийхэд хүргэв. Үүнээс нийтийн хоол, зочид буудал 29.7 хувь, үйлчилгээний бусад салбар 3.8 хувиар буурсан байна. Харин хөдөө аж ахуйн салбарт 6.2 хувийн өсөлт, санхүү болон даатгалын салбарт 0.9 хувийн өсөлт гарсан нь энэ оны хамгийн сайн мэдээ юм.

Нийт эдийн засаг уналттай байсан ч, санхүүгийн салбарт өсөлт ажиглагдлаа.


ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРУУДЫН ӨСӨЛТ, 2020 он



Засгийн газрын зүгээс зах зээлд мөнгө нийлүүлэх замаар эдийн засгийг дэмжих оролдлого хийсэн боловч хэрэгжилт төдийлөн сайн байсангүй. Мөн ам.долларын эрэлт өндөр байгаагүй тул валютын ханш харьцангуй тогтвортой, инфляци 2.6 хувьтай буюу бага түвшинд байв. Нэг үгээр хэлбэл, 2020 онд эдийн засгийн идэвхжил маш сул жил болж өнгөрлөө. Энэ мэт олон сөрөг үйл явдал Монголын эдийн засагт тохиосон ч нөгөө талдаа таваарын ханш өндөр байж, улсын экспортын орлогод том дэмжлэг болж байв. Жишээ нь, оргил үед зэсийн ханш тонн нь 9,000 ам.доллар давсан нь түүхэнд тэмдэглэх өндөр үнэ юм.

Энэхүү суурь нөхцөл байдал дээр үндэслэн ирэх онд эдийн засгийн өсөлт ямар байдалтай байхыг доорх графикаар үзүүлээ. Энэхүү дүгнэлт нь дотоодын болон олон улсын судалгааны байгууллагуудын гаргасан таамаглал болно.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, Төсөөлөл



Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС



Хөрөнгө оруулалтын менежер Д.БААТАРЖАВ

Ирэх оны хувьд нүүрс болон зэсийн үнэд өөрчлөлт орохгүй. БНХАУ-ын эдийн засаг сэргэж буйтай холбоотойгоор манай улсаас таваарын эрэлт өндөр байхаар хүлээгдэж байна.

2020 онд баримталсан төсөв, мөнгөний тэлэх бодлого 2021 онд нөлөөллөө үзүүлнэ. Улмаар зээлийн өсөлт нэмэгдэх хандлагатай байна. Банкууд их хэмжээний бэлэн мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгөтэй байгаа нь хүүгээ бууруулах суурь нөхцөл болно. Мөн ирэх онд хадгаламжийн хүү их хэмжээгээр буурах төлөвтэй байна.

ЕРДИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхий дахинд Ковид-19 халдвараас үүдэн даатгалын салбарт олон өөрчлөлт гарснаас хамгийн том нөлөө үзүүлсэн нь бизнес тасалдалтай холбоотой их хэмжээний нөхөн төлбөр гарсан байв. Харин манай улсын хувьд даатгалын салбарт эерэг нөлөөтэй байлаа. Монголын даатгалын салбарын хөгжил бусад оронтой харьцуулахад бага тул эдийн засаг болоод нийгмийн бүхий л нөхцөлд өсөх боломжтой юм.

2020 онд даатгалын компаниудын нийт актив жилийн 4.4 хувиар, нийт хураамжийн орлого 4.3 хувиар тус тус өссөн. Улмаар даатгалын компаниудын нийт актив 382 тэрбум төгрөг, хураамжийн орлого 205 тэрбум төгрөгт хүрлээ.

Даатгалын салбарын хувьд өсөлттэй жил боллоо.

382 тэрбум

ДААТГАЛЫН САЛБАРЫН НИЙТ АКТИВ,
тэрбум төгрөг



205 тэрбум

ДААТГАЛЫН САЛБАРЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО,
тэрбум төгрөг



Даатгалын нэвчилтийн түвшинг тооцон харвал манай улсын хувьд 2020 онд 0.5 орчим хувьтай байгаа нь сүүлийн жилүүдэд төдийлөн нэмэгдээгүй үзүүлэлт юм. Энэ нь хөгжиж буй орнуудын дунджаас даруй хоёр нэгж хувиар, өндөр хөгжилтэй Азийн орнуудаас есөн нэгж хувиар бага байна. Энэ нь даатгалын зах зээлийн өсөлтийн боломжийг улам бүр тодорхой болгож буй юм.

ДААТГАЛЫН НЭВЧИЛТИЙН ТҮВШИН, хувиар







Эх сурвалж: YCX

Бусад үзүүлэлтээс дурдвал, 2020 онд 60 орчим тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон ба даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ 174 тэрбум төгрөг байв. Тус онд нийт 16 даатгалын компани, 55 даатгалын зуучлалын компани, 2,473 даатгалын төлөөлөгч үйл ажиллагаа явуулжээ.

2019 онд даатгалын компаниудын цэвэр ашиг 17.3 тэрбум төгрөг байсан бол 2020 онд 17.6 тэрбум төгрөг болж жилийн хугацаанд 1.4 хувийн өсөлт үзүүлжээ. Энэ нь эдийн засгийн уналттай жилд маш том амжилт юм.


Ердийн даатгалын салбарын голлох үзүүлэлтээр тэргүүлэгч компаниуд

Ердийн даатгалын салбарын үзүүлэлтүүдийг компаниар нь салган эхний таван компани дараах байдалтай жагсаж байна. Нийт хөрөнгийн дүн, мөнгөн хөрөнгийн болон цэвэр ашгаар салбартаа Мандал даатгал тэргүүлж байгаа бол нийт хураамжийн орлогоор Бодь даатгал нэгдүгээрт жагсаж байна.

НИЙТ ХӨРӨНГӨ, тэрбум төгрөг**МӨНГӨН ХӨРӨНГӨ**, тэрбум төгрөг**НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО**, тэрбум төгрөг**ЦЭВЭР АШИГ**, тэрбум төгрөг

Даатгалын бизнесийн үндсэн хоёр үйл ажиллагааны нэг болох хөрөнгө оруулалт нь даатгалын компанийн ашигт ажиллагаанд чухал ач холбогдолтой.

Хөрөнгө оруулалтын орлогын үзүүлэлтүүдийг харьцуулан үзвэл Мандал даатгал 5.5 тэрбум төгрөгийн орлогоор хамгийн өндөр орлоготой ажилласан бол Ард даатгал 2.6 тэрбум төгрөгийн орлогоор удаалжээ.

ТОП 5 компанийн хөрөнгө оруулалтын орлого, 2020, тэрбум төгрөг

Эх сурвалж: Монголын даатгагчдын холбоо

ӨЛЗИЙБАЯРЫН ГАНЗОРИГ

Төлөөлөн удирдлах зөвлөлийн
дарга, Үүсгэн байгуулагч



“

Бид ашиг орлогоос илүүтэй, нийгэм улс орондоо оруулах хувь нэмэртээ илүү их анхаарал хандуулдаг. Энэ нь бидний амжилтын нууц гэж хэлж болно.

НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ХАРИЛЦАГЧИД, ХАМТ ОЛОНДОО 10 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНДИЙГ ДЭВШҮҮЛЬЕ!

2011 онд компани анх байгуулагдаж, үйл ажиллагаа дөнгөж эхэлж байх үед бид даатгалын салбарын топ компани болох вижн дэвшүүлсэн юм. Салбарын топ компани нь зөвхөн ашиг орлого, хөрөнгөөрөө тэргүүлэгч байгаад зогсохгүй салбартаа шинэ стандарт, шинэлэг ёс суртахууныг нэвтрүүлэгч байх ёстой гэдэгт бид итгэдэг.

Тэгвэл өнөөдөр буюу 10 жилийн дараа бид бүхий л үзүүлэлтээрээ даатгалын салбарын топ компани болж чаджээ. Үүний баталгаа болгож ганцхан жишээ хэлэхэд, Мандал даатгал нийгэмд эрсдэлийн боловсролыг түгээх тал дээр ямар ч компанийн хийж чадаагүй их ажлыг нугалсан байна. Бидний энэ амжилтын нууц бол ашиг орлогоос илүүтэй нийгэм, улс орондоо оруулах хувь нэмэртээ түлхүү анхаарал хандуулж ирсэнтэй салшгүй холбоотой билээ.

Монгол Улсын иргэд төдийгүй компаниуд эрсдэл багатай орчинд ажиллаж, амьдрах

нөхцөлийг бүрдүүлэх явдал бол бидний мишн мөн.

Ирэх 10 жилд бид даатгалын салбараас хальж улсынхаа нийт компаниудын ёс суртахууны үнэлэмж, нийгэмд оруулах хариуцлагын үлгэр жишээ нь болж, шинэ стандартыг тогтоох ажлыг хийх болно.

Монгол Улсыг хэн нэгэн сайд эсвэл дарга биш, харин иргэдийнхээ өмнө сайн дураар өөрийнхөө бизнесийн үйл ажиллагаанаас давсан хариуцлага хүлээж чаддаг хүнлэг, том амбицтай компаниуд хөгжүүлж чадна. Мандал даатгал өнгөрсөн хугацаанд зорьсондоо хүрч, зорилгоо биелүүлдэг гэдгээ нотлон харуулсан учраас бид 10 жилийн ойгоо бахархал дүүрэн тэмдэглэж байна.



ВИЖН

Азийн тавцанд өрсөлдөх даатгал, санхүүгийн олон улсын брэндийг бий болгох

Мандал даатгал үүсгэн байгуулагдсанаасаа хойш харьцангуй богино хугацаанд салбартаа тэргүүлэгч даатгалын компани болсон төдийгүй Мандал даатгалын алсын хараа нь зөвхөн Монголын шилдэг даатгалын компани болсноор хязгаарлагдахгүй, Азийн орнуудын зах зээлд гарч өрсөлдөх Монгол брэндийг бий болгох явдал юм.

МИШН

Өнөөдрөө баталгаажуулсан маргаашийг иргэн бүрд

Даатгалын компанийн нийгэмд оруулж буй хамгийн том хувь нэмэр нь иргэдийг гэнэтийн эрсдэлээс үүдэн бий болох санхүүгийн хохиролд өртөхөөс хамгаалж, амьдралын хэмнэлийг нь баталгаажуулах явдал юм.

Мандал даатгал нь хувь хүн, өрх гэр, албан байгууллага тус бүр өнөөдрийг хүртэл бий болгосон өөрийн баялгийг тулгарч болох эрсдэлээс хамгаалан, маргаашийнхаа зорилгын төлөө ажиллаж, амьдардаг сайхан нийгмийг даатгалаараа дамжуулан бүтээхийг зорьдог.

БАТСАЙХАНЫ ЖАВХЛАН

Гүйцэтгэх захирал



“

Бүтэн жил гаруй
үргэлжилсэн хөл хориог
бид бэрхшээл бус
харин бүтээгдэхүүн,
үйлчилгээний
чанар, хүртээмжийг
нэмэгдүүлэх,
ажилтнуудын ур
чадварыг дээшлүүлэх,
бүтээмжийг өсгөх
боломж гэж үзсэн.

ЭРХЭМ ХҮНДЭТ ХАРИЛЦАГЧ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ХАМТРАН АЖИЛЛАГЧ ТҮНШҮҮД ЭЭ

Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Мандал даатгалын 2020 оны үйл ажиллагаа, үр дүнгээ тайлагнах ялдамд та бүхэнтэйгээ нүүр бардам учран золгож байгаадаа баяртай байна.

2020 онд дэлхий дахины онцлох гол сэдэв бол Ковид-19 цар тахал байлаа. Халдварыг бууруулах, тархалтыг зогсоох зорилготой олон нийтийг хамарсан хөл хорио, улс хоорондын хил, гаалийн хориг ба түүнээс үүдсэн гадаад худалдааны тогтворгүй байдал зэргээс хамаарч эдийн засаг хямарч иргэд, бизнес эрхлэгчдэд сөргөөр нөлөөлсөн, сорилт бүхий хүнд жил болж өнгөрлөө. Нийслэл хотод жилийн хагаст нь буюу таван сар гаруй хугацаанд хөл хорио тогтоосон үед бидний борлуулалт бууралттай, зарим үед бүрэн зогссон байдалтай байлаа. Гэхдээ Мандалчууд бид энэ цаг хугацааг зогсолт биш, боломж гэж үзэн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, ажилчдын ур чадвар болон хүртээмжийг дээшлүүлэх, автоматжуулалтыг нэмэгдүүлэн бүтээмжийг өсгөх ажлуудыг маш амжилттай гүйцэтгэн ард нь гараад байна. Хөл хорионоос шалтгаалан цахим шилжилтэд эргэлт буцалтгүй орсноор 4-р улирлын нөхөн төлбөрийн 70 хувийг цахимаар шийдвэрлэжээ. Төлөвлөгөөний дагуу чухал, нэн шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэсний үр дүнд даатгалын хураамжийн орлого өмнөх оноос 15 хувиар өсч 33.2 тэрбум төгрөгт хүрлээ. Хямралын үед зах зээлд шинэ боломжууд гарч ирдэг. Эдгээр боломжийг үнэлэн эрсдэлийн удирдлагыг оновчтой хийснээр хөрөнгө оруулалтын орлого өмнөх жилээс 47 хувиар өсч 5.5 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна. Энэ бүхний үр дүнд цэвэр ашиг 4.5 тэрбум төгрөгт хүрч өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 21 хувь байлаа.

Монголын даатгалын салбарт анх удаа олон улсын үнэлгээний байгууллагаар үнэлүүлсэн нь 2020 оны Мандалын хамгийн онцлууштай үйл явдал боллоо. Олон улсын үнэлгээний AM Best агентлаг нь Мандалын санхүүгийн чадавх В, урт хугацааны зээлжих зэрэглэл “BB+” гэж үнэлжээ. Энэхүү үнэлгээ нь жилийн турш хийгдсэн маш урт үйл явц байсан ба

Мандал даатгалыг олон улсын стандартын дагуу даатгалын үйл ажиллагаа явуулдаг, найдвартай, нөхөн төлбөр төлөх чадамжтай гэдгийг батламжиллаа.

2021 онд компанийн маань 10 жилийн ой тохиож байна. Анх тогтсон зах зээлд үйл ажиллагаагаа эхлүүлэн “харилцагч бүрийг эрсдэлийн удирдлагын мэдлэгтэй болгож тохирсон бүтээгдэхүүнийг санал болгох” зорилго тавьж ажиллаж эхэлсэн. Өнөөдөр энэ зорилгоо биелүүлж Монгол Улсад эрсдэлийн удирдлага, боловсролыг түүчээлэн түгээж чадсан байна. Үүний үр дүнд олон нийтийн эрсдэлийн боловсрол дээшилж, Мандалын харилцагчийн тоо нэмэгдэн, санхүүгийн чадавх бэхжиж салбартаа тэргүүлэгч даатгалын компани болж чадсан юм. Харилцагч, хамтрагч та бүхэндээ чин сэтгэлээсээ талархал илэрхийлье.

Мандалын өнөөдрийг хүртэл бий болгосон зүйлс, амжилтаар миний бие бахархдаг бөгөөд биднийг ирээдүйд илүү том сорилт, амжилтууд хүлээж байгаа гэдэгт итгэдэг. Хөгжиж буй бусад улс оронтой харьцуулахад Монголчуудын эрсдэлийн талаарх ойлголт дутмаг, даатгалд хамрагдах сэдэл бага байдаг нь нууц биш. Эрсдэлийн удирдлага, түүнийг шилжүүлэн авдаг даатгал гэдэг механизмыг ашиглан бизнесүүдийн үйл ажиллагааг хэвийн явуулах, тэдний бий болгосон капиталыг хамгаалах, иргэдийн хувьд дундаж давхаргыг эрсдэл тохиолдсоны улмаас ядууралд нэрвэгдэхээс сэргийлэх ажлуудыг системтэйгээр, улсын түвшинд бодлоготойгоор хэрэгжүүлэх нэн шаардлагатай. Энэ үйл хэрэгт бид салбарын тэргүүлэгчийн хувиар хариуцлага хэмээн хүлээн авч оройлон оролцоно.

Цар тахлаас хамаарсан тодорхойгүй байдал дуусаж, эдийн засаг эргэн сэргэсэн сайхан цаг удахгүй ирнэ гэдэгт итгэлтэй байна. Хамтдаа давна!



“ЭРСДЭЛ МИНИЙ НҮДЭЭР” зургийн уралдаан,
Мандал Эрсдэлийн Сургуулийн сурагч Э.Содбилэг, 9 настай



02

СТРАТЕГИЙН
ТАЙЛАН

ЧҮЛТЭМИЙН ДАВААДАШ

Ерөнхийлөгч

“

Бид шилдэг нь байх, сайхан бүхнийг бусадтай хуваалцан, сайн үр дүн гаргахыг Мишн болон Вижн, Үнэт зүйлсдээ тусган ажилладаг.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

Мандал даатгал ХК-ийн нийт харилцагч, хувьцаа эзэмшигчид болон хамтран ажиллагсад та бүхэндээ Мандал даатгалын 10 жилийн ойн мэндийг хүргэе!

Мандал даатгал ХК нь Монгол Улсын даатгалын салбар болон хөрөнгийн зах зээл, цаашлаад Монгол Улсын бизнесийн талбарт шинэлэг арга барил, шилдэг менежмент, шинэ нүүр царай болохыг зорьж ажилладаг бөгөөд эдгээр зорьсон зүйлсээ дүгнэж цэгнэн, тайлагнаж буй энэ үед миний бие удирдлагын багийн нэгэн гишүүн байж энэхүү мөчийг та бүхэнтэйгээ хуваалцаж байгаадаа туйлын баяртай байна.

Мандал даатгал ХК бол үйл ажиллагаагаараа мянга мянган харилцагч болон хувьцаа эзэмшигчийнхээ итгэл сэтгэлийг тээн ажилладаг. Энэ утгаараа аливаад шилдэг нь байж, сайн үр дүн, сайхан бүхнийг бусадтайгаа хуваалцаж явах ёстой гэдгийг манай компанийн удирдлагын баг болон залуучууд сэтгэл зүрхэндээ ухамсарлан, хичээн ажилладаг билээ. Бид шилдэг нь байх, сайхан бүхнийг бусадтай хуваалцан, сайн үр дүн гаргахыг өөрийн Вижн, Мишн, Үнэт зүйлсдээ тусгадаг. "Өнөөдрөөр баталгаажуулсан маргааш"-

ийг иргэн бүрт хүргэн (Мишн), Азийн тавцанд өрсөлдөх даатгал санхүүгийн олон улсын брэндийг бий болгохыг (Вижн) зорин ажиллахдаа "Нэг баг-Нэг Мандал" гэдгээ ухамсарлан, Үргэлж түүчээлэн, Харилцагчаа дээдлэн, Үйл хэрэгтээ тууштайгаар (Үнэт зүйлс) ажиллаж байна. Бид хаа хүрэх, хэрхэн хүрэхээ Вижн, Мишн, Үнэт зүйлсдээ зүгээр нэг томьёолоод орхих биш эдгээр зүйлсээрээ "амьсгалан", ажил хэргээ баримжаалах "луужин" нь болгож чаддаг учраас өнөөдрийн бидний амжилт болон та бүхэндээ хуваалцах туршлагууд бий болсон гэж үздэг.

Бид хэрхэн зорилго, үнэт зүйлсээрээ амьсгалж, жинхэнэ утгаар үнэт зүйлс бүхий хамт олныг бий болгож буй талаар манай үйл ажиллагааны болон бусад тайлан мэдээллүүдээс сонирхох бүрэн боломжтой.

Та бүгдийн хамт дараа дараагийн олон арван жилийн түүхийг бичилцэн, хамтдаа хөгжин урагшилна гэдэгт итгэл төгс байна.




Нэг баг, Нэг
Мандал



Үргэлж
түүчээл



Үйл хэрэгтээ
тууштай бай



Харилцагч
нэн тэргүүнд



САНХҮҮГИЙН ҮР ДҮН

“ Мөнгөн урсгалын менежментийг сайжруулж, капиталын үр ашгийг дээшлүүлэх замаар компанийн үнэ цэнийг хамгийн дээд хэмжээнд байлгахыг зорьж байна.



САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран хүчин зүтгэгсэд та бүхэндээ 10 жилийн ойн мэндийг дэвшүүлье!

Мандал даатгал нь байгуулагдсан цагаасаа бизнесийн цар хүрээгээ амжилттай тэлсээр өдгөө Монголын даатгалын салбарт нийт хөрөнгийн хэмжээгээр тэргүүлэгч компани болж чаджээ. Түүгээр зогсохгүй ашигт ажиллагааны түвшингээр салбараа манлайлж, ашгийн хэмжээгээр сүүлийн гурван жил тасралтгүй тэргүүлээд байна.

Бид мөнгөн урсгалын менежментийг сайжруулж, капиталын үр ашгийг дээшлүүлэх замаар компанийн үнэ цэнийг хамгийн дээд хэмжээнд байлгахыг зорилго болгон ажилладаг.

Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг оновчтой удирдаж, компанийн үнэ цэнийг өндөрт байлгах нь бидний үүрэг билээ. Мөн зөвхөн ашигт ажиллагааг нэмэгдүүлэхээс гадна, хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх замаар мөнгөн урсгалыг хамгийн өндөрт байлгах нь чухал үүрэгт тооцогдоно. Мандал даатгалын хамт олон 2020 онд нийт 7.5 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг үйл ажиллагаанаас бий болгож мөнгөн хөрөнгийн хэмжээг 33.6 тэрбум төгрөгт хүргэлээ.

2019 оны сүүлээс дэлхий дахиныг гамшигт автуулаад буй аюулт цар тахал манай оронд ч хүчтэй нөлөөлж, зөвхөн Мандал даатгалаар зогсохгүй хувь болон төрийн хэвшлийн байгууллагуудын хариу арга хэмжээ болон чадамжийг шалгасаар 2020 оныг үдлээ. Хэцүү бэрх энэ үед хувьцаа эзэмшигчдийн итгэл, ТУЗ, баг хамт олны хүчээр бид нөхцөл байдалд тохирсон арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэн, бүх талын эрх ашгийг боломжит хамгийн өндөр түвшинд хүргэн ажиллаж чадлаа. 2020 онд компанийн цэвэр ашиг 4.5 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашгийн 41 хувийг ногдол ашигт хуваарилахаар шийдвэрлэсэн. Компанийн өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшин 21 хувьд хүрч, өнгөрөгч оноос буурсан хэдий ч инфляц, банкуудын хадгаламжийн хүү, нээлттэй хувьцаат компаниуд болон өрсөлдөгч компаниудаас өндөр түвшинд хэвээр байна.

Компани санхүүгийн чадавхыг бүх талаар сайжруулж, компанийн урт хугацааны зорилтыг 2020 онд бодит болгож чадлаа.

Манай баг, хамт олон жилээс жилд үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулахын зэрэгцээ амжилтаа ахиулж, өмнөх ололтуудаа улам бататгаж, зөвхөн Монгол Улсын хэмжээнд өрсөлдөх бус бүс нутаг, цаашлаад дэлхийн хэмжээний компаниудын жишиг үзүүлэлтэд хүрэхийн тулд санхүүгийн чадавхаа бүх хүрээнд сайжруулж ирсэн. Энэхүү зорилго маань 2020 онд үр дүнгээ өгч бид Монгол Улсдаа анхны олон улсын үнэлгээтэй ердийн даатгалын компани болж чадлаа. Энэ бол манай компанийн санхүүгийн чадавхын үзүүлэлтүүд олон улсын түвшинд хүрэхүйц сайн гэдгийг бататгасан хэрэг байлаа. Бид сахилга бат, зохион байгуулалт, оюун ухааны чадамжаараа дэлхийн хэмжээний компанийг байгуулна гэсэн үүсгэн байгуулагчдын 10 жилийн өмнө харсан зорилтыг өдгөө бодит болгож чадсан хэмээн харж байна.

AM Best агентлаг олон улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг Монголын эдийн засгийн нөхцөл байдал, бизнесийн орчноос гадна, тухайн компанийн балансын чадавх, стратеги, эрсдэлийн удирдлагын тогтолцооны түвшинг тус бүрчлэн үнэлэн тогтоодог. Мандал даатгалын хувьд санхүүгийн эерэг өсөлтүүд болон өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай түвшинд байгаа нь өндөр үнэлгээ авахад нөлөөлсөн гэж дүгнэж байна. Санхүүгийн тогтвортой "BB+" үнэлгээ авсан нь цаашид ч компанийн санхүүгийн үзүүлэлтүүд өндөр хэвээр хадгалагдана гэдгийг нотлон харууллаа.

Бүх цаг үед эрсдэлийг таньж, удирдаж бидэнд итгэдэг эрхэм харилцагчид болон компанийг бүтээлцэж буй хувьцаа эзэмшигчид та бүхэндээ талархаж байна.



Г.ХАЛИУНАА

Санхүү хариуцсан захирал

АШИГТ АЖИЛЛАГАА: МАНДАЛ ДААТГАЛ БА ДААТГАЛЫН САЛБАР

Ердийн даатгалын компаниудын дундаж ашгийн хэмжээ болон даатгалын салбарын 82 хувийг эзэлдэг ТӨП 7 компанийн дундаж ашгийг харьцуулбал Мандал даатгал нь ашгийн хэмжээгээр салбартаа тэргүүлж байна.


ЦЭВЭР АШИГ, тэрбум төгрөг



Төп 7 ердийн даатгалын компани: Мандал даатгал ХК, Бодь даатгал ХХК, Монгол даатгал ХХК, Миг даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Тэнгэр даатгал ХХК болон Ард даатгал ХК

Салбарын дундаж түвшинтэй харьцуулахад Мандал даатгал өөрийн хөрөнгийн өгөөжийн түвшингээр өндөр байгаа нь капиталын удирдлага, хөрөнгийн ашиглалт зөв зохистой байгааг илтгэнэ.

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ, хувиар



САНХҮҮГИЙН ГОЛЛОХ ҮР ДҮН, 2020



Дундаж өсөлт: Жилүүдийн нийлмэл өсөлтийн хувь (CAGR). Нийт хугацааны туршид жил тутамд дунджаар хэдэн хувиар өссөн болохыг хэмжих үзүүлэлт.

НИЙТ ХӨРӨНГӨ

2020 онд нийт хөрөнгийн хэмжээ 55.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 14.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Тус өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь даатгалын үйл ажиллагаа, цэвэр ашиг, нөхөн төлбөрийн нөөц сангийн өсөлтүүд юм. 2020 онд бид даатгалын салбартаа нийт хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хэмжээгээр тус тус тэргүүлж байна. Компани анх байгуулагдахдаа 6.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 10 жилийн турш, жилд дунджаар 27 хувийн өсөлттэйгөөр үйл ажиллагаагаа өргөжүүлсээр иржээ.

МӨНГӨН ХӨРӨНГӨ

2020 онд мөнгөн хөрөнгийн хэмжээ 33.6 тэрбум төгрөгт хүрч түүхэн амжилт тогтоолоо. Энэ нь өмнөх оноос таван тэрбум төгрөг буюу 18 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. 2011 оноос жилд дунджаар 21 хувийн өсөлттэй ажиллаж, хөрөнгө оруулалтын хэмжээгээр салбартаа тэргүүлж, Монголын хөрөнгийн зах зээл дээр мэргэжлийн хөрөнгө оруулагчийн үүргээ нэр төртэй гүйцэтгэсээр байна. Бидний өнөөдрийн амжилтад 2018 онд компанийн нийт хувьцааны 25 хувийг олон нийтэд санал болгон анхдагч зах зээлд арилжаалж, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлсэн нь голлох нөлөө үзүүлсэн билээ.

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО

2020 онд Монголын эдийн засаг 5.3 хувиар агшсан боловч даатгалын салбар гурван хувийн өсөлттэй байв. Мандал даатгалын хувьд нийт хураамжийн орлого 33.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15 хувиар өсчээ. Мөн нийт хураамжийн орлогын хэмжээгээр даатгалын зах зээлд эзлэх хувиа хоёр нэгж хувиар ахиулж, 17 хувьд хүргээд байна.

Мөн анх байгуулагдсан үеийн жилийн орлогоос 64 дахин их орлогыг төвлөрүүлэн ажиллажээ. Үүнийг жилийн дундаж өсөлтөөр авч үзвэл 59 хувь бөгөөд салбарын дундаж өсөлттэй харьцуулахад (салбарын дундаж өсөлт 17 хувь) 42 нэгж хувиар өндөр байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЛОГО

Хөрөнгө оруулалтын орлого 5.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 47 хувиар нэмэгдсэн. Мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлага, хөрөнгө оруулалтын оновчтой багцын бодлого бол хөрөнгө оруулалтын орлогод нөлөөлөгч гол хүчин зүйлс юм. 2020 оны тухайд хөрөнгө оруулалтын эрсдэлийн удирдлагыг төгөлдөржүүлэх тэр дундаа хөрөнгө оруулалтын багцыг богино хугацаатай, зээлжих зэрэглэл сайтай, тогтмол орлоготой хэрэгслүүдэд байршуулсан нь хөрөнгө оруулалтын орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлжээ.

НӨХӨН ТӨЛБӨР

Бид харилцагчдаас хүлээн авсан эрсдэлийн багцын үлэмж хэсгийг олон улсын давхар даатгалын зах зээл дээр байршуулж ажилладаг билээ. Ингэснээр, компанийн төлбөрийн чадварыг хамгаалж, харилцагчдын нөхөн төлбөр найдвартай, баталгаатай төлөгдөх нөхцөлийг бүрдүүлдэг. 2020 онд нийт 7.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон ба өмнөх оноос 45 хувиар буюу 2.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Үүнээс давхар даатгалын хариуцсан нөхөн төлбөр 640 сая төгрөг байна.

НӨХӨН ТӨЛБӨРИЙН НӨӨЦ САН

Нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ өмнөх оноос 1.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 6.4 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнд хохирлын харьцаа 42 хувьд хүрч нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна. 2011 оноос нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээг хохирлын харьцааны гүйцэтгэлтэй уялдаатайгаар жилд дунджаар 67 хувиар нэмэгдүүлсэн бол, нөөц сангийн хүрэлцээний түвшин 1.9 буюу хангалттай түвшинд байна.

ЦЭВЭР АШИГ

2020 онд компанийн цэвэр ашиг 4.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэйгээр тайланд тусгагджээ. Цэвэр ашгийн үзүүлэлтэд хөрөнгө оруулалтын орлого өмнөх онтой харьцуулахад 47 хувиар өссөн нь эерэг нөлөө үзүүлсэн байна. Ийнхүү ашгийн үзүүлэлтээр салбараа дахин тэргүүлжээ. Компанийн цэвэр ашгийн үр дүн, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн нэгж хувьцаанд гурван төгрөг буюу нийт 1.8 төгрөгийн ногдол ашгийг 2021 онд тараахаар шийдвэрлэсэн.

Компанийн үйл ажиллагааны үр дүн сүүлийн зургаан жилийн хугацаанд тогтмол эерэг үзүүлэлттэй гарсан ба цэвэр ашгийн дундаж өсөлт 33 хувь байна. Харилцагч төвтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааны энгийн загварчлал, андеррайтинг болон хөрөнгө оруулалтын багцын оновчтой бодлого нь компанийн ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлсээр иржээ.

НИЙЛМЭЛ ХАРЬЦАА


2020 онд нийлмэл харьцаа 95 хувьд хүрсэн. Тус харьцаа буурах тусам ашигт ажиллагаа сайжирдаг. Өмнөх онд салбарын дундаж нийлмэл харьцаа 99 хувь ба Мандал даатгал тус түвшингээс дөрвөн нэгж хувиар бага байгаа нь ашигт ажиллагаа сайн байгааг илтгэж байна. 2015 оноос ашигт ажиллагааг тасралтгүй сайжруулж ирсэн хэдий ч 2020 онд нөхөн төлбөрийн өсөлттэй уялдаатайгаар 22 нэгж хувиар нэмэгдсэн.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ХАРЬЦАА

Төлбөрийн чадварын харьцаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх болон ирээдүйд учрах томоохон эрсдэлийг даахад хүрэлцэхүйц хөрөнгөтэй эсэхийг харуулдаг үзүүлэлт билээ. Мандал даатгалын хувьд энэхүү үзүүлэлт сүүлийн таван жилийн хугацаанд тогтвортой сайжирч байгаа нь компанийн суурь чадавх ирээдүйн өндөр өсөлтөд бэлэн гэдгийг илтгэж байна. 2020 оны тайлангаар төлбөрийн чадварын харьцаа 161 хувьтай гарсан нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тавигдах шаардлагыг хангасан үзүүлэлт юм.

АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“ Андеррайтингийн үйл ажиллагааг автоматжуулах нь бидний дараагийн 5 жилийн тэргүүн зорилт байх болно. Бид даатгуулагчийн эрсдэлийг үнэлэх, тухайлсан даатгалын үнэ тооцоолох зэрэгт хиймэл оюун ухаан ашигладаг болохоор зорьж байна.



ДААТГАЛЫН БОДЛОГО ХАРИУЦСАН ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Мандал даатгалд итгэж эрсдэлээ шилжүүлэн хамтарч ажиллаж байгаа даатгуулагч нартаа энэ өдрийн мэнд хүргэе!

Мандал даатгал нь салбарынхаа тэргүүлэгч компанийн хувьд салбарын цаашдын хөгжил, ирээдүйд андеррайтингийн үйл ажиллагаагаараа дамжуулан хувь нэмрээ оруулсаар ирсэн билээ. Даатгалын компаниуд чадавхжин, хүрээгээ тэлж, хөгжихийн тулд эрсдэл үнэлэх, эрсдэлд таарсан хураамж, нөхцөл тооцоолох андеррайтингийн үндсэн чадавхыг бий болгож хөгжүүлэх нь нэн чухал юм. Бид энэхүү чадавхыг үе шаттайгаар бий болгож, хөгжүүлж ирсэн ба 2020 онд гурван төрлийн эрсдэл үнэлэх аргачлал болон эрсдэлийн үнэлгээ хийх инженерийн мэргэжлийн багийг бүрдүүлсэн нь том амжилт байлаа.

Үүнээс гадна бид өөрийн чадах хэмжээнээс хэтэрсэн, гэнэтийн эрсдэл нэг бүрийг дэлхийн шилдэг давхар даатгагчид болох SCOR, HANOVER RE, AXA руу автоматаар шилжүүлэхээр тохиролцож, Трити давхар даатгалын гэрээ байгуулан ажиллаж байна.

AM Best олон улсын үнэлгээний агентлаг Мандал даатгалын андеррайтингийн болон давхар даатгалын үйл ажиллагааны бодлого, процесс, дэд бүтцүүдийг нарийн шалгасны үндсэн дээр компанийн ирээдүйн төлөвт “B” үнэлгээ өгсөн ба энэ нь компанийн андеррайтингийн үйл ажиллагаа олон улсын стандарттай нийцэж байгааг илэрхийлсэн чухал үр дүн байлаа. Өөрөөр хэлбэл, олон улсын хөндлөнгийн үнэлгээний байгууллага Мандал даатгалын санхүүгийн болон андеррайтингийн үйл ажиллагаанд эерэг дүн тавьсан гэсэн үг.

Бид ирэх жилүүдэд Мандал даатгал болон даатгалын салбарын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн, илүү өндөрт хүргэхийн төлөө тууштайгаар хичээнгүйлэн ажиллах болно.



Ж.ГАРВАА

Даатгалын бодлого хариуцсан захирал

Мандал даатгал нь 2019 оны 10 дугаар сард “AM Best”-ийн A+ үнэлгээтэй Францын давхар даатгагч “SCOR”-той Трити давхар даатгалын гэрээ байгуулсан. SCOR нь 1970 онд үүсгэн байгуулагдсан, 160 гаруй улсад давхар даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, дэлхийд дөрөвдүгээрт ордог том давхар даатгагч юм.



АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зөв эрсдэлийн багц бүрдүүлэх

Мандал даатгал ХК нь өөрийн Андеррайтингийн бодлогын хүрээнд даатгалын бүтээгдэхүүн бүрийг дараах гурван үндсэн шалгуураар үнэлж, бүтээгдэхүүний зөв багцыг бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Үүнд:

- Зах зээлийн багтаамж
- Хохирлын харьцаа
- Андеррайтингийн туршлага зэрэг багтана.

Зөв эрсдэлийн багц бүрдүүлэх нь нэг талаас компанийн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, нөгөө талаас даатгуулагчдад нөхөн төлбөрийг түргэн шуурхай, найдвартай олгоход чиглэж буй юм.

Даатгалын болон эрсдэл бууруулах инженерийн шийдэл санал болгох

Манай мэргэжлийн инженерийн баг даатгуулагчийн эрсдэлийг үнэлж үзсэний үндсэн дээр тухайлсан даатгалын шийдэл болон даатгуулагчийн эрсдэлийг бууруулах аргачлал, төлөвлөгөөг боловсруулж санал болгож байна. Улмаар даатгуулагчийн болон компанийн аль алиных нь эрсдэл буурч харилцан өгөөжтэй, хамтран ажиллах үндэс бий болох юм.

Олон улсын стандартыг нутагшуулах, андеррайтингийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх

Бид 2018 оноос голлох даатгалын бүтээгдэхүүнүүдийн гэрээг Lloyds', Munich Re зэрэг олон улсад даатгалын гэрээний стандарт тогтоогч мэргэжлийн оролцогчдын туршлага болон Монголын даатгалын зах зээлийн онцлог, шинж чанарт нийцүүлэн шинэчлэх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар 11 стандарт бүтээгдэхүүнтэй болсон байна. Үргэлжлүүлэн олон улсын туршлагатай андеррайтеруудтай хамтарч андеррайтингийн үйл ажиллагааг автоматжуулах чиглэлд ажиллаж байна.

Даатгуулагчийн эрсдэлийг найдвартай Давхар даатгагч нарт хуваарилах

Даатгалын бизнес нь эрсдэлийг үнэлэх, шилжүүлэх, удирдах механизм юм. Тиймээс, бид өөрсдийн дааж чадах хэмжээнээс давсан эрсдэлийг санхүүгийн чадавх өндөртэй буюу AM Best, Standard & Poors (S&P) зэрэг олон улсын үнэлгээний агентлагуудаас А болон түүнээс дээш үнэлгээ авсан Давхар даатгагчид руу шилжүүлэн ажиллаж байна.

АНДЕРРАЙТИНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮН

Мандал даатгал нь 2020 онд харилцагчийн тоог өмнөх оноос 1,698-аар нэмэгдүүлж 82,902 харилцагчтай хамтран ажилласан ба тоогоор илэрхийлбэл доорх үр дүн гарсан байна.

Санхүүгийн үзүүлэлтүүд, сая төгрөг	2019	2020
Нийт гэрээний тоо	115,260	125,141
Нийт хураамжийн орлого	28,927	33,225
Нийт нөхөн төлбөрийн дүн	5,423	7,862
Хохирлын харьцаа	27%	42%
Хийсэн эрсдэлийн үнэлгээний тоо	-	21

ОНЦЛОХ ӨӨРЧЛӨЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ

Эрсдэлийн удирдлагын үйлчилгээ

Бид өнгөрсөн 10 жилийн хугацаанд 20 сая төгрөгөөс дээш хохирол бүхий 250 гаруй томоохон гал, цахилгаан, сантехник, үйлдвэрлэлийн ослын тохиолдлууд дээр ажиллаж, нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Бид энэхүү туршлага дээрээ үндэслэн, гадна дотнын стандартуудад нийцүүлэн даатгуулагчийн эрсдэлийг үнэлэх аргачлалуудыг боловсруулсан. Улмаар 2020 оноос харилцагч нартаа даатгалын бүтээгдэхүүнээс гадна эрсдэлийн удирдлагын цогц үйлчилгээг санал болгон ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээний аргачлалыг нийцүүлсэн стандартууд:

1. MNS ISO 31010:2011 "Эрсдэлийн Менежментийн Стандарт"
2. Монгол Улсын хөдөлмөрийн сайдын тушаалаар батлагдсан "Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж"
3. Олон улсад эрсдэлийн үнэлгээ, удирдлагын үйлчилгээ үзүүлэгч FM Global, Cunningham Lindsey зэрэг компаниудын арга аргачлал

Бидний туршлага

- 2011** • Мандал даатгал үүсгэн байгуулагдав.
- 2012** • Эрсдэлийн удирдлагын үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.
- 2019** • Эрсдэлийн удирдлагын инженерийн багтай болов.
- Эрсдэлийн удирдлагын шинэ аргачлал нэвтрүүлэв.
- 2020** • Нийт 21 объектод Эрсдэлийн үнэлгээ хийж, зөвлөмж гаргав.

Даатгуулагч нарт санал болгож буй эрсдэлийн удирдлагын үйлчилгээнүүд:

01 Эрсдэлийн үнэлгээ хийж зөвлөмж өгөх

- Хөрөнгийн эрсдэлийн үнэлгээ
- Тоног төхөөрөмжийн эрсдэлийн үнэлгээ
- Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ

02 Эрсдэлээс урьдчилан сэргийлэх сургалт

- Галаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- Цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдал
- Хөдөлмөрийн аюулгүй байдал

03 Эрсдэл бууруулах ажлыг удирдан зохион байгуулах

- Эрсдэл бууруулах ажлын төсвийн тооцоолол, судалгаа
- Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийн хяналт
- Гүйцэтгэлийн дараах явцын хяналт

Эрсдэлийн удирдлагын үйлчилгээ үзүүлж буй инженерийн баг

Эрсдэл хөрөнгө үнэлгээний менежер	Нөхөн төлбөрийн менежер
Электроник инженер, хөргөлт агаар сэлгэлтээр мэргэшсэн, Цахилгааны 4-р зэрэгтэй, инженерийн 15 жилийн ажлын туршлагатай	Хөдөлмөр аюулгүй байдлын инженерээр мэргэшсэн, хөрөнгийн даатгалын нөхөн төлбөрийн чиглэлээр 10 жилийн ажлын туршлагатай
Зөвлөх	Зөвлөх
ХАБЭА сургагч болон зөвлөх багш, 18 жилийн ажлын туршлагатай	Монгол Улсын зөвлөх инженер, Галын аюулгүй байдлын инженерээр мэргэшсэн, 30 жилийн ажлын туршлагатай

Эрсдэлийн үнэлгээ хийсэн байгууллагууд

2020 онд 300 орчим тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 21 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэл бууруулах зөвлөмж хүргүүлж хамтарч ажилласан байна.



Даатгуулагчид тухайлан зориулсан даатгалын хураамж тооцох моделиуд

Бид даатгуулагч тус бүрийнхээ эрсдэлийг бодитойгоор үнэлж, тухайн эрсдэлд нь тохирсон даатгалын бүтээгдэхүүн санал болгодог ба 2020 онд даатгалын хураамж тооцох автомат моделиудыг боловсруулснаар даатгуулагч тус бүрд газар дээр нь тухайлан зориулсан даатгалын хураамж буюу үнэ санал болгох боломжтой болсон.


Хураамж тооцох моделиуд:

1. Үл хөдлөх хөрөнгийн даатгал
2. Тээврийн хэрэгслийн даатгал
3. Машин механизмын даатгал
4. Гэнэтийн ослын даатгал
5. Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал
6. Эрүүл мэндийн даатгал
7. Тоног төхөөрөмжийн даатгалууд багтана.

Эдгээр хураамж тооцох моделиуд ашиглалтанд орсноор даатгагчийн андеррайтингийн чадавх сайжирч даатгуулагчдад чанартай, найдвартай даатгалын үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх боломж улам бүр нэмэгдэж байна.


БАГЦЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ДАВХАР ДААТГАЛ

Андеррайтингийн модель



Багцын төвлөрөл ба андеррайтингийн туршлага

БАГЦЫН БҮРДЭЛ



● Авто тээврийн хэрэгслийн даатгал	29%
● Эрүүл мэндийн даатгал	28%
● Хөрөнгийн даатгал	17%
● Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	10%
● Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	6%
● Хариуцлагын даатгал	5%
● Ачааны даатгал	2%
● Агаарын хөлгийн даатгал	1%
● Бусад даатгал	1%
● Гадаад зорчигчийн даатгал	1%

Бид өөрсдийн андеррайтингийн туршлага, давуу талд үндэслэн бүтээгдэхүүний багцаа бүрдүүлсээр ирсэн. Автотээврийн хэрэгслийн даатгал, хөрөнгийн даатгал, эрүүл мэндийн даатгал нь голлох гурван бүтээгдэхүүн бөгөөд дараах байдлаар ялгарах онцлогийг тайлбарлая.

1. Автотээврийн хэрэгслийн даатгал

- Эрсдэл, хамгаалалтын хэмжээгээ сонгох боломж бүхий хувилбарт бүтээгдэхүүнүүд
- Эрсдэл багатай харилцагчийг урамшуулах систем
- Баталгаат засварын сүлжээ
- Эрсдэлд суурилсан үнэ тооцоолол
- Технологид суурилсан нөхөн төлбөр шийдвэрлэлт (“Мандал” аппликейшнээр)

- зайнаас ослын үзлэг баримтжуулалт, нөхөн төлбөрийн материал бүрдүүлэлт хийх)
- Тээврийн хэрэгслийн осол, хохирлын шалтгаан тодорхойлох гэрээт экспертүүд

2. Хөрөнгийн даатгал

- Олон улсын стандартад нийцүүлэн гаргасан бүтээгдэхүүн, гэрээний нөхцөл
- Даатгуулагчийн эрсдэлийн түвшинг үнэлэх, эрсдэл бууруулах ажлын зөвлөмж өгөх мэргэжлийн инженерийн баг
- Гал, цахилгаан, сангийн чиглэлийн эрсдэлийн удирдлагын сургалт
- Эрсдэлд суурилсан үнэ тооцоолол
- AM Best, Standard & Poors (S&P) зэрэг олон улсын үнэлгээний агентлагуудаас А болон түүнээс дээш үнэлгээ авсан Давхар даатгалын хамгаалалт

3. Жаргалан эрүүл мэндийн даатгал

- Эрүүл мэндийн даатгалаар мэргэшсэн андеррайтеруудын баг
- Нөхөн төлбөр хариуцсан мэргэжлийн эмч нарын баг
- Монголд хамгийн том эмнэлгийн сүлжээ
- Эмнэлэг дээрх харилцаа, үйлчилгээ хариуцсан тусгай менежер
- Эрүүл мэндийн даатгалын тусгай лавлах төв

Багцын трити давхар даатгал

Компани өөрийн дааж чадах хэмжээнээс давсан харилцагчийн эрсдэлийг автоматаар давхар даатгалд шилжүүлэх зорилгоор багцын трити давхар даатгалын гэрээг байгуулан ажилладаг. Энэхүү гэрээ нь харилцагч нэг бүрийн эрсдэлийг давхар даатгагчидтай харилцан тохиролцож байршуулах бус урьдаас тохирсон нөхцөлүүдийн дагуу эрсдэлийг давхар даатгагчид руу автоматаар шилжүүлэх боломжийг олгодог ороо давуу талтай юм. Компанийн трити давхар даатгалын гэрээний ерөнхий нөхцөлүүдийг дор хүснэгтэд үзүүлэв:

Хөрөнгө болон хариуцлагын трити давхар даатгал, Ам.доллар	Өөрийн хариуцах хэсэг	Нэг зүйлийн хязгаар	Нийт хамгаалалт
Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал			
Мэргэжлийн хариуцлагын даатгал		1,000,000	3,000,000
Хүнд машин механизмын даатгал	200,000		
Ачаа тээврийн даатгал		2,000,000	
Хөрөнгийн даатгал			5,000,000
Барилга угсралтын даатгал		5,000,000	

Даатгалын томоохон асуудал гарсан үед даатгуулагчид нөхөн төлбөрийг түргэн шуурхай олгох нь чухал. Тиймээс бид олон улсын үнэлгээний агентлагуудаас А болон түүнээс дээш үнэлгээ авсан давхар даатгагчидтай трити давхар даатгалын гэрээний хүрээнд хамтарч ажилладаг.

Давхар даатгагч

Олон улсын
үнэлгээ



AA- (S&P)

hannover re

A+ (AM Best)



A+ (ACRA)

Эрүүл мэндийн трити давхар даатгал

Мандал даатгал нь 2020 оноос дэлхийн шилдэг 3 давхар даатгагчийн нэг болох AXA PPP Healthcare Limited-тэй олон улсын болон дотоодын эрүүл мэндийн даатгалууд дээр трити давхар даатгалын гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.



AA- (S&P)

Факультатив давхар даатгалын гэрээгээр даатгасан Топ-10 байгууллага



АНДЕРРАЙТИНГИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хураамжийн орлого

2020 оны 33.2 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлогыг бүтээгдэхүүний төрлөөр ангилж харвал дараах бүтэцтэй байна.

Хураамжийн орлого, даатгалын хэлбэрээр	2019		2020	
	Сая төгрөг	Хувь	Сая төгрөг	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	8,165	28%	8,224	25%
Барилга угсралтын даатгал	6,377	22%	6,585	20%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	6,095	21%	6,472	19%
Хөрөнгийн даатгал	3,711	13%	4,209	13%
Хариуцлагын даатгал	1,234	4%	3,236	10%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	491	2%	1,000	3%
Бусад	2,854	10%	3,499	11%
Нийт	28,927	100%	33,225	100%

Дээрх хүснэгтээс компанийн орлогын бүтэц нэг бүтээгдэхүүн дээр төвлөрөөгүй буюу эрүүл багц бүрдэлтэй байгаа нь харагдаж байна. Өмнөх онтой харьцуулан харвал багцын 28 хувийг бүрдүүлж байсан Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 3 хувь, Барилга угсралтын даатгал, Авто тээврийн хэрэгслийн даатгал тус бүр 2 хувиар буурч харин Хариуцлагын даатгал 6 хувиар нэмэгдсэн нь багцын төвлөрлийг бууруулжээ.

Нөхөн төлбөр

Мандал даатгал нь 2020 онд нийт 13,604 даатгалын тохиолдолд нийт 7.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон бөгөөд даатгалын тохиолдлын тоог даатгалын хэлбэрээр өмнөх онтой харьцуулан харвал дараах байдалтай байна.

Нийт нөхөн төлбөр, даатгалын хэлбэрээр	2019		2020	
	Сая төгрөг	Хувь	Сая төгрөг	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2,275	42%	2,944	37%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,930	36%	2,940	37%
Хөрөнгийн даатгал	273	5%	1,222	16%
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	275	5%	464	6%
Хариуцлагын даатгал	561	10%	254	3%
Бусад	109	2%	38	0%
Нийт	5,423	100%	7,862	100%

2020 онд нийт 7.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн 8 хувь буюу 641 сая орчим төгрөгийг давхар даатгагч, 1 хувь буюу 57 сая төгрөгийг буруутай этгээд, үлдсэн 7.2 тэрбум төгрөг буюу 91 хувийг компани өөрөө хариуцан төлсөн байна.

Багцын хохирлын харьцаа

Компанийн 2020 оны хохирлын харьцаа өмнөх оныхоос 15 хувиар өсч 42 хувьд хүрчээ. Өсөлтийн үзүүлэлтийг даатгалын хэлбэрээр задлан харвал Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, Авто тээврийн хэрэгслийн даатгал, Хөрөнгийн даатгалын хохирлын харьцаанууд өссөн харагдаж байна. Бид 2021 онд хөрөнгийн болон гэнэтийн ослын даатгалын хохирлын харьцааг зохистой түвшинд хадгалахын тулд эрсдэлийн үнэлгээ, эрсдэл бууруулах ажлуудыг даатгуулагч нартай хамтарч хэрэгжүүлэх мөн эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж даатгуулагч нарт санал болгохоор ажиллаж байна.

Хохирлын харьцаа, даатгалын хэлбэрээр	2019	2020
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	26%	39%
Барилга угсралтын даатгал	3%	0%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	38%	61%
Хөрөнгийн даатгал	7%	29%
Хариуцлагын даатгал	21%	7%
Бусад	53%	46%
Нийт	27%	42%


НӨӨЦ САН ТООЦООЛОЛ

Нөөц сан нь томоохон гамшиг, ослоудаас үүдэлтэй хохирлыг даатгалын гэрээгээр тохирсны дагуу барагдуулахад зориулагдсан сан бөгөөд компани урт хугацаанд тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

Мандал даатгал нь СЗХ-ны 2019 оны 1-р сарын 9-ний өдрийн №2 тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн Хавсралт №3, “Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам”-ын дагуу нөөц сангийн тооцооллыг хийдэг ба доорх үр дүнтэй байна. Үүнд:

- 2020 оны эцэст 6.4 тэрбум төгрөгийн нөөц сан байгуулснаас давхар даатгалд ногдох хэсэг нь 768 сая төгрөг байна. 2020 оны нийт нөөц сангийн хэмжээ 2019 оноос 40 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Мөн нөөц сан тооцооллын хүрээнд 2020 оноос эхлэн нөөц сангийн зохист түвшинг тодорхойлж эхэлсэн ба 2020 оны нөөц сангийн хэмжээ хүрэлцээтэй түвшинд байгаа юм.
- Нөөц сангийн хэмжээг 2016 оноос хойш харьцуулан харвал дараах байдалтай байна.

НӨӨЦ САН, тэрбум төгрөг



Нийт нөөц сангийн хэмжээ өнгөрсөн оноос $\Delta 40\%$ өссөн байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



“ Эдийн засгийн хямралтай ч, хөрөнгө оруулалтын хувьд өндөр өгөөжтэй жил байлаа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Бидний үйл ажиллагааг үргэлж дэмжин, итгэл үзүүлсэн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нартаа баярын мэнд хүргэхийн сацуу талархал илэрхийлье.

Дэлхий дахинд аюулт цар тахал нүүрлэсэн 2020 онд бид 5.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлоготой ажиллаж чадлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 47 хувиар өссөн үзүүлэлт ба салбарын дундаж өгөөжөөс даруй 7.4 хувь нэгжээр илүү үзүүлэлт юм.

Олон арван сая хүний амийг авч одсон вируст өвчний улмаас дэлхийн эдийн засаг, нийгмийн байдалд томоохон гарз хохирлыг авчирсан бөгөөд энэ нь түүхэнд Ковид-19 вирусээс үүдэлтэй эдийн засгийн хямрал хэмээн түүхэнд тэмдэглэгдэн үлдэх буй за.


Аливаа эдийн засгийн хямрал нь нийгмийг бүхлээр нь доройтуулж, маш олон хүнд ажлын байр, санхүүгийн хүндрэлийг авч ирж, олон компанийн дампуурах шалтгаан болон хувирдаг. Харин нөгөө талаас үүнийг боломж болгон ашиглаж болдог. Энэ суурь зарчмын хүрээнд бид хөрөнгө оруулалтын сувгуудаа улам бүр нэмэгдүүлж, багцаа төрөлжүүлж, товчхондоо хямралыг боломж болгон ашиглаж чадлаа.

Хөрөнгө оруулалтын хувьд эрсдэл, өгөөж гэдэг зоосны хоёр тал шиг зүйл. Нөхцөл байдлаас үүдэн бид өгөөжөөс урьтан эрсдэлийн удирдлагаа төгөлдөржүүлэх ажлыг хийсэн нь тун оновчтой шийдэл байв. Үүнд, тогтмол орлоготой үнэт цааснуудын барьцааг нэмэгдүүлэх, хөрвөх чадвар муутай хувьцаануудаа борлуулах, мөчлөг дагасан салбаруудаас зайлсхийх, олон улсын зээлжих зэрэглэл бүхий үнэт цааснуудыг сонгох зэргийг дурдаж болно.

2020 оны энэхүү амжилт нь бидний хөрөнгө оруулалтын суурь зарчмууд зөв болохыг баталсанд хувьдаа болон хамт ольныхоо өмнөөс баяртай байна. Эдгээр суурь зарчмуудыг дурдвал:

- Эрсдэлийн удирдлага нэгт, өгөөж хоёрт
- Эдийн засгийн бүхий л мөчлөгт хөрөнгө оруулалтын боломжууд бий
- Урт хугацаанд бүгд бодит үнэ цэнэ дээрээ очдог

Энэхүү эерэг, сайн үр дүнтэй жил нь та бидний хамтдаа туулах олон сайхан жилүүдийн эхлэл болно хэмээн найдаж байна.



Г. ГАНЗОРИГ

Хөрөнгө оруулалт хариуцсан захирал

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мандал даатгалын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь СЗХ-оос тогтоосон даатгалын компанийн харьцаа үзүүлэлт болон даатгалын компанийн мөнгөн хөрөнгө байршуулах хязгаартай нийцүүлэн явагддаг билээ.

Багц бүрдүүлэлтийн төлөвлөгөөг макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал болон хөрөнгө оруулалтын боломжууд дээр үндэслэн гаргадаг бөгөөд эрсдэл багатай, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийх нь гол зорилго юм.

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2019	2020	Өсөлт
Мөнгөн хөрөнгө	28.5	33.6	18%
Хөрөнгө оруулалтын орлого	3.8	5.5	47%

Компани нь Удирдлагын хорооны дэргэдэх Хөрөнгө оруулалтын дэд хороотой хамтран үйл ажиллагаа явуулдаг. Тус хороо нь хараат бусаар эрсдэл болон өгөөжийг харгалзан шийдвэр гаргадаг ба холбогдох этгээдэд хөрөнгө оруулалт хийдэггүй. Хөрөнгө оруулалтын удирдлага нь компанийн хөрөнгө оруулалтын позицийг өдөр бүр тогтмол хянан, шаардлагатай тоон мэдээллүүдийг тооцож явдаг.

БАГЦЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖИЙН ХАРЬЦУУЛАЛТ



Эх сурвалж: Монголын даатгагчдын холбоо, Монголбанк

Компанийн мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын үлдэгдлийг 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр үзүүлбэл:

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2020	Хувь
Бэлэн мөнгө	2.2	6%
Тогтмол орлоготой үнэт цаас	30.1	90%
Банкан дахь мөнгөн хөрөнгө	24.8	74%
Бонд	1.5	4%
Компанийн өрийн хэрэгсэл	3.7	11%
Хувьцаа	1.3	4%
Нийт	33.6	100%

Мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалт нь компанийн нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг буюу 71 хувийг бүрдүүлдэг. Нийт активын ихэнх хэсгийг бүрдүүлж буй мөнгөн хөрөнгийн оновчтой удирдлага, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь компанийн ашгийг бий болгогч томоохон хүчин зүйл юм.

Компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг байршуулсан үнэт цаас гаргагчийн үнэлгээгээр харвал:

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2020	Хувь
В3 үнэлгээтэй /Moody's/	27.0	81%
Үнэлгээ хийгдээгүй	6.5	19%
Нийт	33.6	100%

Мөнгөн хөрөнгийн 81 хувийг Олон улсын үнэлгээний Moody's агентлагаас өгсөн үнэлгээгээр В3 үнэлгээтэй үнэт цаас гаргагчид байршуулсан байна. Монгол Улсын Засгийн газар нь Moody's агентлагаас өгсөн үнэлгээгээр мөн ижил В3 үнэлгээтэй юм.

ДААТГАЛЫН БОРЛУУЛАЛТ



Үе үеийн залуусын мөрөөдөл, тогтвор тууштай ажилласан түүх, стратеги, менежментийн оновчтой бодлогуудын үр шимээр өнөөдрийн Мандал даатгал салбарынхаа хамгийн эрүүл, хүчирхэг, эрсдэл даах чадвартай, тэргүүлэгч компани болж хөгжсөн.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ОРЛОГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт харилцагч, хөрөнгө оруулагч, хамтрагч танаа

2020 оныг нэг үгээр ЭРСДЭЛ гэж дүгнэж болно. Монгол Улсыг төдийгүй Дэлхий нийтийг цочроосон цар тахал нь эдийн засаг, нийгмийг доройтуулж, бидэнд ойлгомжгүй, санаа зовнилтой, тодорхойгүй үеүдийг бий болгож байсан бол дотоодод гал түймэр, үер уснаас гадна төдийлөн тохиолдоод байдаггүй газар хөдлөлтийн эрсдэл үүссэн жил байлаа. Мандал даатгал нь харилцагчидтайгаа амьдралынх нь бүхий л үед, тэр дундаа эрсдэлтэй хүнд үед нь цугтаа байж зовлон жаргалыг хамт туулах зорилгоор тэмүүлэн ажилладаг билээ.

Тиймдээ ч бид даатгалын салбарт тогтвортой өсөлтийг тууштай хамтын ажиллагаагаар бий болгож ирсэн. Өнгөрсөн 10 жилд бид хамгийн отгон даатгалын компаниас хөрөнгө, борлуулалтын орлого, эрсдэл даах чадвар, нөхөн төлбөрөөрөө салбартаа тэргүүлээ. Харилцагчдааа боломжит бүх сувгаар хурдан шуурхай хүрч үйлчлэх нь Мандал даатгалын нийт хамт олны үндсэн зорилго болж ирсэн.

Дижитал борлуулалтын сувгуудыг хөгжүүлэх, фэйсбүүк, аппликейшн, утсан борлуулалт, биечлэн хийж буй борлуулалтын сувгуудыг сайжруулж, аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг чанаржуулахад анхаарч ажилласны үндсэн дээр хүнд үеийг харьцангуй бага эрсдэлтэйгээр даван тууллаа.

Эрдэнэт хүн бол Мандал даатгалын эрхэм үнэ цэнэ гэдэгт бид итгэж ажилладаг. Зорилго, вижндээ итгэсэн мэргэжлийн боловсон хүчин, даатгалын туршлагатай зөвлөх бол ямар ч хүнд үед харилцагчаа зөв чиглүүлж чадах чухал хамтрагч нь билээ. Мандал даатгалын хамт олны бусдаас ялгарах нэг онцлог нь мерит зарчмаар өсөн дэвшдэг, мэргэшдэг байдал юм. Шинээр ажилд орж буй залуусыг харилцагчийн үйлчилгээ, шууд борлуулалт зэрэг анхан шатны ажлаас нь мэргэшүүлснээр харилцагчийнхаа

хэрэгцээ шаардлагыг сонсох, мэдрэх тал дээр бусдаас илүү ойр байдаг гэдэгт итгэдэг. Ингэснээр тэд харилцагчдаас гарсан саналыг дамжуулах, шаардлагатай бүтээгдэхүүн үйлчилгээг нь бий болгох тал дээр жил ирэх тусам боловсорч, ахиц гарсаар байна. Үүнийг харилцагч, хамт олны санаачлагаар томуу, томуу төст өвчний вакцинжуулалт, КОВИД санхүүгийн даатгал, байгууллагын иж бүрэн эрсдэлийн үнэлгээ зэргээр жишээ татан харж болох юм. Мөн манай байгууллагад мэргэжлийн эмч, хөрөнгө оруулагч, даатгалын зөвлөх, эрсдэлийн судлаач зэрэг төрөл бүрээр мэргэшсэн хамт олон улс эх орныхоо сайхан ирээдүй, сайн цагийн төлөө зогсолтгүй, бүх хүчээ дайчлан ажиллаж байна.

Мандал даатгалын энэ хүртэл бий болгож, үргэлж хамгаалж ирсэн үнэ цэнэ бол санхүүгийн найдвартай байдал юм. Үе үеийн залуусын мөрөөдөл, тогтвортой, тууштай ажилласан түүх, тактик, стратеги, менежментийн оновчтой бодлогуудын үр шимээр өнөөдрийн Мандал даатгал нь салбарынхаа хамгийн эрүүл, хүчирхэг, эрсдэл даах чадвартай, тэргүүлэгч компани болж хөгжсөн билээ.

Ирээдүй бидэнд үргэлж сайхан харагддаг. Амьдрал баялаг учир бид асуудал болоод эрсдэлтэй үргэлж нүүр тулах болно. Гэхдээ цаг ямагт сайн сайханд итгэж, эрсдэлтэй хүнд үеүдэд бэлтгэлтэй байж, юунд ч бууж өгөлгүй зорилго тэмүүлэлтэй байхыг өнгөрсөн жилүүд бидэнд сургалаа. Цаашид үргэлж шинэчлэгдэн хөгжиж, дижитал суваг, мэргэжлийн хамт олон, санхүүгийн найдвартай байдлаараа улс эх орондоо төдийгүй бүс нутаг, Ази тивдээ хөрөнгө оруулалт хийсэн даатгалын түүхээ компани болж хөгжинө гэдэгт итгэлтэй байна. Энэ бүх зорилгын үнэ цэнэтэй хэсэг болж буй харилцагч, хөрөнгө оруулагч, хамтрагч та бүхэндээ гүн талархал илэрхийлье.



Н.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

Гүйцэтгэх захирлын орлогч

ДААТГАЛЫН БОРЛУУЛАЛТ

2020 онд бид барилга угсралт, гэнэтийн осол, эрүүл мэнд, хариуцлага, тээврийн хэрэгслийн даатгалын нийт хураамжийн орлого болон олгосон нөхөн төлбөрийн хэмжээгээр салбараа түүчээлэв.

Даатгалын салбар өндөр хөгжсөн орнуудад иргэдийн болон байгууллагын даатгалын хураамжийн орлогын харьцаа ойролцоогоор 50:50 байдаг нь салбарын хувьд зохист харьцаа юм. Монгол Улсын хувьд иргэдийн даатгал болон байгууллагын даатгалын салбарын хураамжийн орлогын харьцаа 30:70 байна.

Манай орны байгууллагын даатгалын хураамжийн орлого салбарын нийт орлогын дийлэнх буюу 70 орчим хувийг бүрдүүлж байгаа нь салбарыг макро эдийн засгийн мөчлөгөөс ихээхэн хамааралтай болоход хүргэдэг. Тухайлбал, эдийн засгийн хямралын жилүүдэд байгууллагууд даатгалд зориулсан төсвөө танах хандлагатай байдаг бөгөөд байгууллагын даатгалын харилцагч давамгайлсан даатгалын компаниудын хувьд бизнесийн үйл ажиллагаа нь харьцангуй тогтворгүй байх эрсдэл дагуулдаг. Харин иргэдийн даатгалын бизнесийг хөгжүүлж, орлогын жишиг харьцаанд дөхөж ажиллавал компани нь урт хугацаанд тогтвортойгоор өсөж хөгжих давуу талтай байдаг билээ.

Мандал даатгалын хувьд иргэдийн даатгал болон байгууллагын даатгалын хураамжийн орлогын харьцаа 45:55 хувьтай байгаа нь даатгалын салбар өндөр хөгжсөн орнуудын жишгийн дагуу явж байгаагийн илрэл юм.

БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ

Мандал даатгал нь байгууллагын даатгалын чиглэлээр салбартаа тэргүүлэгч, Монголын ТОП 100 аж ахуй нэгжийн 1/3-ийг дангаараа даатгадаг хамгийн том корпорэйт даатгагч юм. Бид уул уурхай, барилга, тээвэр, худалдаа, үйлчилгээ, санхүү, үйлдвэрлэлийн салбарын компаниудад нийт 60 орчим нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож байна. Эдгээр нь байгууллагын нийт харилцагчдаас орж ирэх орлогын 95 хувийг бүрдүүлдэг билээ.

Байгууллагын харилцагчдадаа мэргэжлийн, чанартай, найдвартай буюу санхүүгийн чадамжтай, давхар даатгагдсан үйлчилгээг хүргэж буйг олон улсын үнэлгээний AM Best байгууллага өндрөөр үнэлсэн нь бидний үйл ажиллагаа шат ахиж, өргөжсөнийг нотлон харуулсан юм.

Харилцагчийн үйлчилгээ болон дижитал эрин

2020 оны байдлаар бид барилга угсралт, гэнэтийн осол, эрүүл мэнд, хариуцлага,

тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүний нийт хураамжийн орлого болон олгосон нөхөн төлбөрийн хэмжээгээр салбараа түүчээлэв. Тодруулбал, зөвхөн эрүүл мэндийн даатгалын хувьд даатгуулагчид олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 2.7 тэрбум төгрөгт хүрч, 9,700 гаруй нөхөн төлбөрийн материалыг цахимаар буюу гар утасны Мандал аппликейшнд суурилан хүлээн авч, өмнөх оноос хоёр дахин богино хугацаанд буюу дунджаар ажлын 1-3 хоногт шийдвэрлэн ажиллалаа.

2020 он бол байгууллагын харилцагчдын хувьд цар тахлын улмаас тооцоолоогүй нөхцөл байдлууд, гэнэтийн эрсдэлүүдтэй нүүр тулсан, төлбөрийн чадварын хувьд сорилт дүүрэн жил болж өнгөрлөө. Энэ сорилт дунд бизнесүүд нэн түрүүнд тэвчиж болох зардлуудаа хойшлуулж, худалдан авалтын бодлогоо чангатгадаг. Даатгалын төсөв зардлаа танах, хасах нь компаниудын хувьд хамгийн хялбар, тэргүүнд шийддэг асуудал юм.

Нөгөөтэйгүүр өнгөрсөн онд даатгалын худалдан авалтаа үргэлжлүүлж, эрсдэлээ удирдаж буй харилцагчид дийлэнх байсан нь тун сайшаалтай байв. Энэ нь сүүлийн 10 жил бид харилцагчийн эрсдэлийн боловсролд чиглэсэн Эрсдэлийн удирдлагын форум, эрсдэлийн тайлан, салбарын эрсдэлийн семинар, эдийн засгийн Purplebook сэтгүүл гэх мэт олон арга хэмжээ, сургалт, уулзалт, семинар, эрсдэлийн контентууд боловсруулан хүргэж байсны үр нөлөө бөгөөд харилцагчдын хувьд эрсдэлийн удирдлагын хандлага, тэр тусмаа даатгалын ойлголтод өөрчлөлт орж буйн тод илрэл юм.

Бид цар тахлын үед харилцагчдын эрсдэлийг шилжүүлж авч даатгахаас гадна тэдэнд эрсдэлийн удирдлагын зөвлөгөө, мэдээллүүдийг зөв цагт нь цаг алдалгүй хүргэж, эрсдэл бууруулах чиглэлд хамтран ажиллалаа. Энэ ажлын хүрээнд дараах шат дараатай ажлуудыг цаг үетэйгээ нийлүүлэн хэрэгжүүллээ. Үүнд:

- Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх болон цар тахлын үед бизнесээ удирдах чиглэлээр сургалтын контент, гарын авлага, нийтлэл мэдээ, ажлын заавруудыг боловсруулан харилцагчдаа цахимаар хүргэв.
- Байгууллагын даатгалын бүх харилцагчаа КОВИД санхүүгийн даатгалын бүтээгдэхүүнээр үнэ төлбөргүй хамгаалсан нь харилцагчдын талархлыг хүлээсэн, цаг үеэ мэдэрсэн чухал алхам боллоо.
- Байгууллагын харилцагчидтай хамтран ажиллах дунд, урт хугацааны тусгай хөтөлбөр гарган, энэхүү хүнд цаг үед нь санхүү, төлбөрийн хувьд уян хатан, урт хугацааны 30-50 хувийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хамтран ажиллах санал хүргүүлэн ажиллав.
- Харилцагчийн эрсдэлийг бууруулах чиглэлд 2020 онд нийтдээ 21 удаагийн эрсдэлийн үнэлгээг хамтран хэрэгжүүлж ажиллалаа. Үүний үр дүнд харилцагчдын эрсдэлийг бодитоор харж, зөв үнэлэлт, дүгнэлтийг өгч, тэдэнд хамгийн сайн тохирох нөхцөл хамгаалалтыг санал болгож чадсан. Эрсдэлийн үнэлгээний үр дүнд даатгуулагчийн зайлшгүй авч хэрэгжүүлэх болон анхаарах арга хэмжээнүүдийг тодорхойлж, зарим эрсдэл бууруулах арга хэмжээг хамтдаа хэрэгжүүллээ.

ИРГЭДИЙН ДААТГАЛ

Мэргэжлийн хамт олон

Мандал даатгал нь байгуулагдсан цагаасаа эхлэн даатгалын салбарын мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажилласан бөгөөд Шууд борлуулалтын хэлтсийг 2014 онд таван хүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулсан. Уг хэлтэс нь иргэдэд даатгалын мэдээлэл өгөх, харилцагч төвтэй, хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэхээс гадна, иргэдийг эрсдэлээс үүдэн гарах хохирлыг тооцож сургахад чиглэн ажилладаг.

Даатгалын салбарт ажиллах гараагаа шууд борлуулалтын хэлтэст ажиллаж эхэлснээр даатгалын төрөл бүрийн бүтээгдэхүүний талаарх өргөн мэдлэгийг олж авах, харилцагчдад мэргэжлийн түвшинд зөвлөх үр чадваруудыг эзэмшдэгээрээ давуу талтай юм. Хэдийгээр бид технологийн дэвшилтэт зуунд амьдарч, бүх харилцаа цахим орчинд өрнөх нь давамгайл болсон ч биет хүнтэй харьцах, зөвлөгөө авах мэргэжлийн борлуулалтын үйлчилгээ хоцрогдолгүй улам ч боловсронгуй болсоор ирсэн билээ.

Шууд борлуулалтын ажилтнууд нь дараах давуу талыг харилцагчдад олгодог:

- Бид аливаа нэг бараа бүтээгдэхүүнийг борлуулах биш зөвлөх, чиглүүлэх, ойлгуулах зорилгыг баримталдаг нь харилцагчдад даатгалын талаарх ойлгомжгүй байдлыг үгүй хийж, үр ашгийг нь хурдан хүртэхэд дэмжлэг үзүүлдэг.
- Шууд борлуулалт нь харилцагчдад даатгалын бүтээгдэхүүнийг өөрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн авах боломжийг олгодоггоороо цаг хугацааг хэмнэх давуу талтай.
- Урамшуулалт аян, хөнгөлөлт зэрэг харилцагчдад өгөөжтэй үйлчилгээнүүдийг өөрийн зөвлөхтэй холбогдох замаар шууд авах нь VIP үйлчилгээг бий болгодог.
- Харилцагч, даатгалын ажилтан хоёрын итгэлцлийг бий болгох замаар урт хугацааны үнэнч харилцаа бий болдог.

ХАРИЛЦАГЧИЙН ХАЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Мандал даатгал нь харилцагч төвтэй стратегийн хүрээнд бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанар, хүртээмж, харилцагчийн сэтгэл ханамжийг тодорхойлон түүнд суурилсан үр ашигтай халамжийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлж ажиллалаа. Энэхүү бодлогын хүрээнд дараах чиглэлүүдэд иж бүрэн халамжийн арга хэмжээ зохион байгуулав.

Үйлчилгээний чанар

Эмнэлэг хамтын ажиллагааны хүрээнд ТОП 2 эмнэлэгтэй харилцагчдад туслах дундын ажилтантай болж, чирэгдэлгүй бүтээгдэхүүн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлээд байна.

Дотоод үйл ажиллагаанд ISO процессын удирдлагын системийг нэвтрүүлж, үйл ажиллагааны процессыг оновчлов.

Хүртээмж

Эмнэлэг хамтын ажиллагааны хүрээнд сүлжээ эмнэлгийн тоог гурваар нэмж, мобайл аппликейшн ашиглалтыг нэмэгдүүлэх гарын авлагаар хангаж, харилцагч түргэн шуурхай үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэв.

Гепатит В,С вирусийн илрүүлэг шинжилгээ, Гепатит В вирусийн вакцинд 10 гаруй байгууллагын 500 ажилтан, томуугийн вакцинд 30 гаруй байгууллагын 1,100 ажилтныг тус тус хамруулсан.

Харилцагч байгууллагын ажилтнуудад 80 гаруй цагийн даатгалын гэрээ болон эрсдэлийн удирдлагын сургалтыг танхимаар зохион байгуулж, онлайн гарын авлага, сургалтын видео материалыг хүргэж, зайнаас мэдээлэл өгч ажиллалаа.

2020 ОНЫ НӨХӨН ТӨЛБӨРИЙН ОНЦЛОХ ТОХИОЛДЛУУД

Харилцагч: ХХХ

Хохирол гарсан огноо: 2020 оны 3 сар

Даатгалын тохиолдлын шалтгаан: Даатгуулагчийн эзэмшлийн үл хөдлөх хөрөнгөд цахилгаан сүлжээний гэмтэл, цахилгааны утасны богино холболтоос үүдэн гал түймэр гарч даатгуулагч болон гуравдагч этгээдүүдийн хөрөнгөнд их хэмжээний хохирол учирсан.

Хохирлын хэмжээ: 430 сая төгрөг

Шийдвэрлэлт: Даатгалын гэрээний дагуу харилцагч болон гуравдагч этгээдүүдийн хохирлыг бүрэн барагдуулсан.



Харилцагч: Мандал даатгалын 5 харилцагч

Хохирол гарсан огноо: 2020 оны 6 сар

Даатгалын тохиолдлын шалтгаан: Гуравдагч этгээдийн санамсар болгоомжгүй байдал, аюулгүй ажиллагаа мөрдөн ажиллаагүй үйлдлээс үүдэн объектын гал түймэр гарч Номин их дэлгүүрт үйл ажиллагаа явуулдаг Мандал даатгалын харилцагч нарын бараа материал, эд хөрөнгөнд хохирол учирсан.

Хохирлын хэмжээ: 150 сая төгрөг

Шийдвэрлэлт: Харилцагч нарын хохирлыг бүрэн барагдуулсан.



Харилцагч: ХХХ

Хохирол гарсан огноо: 2020 оны 4 сар

Даатгалын тохиолдлын шалтгаан: Уурхайн хөрс тээвэрлэх ажлын явцад даатгуулагчийн эзэмшлийн том оврын өөрөө буулгагч машин замын хөдөлгөөнд оролцох үедээ жолоочийн санамсар болгоомжгүй, буруутай үйлдлээс үүдэн мөргөлдөж даатгуулагч болон хохирогч талын хөрөнгөнд их хэмжээний хохирол учирсан.


Хохирлын хэмжээ: 864 сая төгрөг

Шийдвэрлэлт: Даатгуулагч болон хохирол учирсан гуравдагч этгээдийн хохирлыг бүрэн барагдуулсан.



БИЗНЕС ХӨГЖИЛ

“ Ард иргэд, аж ахуй нэгжүүдийн эрсдэлийн удирдлагын талаарх цогц ойлголт нэмэгдэх нь салбарын хөгжлийн бодит хөшүүрэг болж чадна.



БИЗНЕС ХӨГЖИЛ МАРКЕТИНГ ХАРИУЦСАН ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Бидний амжилт бүрийн ард хана мэт бат зогсдог эрхэм харилцагч, хөрөнгө оруулагч, түншүүддээ Мандал даатгал компанийн 10 жилийн ойн мэндийг дэвшүүлье!

Манай улсын санхүүгийн салбарын 93 хувийг банкны салбар дангаараа эзэлдэг бол даатгалын салбар ердөө 1 хувийг эзэлж байна. Олон улсад банкны салбартай эн зэрэгцэн оршдог даатгалын салбар нэвчил багатай байгаа нь нэг талаасаа хөгжлийн доогуур түвшинг нь илтгэж байгаа боловч, нөгөө талаасаа бидэнд өсөлт, хөгжлийн ямар их орон зай байгааг харуулж байгаа юм. Мандал даатгал байгуулагдсан цагаасаа нэгэнт тогтсон зах зээл дээр өрсөлдөхөөс илүүтэй хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, амьдралд ойрхон бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан шинэ хэрэглэгчдийн бааз суурийг бүрдүүлж, даатгалын зах зээлийг тэлэх зарчмыг баримтлан ажиллаж ирсэн.

Энэ зарчмын хүрээнд сүүлийн 10 жилийн хугацаанд даатгалын зах зээл дээр олон шинэ, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн, сайн дурын даатгалтай хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж чадсан. Тухайлбал, Монгол Улсад анх удаа Bancassurance буюу банкаар дамжуулж даатгалын борлуулалт хийх схемийг санаачилсны үрээр олон мянган харилцагчид арилжааны банкуудын өргөн сүлжээгээр дамжуулан манай бүтээгдэхүүнийг авч байна. Харилцагчдын таашаалд нийцсэн Жаргалан, Сонголт, КОВИД зэрэг шинэлэг даатгалын бүтээгдэхүүнүүдийг ч нэрлэж болох юм.

Нөгөөтэйгүүр, дан ганц шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжүүлэх замаар даатгалын нэвчлийг нэмэгдүүлэх боломжгүй. Ард иргэд, аж ахуй нэгжүүдийн эрсдэлийн удирдлагын талаарх цогц ойлголт нэмэгдэх нь салбарын хөгжлийн бодит хөшүүрэг болж чадна. Иймээс, бид даатгалын бүтээгдэхүүний ач холбогдлыг олон нийтэд таниулах, нийгмийн эрсдэлийн боловсролыг нэмэгдүүлэх, олон нийтийн эдийн засгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлд олон тооны төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, салбарын хөгжилд хувь нэмрээ оруулсаар байгаа билээ.

Салбарын хөгжлийн асуудлыг дэвшүүлж байгаа нөхцөлд дижитал шилжилтийг заавал хөндөх шаардлагатай болно. Орчин үеийн технологийн дэвшлийн нөлөөгөөр уламжлалт даатгалын тогтолцоо ихээхэн өөрчлөлт, шинэчлэлтэд орох нь дамжиггүй. Иймээс, бид стратегийн түвшинд энэхүү өөрчлөлтөд бэлтгэлтэй байж, өөрчлөлтийн нэг хэсэг бус өөрчлөлтийг хэлбэржүүлэх гол тоглогч нь байхыг зорин ажиллаж, та бүхэнд хүлээлтээс давсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээр бэлэг барьсаар байх болно.



3.ОДМАА

Бизнес хөгжил маркетинг хариуцсан захирал

БИЗНЕС ХӨГЖИЛ

Харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн, амьдралд ойрхон, шинэлэг даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, хамгийн үр ашигтай сувгаар хүргэхийг зорин ажиллаж байна.

Мандал даатгал нь байгуулагдсан цагаас хойш салбартаа шинэлэг шийдлийг нэвтрүүлж, харилцагчдын хүсэл шаардлагад нийцсэн даатгалын үйлчилгээг үзүүлэхийг эрмэлзсэн. Түүнчлэн компанийн бизнес хөгжил, бодлогын хүрээнд бүтээгдэхүүний чанар, зах зээлд өрсөлдөх чадвар болон, даатгуулагчдад хүргэх борлуулалтын сувгийг үр ашигтайгаар шийдэхэд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Даатгалын бүтээгдэхүүнүүд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцдэггүй, нөхөн төлбөр авах үед таагүй, хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэдэг зэрэг даатгалын салбарын талаарх хэвшмэл, буруу ойлголтуудаас үүдэн иргэд сайн дураараа даатгуулах дадал багатай байдаг. Эдгээр асуудлыг шийдвэрлэх, зах зээлд иргэдийн сайн дурын даатгалыг хөгжүүлэх зорилгоор манай компани 2014 онд судалгаа шинжилгээнд суурилсан бүтээгдэхүүн хөгжлийн технологийг анх нэвтрүүлсэн. Үр дүнд нь бид Жаргалан, Сонголт, Замд Гаръя, КОВИД зэрэг хэрэглэгчдийн талархлыг хүлээсэн олон бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн билээ. Мөн шинээр гаргаж буй болон нэгэнт зах зээлд нэвтрүүлсэн бүтээгдэхүүнээ харилцагчдынхаа амьдралд ойр байлгахад анхаарч, бүтээгдэхүүнээ сайжруулах ажлыг тасралтгүй хийсээр байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ


Мандал даатгал нь 2015 онд дотооддоо анхны хувийн эрүүл мэндийн даатгал болох Жаргаланг зах зээлд нэвтрүүлсэн билээ. Иргэд Улсын эрүүл мэндийн даатгалд жил бүр тогтмол хураамж төлдөг боловч үйлчилгээний хүртээмж бага байдгаас шалтгаалан шаардлагатай тусламж үйлчилгээгээ авч чаддаггүй, эрүүл мэндийн зардлыг халааснаасаа төлдөг, эрүүл мэнддээ хуримтлал үүсгэдэггүй учраас өвдсөн тохиолдолд санхүүгийн болон сэтгэл зүйн асар их дарамтанд ордог зэрэг асуудлууд түгээмэл байдаг нь бүтээгдэхүүний зах зээлийн судалгаагаар тогтоогдов.

Эдгээр асуудлын шийдлийг эрэлхийлэн, Жаргалан даатгалыг хөгжүүлсэн нь өдгөө 8,000 даатгуулагчтай зах зээлд №1 даатгал болж, хувийн эрүүл мэндийн даатгалын зах зээлийн 60 хувийг дангаараа бүрдүүлж байна.

ЭРҮҮЛ МЭНД, ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛЫН НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО,
тэрбум төгрөг

8.0 тэрбум

Дундаж өсөлт: 54%



2015

Монгол Улсад анхны дотоодын эрүүл мэндийн даатгал болох Жаргалан даатгалыг зах зээлд нэвтрүүлэв.

Жаргалан эрүүл мэндийн даатгал зах зээлд нэвтэрсэн тухайн жилдээ **BLOOMBERG AWARD "ШИЛДЭГ ИННОВАЦИ"** шагнал хүртэв.



2016

Улсын бүх шатлалын эмнэлгүүд болон тэргүүлэх зэрэглэлийн хувийн 13 эмнэлэгтэй гэрээ байгуулж, хувийн эрүүл мэндийн даатгалын хамгийн том дэд бүтцийг бий болгов.

Мөн мэргэжлийн эмч, мэргэжилтнүүдээс бүрдсэн эрүүл мэндийн даатгалын мэргэжлийн багийг бүрдүүлэв.



2017

Монгол Улсын түүхэнд сайн дурын эрүүл мэндийн даатгалын хамгийн том гэрээг Оюу Толгой ХХК-тай байгуулж, тус компанийн нийт ажилчдын эрүүл мэндийн асуудлыг хариуцан ажиллах болов.



2018

Оюу Толгой төслийн хамгийн том туслан гүйцэтгэгчдийн нэг болох Жи Си Ар Монголиа ХХК нийт ажилчид болон тэдгээрийн гэр бүлийг Жаргалангаар даатгуулж, хамтын ажиллагааг эхлүүлэв. Ингэснээр, хувийн эрүүл мэндийн даатгал зах зээлийн 60 хувийг дангаараа бүрдүүлдэг боллоо.

2020

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээгээр дэлхийд тэргүүлэгч АХА компанитай давхар даатгалын гэрээ байгуулав. Ингэснээр Жаргалан эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанарыг улам сайжруулж, дэлхийн жишигт нийцсэн дотоодын болон олон улсын бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдадаа олгох боломж бүрдлээ.



Өнгөрсөн зургаан жилийн хугацаанд Мандал даатгал Жаргалан эрүүл мэндийн даатгалаар нийт 6.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгон, 8,100 гаруй харилцагчийн эрүүл мэндийн эмчилгээ, үйлчилгээний санхүүгийн асуудлыг шийдвэрлэжээ.

Мандал даатгал нь Жаргалан эрүүл мэндийн даатгалыг харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, цогц үйлчилгээг хүргэхээр тасралтгүй сайжруулж ирсэн бөгөөд даатгалын гурван төрлийн багцыг санал болгож байна.



Жаргалан эрүүл мэндийн даатгалын давуу тал

- Монголын тэргүүлэх зэрэглэлийн хувийн болон улсын эмнэлгүүдийг өөрийн эмнэлгийн сүлжээнд багтаасан.
- Мэргэшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн эрүүл мэндийн хамгийн том тусгайлсан багтай.
- Хэвтэн эмчлүүлэх тохиолдолд төлбөрийг эмнэлэг рүү шууд шилжүүлэх Direct billing шийдлийг тав дахь жилдээ амжилттай хэрэгжүүлж байна.
- Гар утасны аппликейшнээр дамжуулан эрүүл мэндийн нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэдэг боллоо.

Олон улсын эрүүл мэндийн даатгал

Мандал даатгал нь Дэлхийд эрүүл мэндийн даатгалын үйлчилгээгээр тэргүүлэгч АХА компанитай 2020 онд эрүүл мэндийн даатгалаар хамтран ажиллах гэрээ байгууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний чанарыг улам сайжруулж, эрсдэл даах чадамжаа нэмэгдүүлэн, найдвартай хамгаалалтыг санал болгож, үйлчилгээний дэд бүтцээ олон улсын жишигт хүргэн, өргөжүүлэх боломжийг өгсөн юм.

АХА нь ердийн даатгал, амьдралын даатгал, банк санхүү, хөрөнгийн удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дэлхийн хамгийн том групп компаниудын нэг бөгөөд 2020 оны байдлаар дэлхийн 57 оронд салбарлаж, 160,000 ажилтан, 108 сая харилцагч, олон улсад 11,000 орчим сүлжээ эмнэлэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хамтын ажиллагааны давуу тал

1. Олон улсын давхар даатгагчийн найдвартай хамгаалалт;
2. Эрүүл мэндийн даатгалын эрсдэл даах чадвар нэмэгдэх;
3. Бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл сайжрах, илүү уян хатан болох;
4. Олон улсын тэргүүн туршлагуудаас суралцаж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж;
5. АХА-ийн олон улсын сүлжээг ашиглан, чанартай эмчилгээ үйлчилгээг 24/7 авах боломж;

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛ

2012

Вансассурэнс буюу банкны даатгалын зуучлалын системийг бий болгосон нь тээврийн хэрэгслийн даатгалын зах зээлийг тэлэхэд ихээхэн түлхэц үзүүлэв.



2014

Даатгалын зөвлөгөө үйлчилгээг газар дээр нь очиж үзүүлэх Шууд борлуулалтын нэгжийг бий болгосноор сайн дурын даатгуулагчдыг татах, үнэнч харилцагчдын баазыг бүрдүүлэх эхлэл тавигдлаа.

2015

Зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлаж шинэ концепц бүхий Сонголт багц даатгал, уламжлалт даатгалын бүтээгдэхүүнийг илүү сайжруулан шинэчилсэн Классик тээврийн хэрэгслийн даатгалыг тус тус хөгжүүлж гаргасан нь зах зээлд амжилттай нэвтэрч өдгөө брэнд бүтээгдэхүүн болжээ.



2018

2018 оноос хойш даатгалын зах зээлийн мөчлөгт тохируулан жилдээ 2-3 удаа урамшууллын аян зохион байгуулж, борлуулалтыг дэмжих үйл ажиллагаа тогтмол явуулж байна.

Бидний зохиосон Даатгалын синдром, Нэг тонн бензин, Дүүрэн богц зэрэг урамшуулалт аянуудад нийт 5,100 гаруй харилцагч хамрагдаж бэлэг урамшууллын эзэд болжээ.



2020



Олон жил даатгуулсан үнэнч харилцагч нартаа зориулж Харилцагчийн халамжийн өдөрлөгийг зохион байгуулж хоёр өдрийн турш харилцагчдад авто үзлэг, оношилгоо болон эрүүл мэндийн нэмэлт үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүллээ. Энэхүү үйл ажиллагааг цаашид тогтмол хэрэгжүүлж, харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээр шийдвэрлээд байна.




Тээврийн хэрэгслийн даатгал нь салбарын хувьд голлох байр суурь эзэлдэг хамгийн түгээмэл хэлбэрийн бүтээгдэхүүн юм. Монгол Улсын хувьд сүүлийн 10 жилд автомашины тоо хоёр дахин өсөж 1 сая даваад байна. Харамсалтай нь манай орны тээврийн хэрэгслийн даатгалын нэвчилт хөгжиж буй орнуудын дундаж үзүүлэлтээс доогуур байгаа ч нөгөөтэйгүүр энэхүү зах зээлд тэлэх боломж их байгааг харуулдаг.

Бид 2011 оноос хойш зах зээлд эзлэх байр сууриа олохын тулд даатгуулагчийн тоог нэмэгдүүлэх, улмаар үнэнч харилцагчийн баазыг бүрдүүлж тогтвортой өсөлтийг хангах олон төрлийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд өнгөрсөн 10 жилийн хугацаанд тогтмол өсөлт үзүүлж 2020 оны эцсийн байдлаар тээврийн хэрэгслийн даатгалын зах зээлийн 18.5 хувийг дангаараа бүрдүүлж тэргүүлэгч гэдгээ дахин баталгаажууллаа.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛЫН НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО, тэрбум төгрөг

6.5 тэрбум

Дундаж өсөлт: 36%



СУВАГ ХӨГЖИЛ

Банкны зуучлал

Мандал даатгал нь 2012 онд Монгол Улсын тэргүүлэх банкнуудын нэг ХААН банктай хамтран банкны даатгалын зуучлалыг Монголд анх удаа албан ёсоор нэвтрүүлж байсан билээ. Эдүгээ, энэхүү борлуулалтын суваг өргөжин тэлж, жилд 20.9 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг зуучилжээ.

Мандал даатгалын хувьд арилжааны томоохон банкууд болох Голомт, ХААН, Капитрон болон Тээвэр хөгжлийн банктай хамтран ажиллаж, тус банкуудын Улаанбаатар хот болон орон нутаг дахь 300 гаруй салбар, тооцооны төвүүдээр дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж байна.

2019 онд Монголбанкнаас арилжааны банкуудын “Хэрэглээний зээлийн журам”-д өөрчлөлт оруулж шинээр олгогдох хэрэглээний зээлийн хугацааг 30 сараар хязгаарлаж, зээлдэгчийн нийт өр, орлогын харьцааг 70 хувиар тогтоох шийдвэр гаргасан. Энэхүү журмын хэрэгжилтийн хүрээнд банкуудын хэрэглээний зээл олголт багассантай холбоотойгоор зээлийн бүтээгдэхүүнийг дагасан даатгалын борлуулалтын орлого салбарын хэмжээнд буурсан хэдий ч, Мандал даатгалын хувьд өнгөрсөн онд банкны зуучлалын орлогыг долоон хувиар өсгөн амжилттай ажиллажээ.

Брокер

2012 онд “Жолоочийн даатгалын тухай” хууль батлагдаж, иргэд уг төрлийн даатгалд хамрагдаж эхэлснээр бид брокерийн зах зээлд үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоогийн байдлаар Мандал даатгал нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй 10 гаруй брокерийн компанитай хамтран ажиллаж, тэдгээрийн салбар төлөөлөгчийн газраар дамжуулан иргэдэд сайн дурын болон жолоочийн хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнийг санал болгож байна.

2020 оны тухайд Мандал даатгал нийт 407 сая төгрөгийг брокероор дамжуулж төвлөрүүлжээ. Цаашид брокерийн үр дүнг сайжруулах, брокерийн зах зээлийг тэлэх, ашигт ажиллагаа болон сайн дурын даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг шинэ бодлого баримталж, брокерийн зах зээлд ажиллахаар бэлтгэлээ базааж байна.

Цахим борлуулалт

Бид 2019 оноос эхлэн даатгалын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх зорилготойгоор Голомт банкны Social Pay, Мост Финтекийн Most money, Гэрэгэ Системсийн Гэрэгэ киоскуудтай хамтран ажиллаж даатгалын үйлчилгээг илүү хялбар, хурдан шуурхай авах боломжийг олгож эхэлсэн билээ.

2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүдэлтэйгээр эрсдэл багатай даатгалын үйлчилгээг хүргэх боломж бүхий цахим сувгаа нэгээр нэмэгдүүлэн Фейсбүүк мессенжер ашиглан даатгалын үйлчилгээ авах боломжийг бүрдүүллээ. Тус сувгаар “Гадаадад зорчигчийн даатгал”, “Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал”, “Тээврийн хэрэгслийн даатгал”, “Замд гаръя” дотоод аяллын даатгал зэрэг сайн дурын дөрвөн бүтээгдэхүүнийг борлуулж байна.



КОВИД санхүүгийн даатгал

Дэлхийн 221 оронд тархаж, олон сая хүнд халдварлаад байгаа шинэ төрлийн коронавирусийн халдвар Ковид-19 нь маш хурдацтай тархаж, нийгмийн харилцаа, ард иргэдийн амьжиргаанд нөлөөлж, бизнесийг тасалдуулж, эдийн засгийг доголдуулсаар байгаа билээ. Нөхцөл байдалтай холбоотой олон улсын даатгалын компаниуд ард иргэд, даатгуулагч нартаа дэмжлэг үзүүлэх зорилгоор төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

Жишээлбэл, Индонези, Тайланд, Энэтхэг зэрэг Зүүн Азийн орнуудад зөвхөн коронавирусийн халдвараас хамгаалсан эрүүл мэнд, амь насны богино хугацаатай, хямд үнэтэй, хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулан иргэддээ нийлүүлж байна. Харин Сингапурын AIA, HSBC, Manulife, ANA Prufential зэрэг есөн даатгалын компани харилцагч нараа богино хугацааны COVID-19 даатгалд үнэ төлбөргүй хамруулсан байна. Хятад болон Европын орнуудад даатгалын компаниуд Эрүүл мэндийн даатгалын хамгаалалтаа нэмэгдүүлж, коронавирусийн халдварыг нэмэлтээр оруулж байгаа бол, эрүүл мэндийн даатгал санал болгодоггүй компаниудын хувьд эд хөрөнгийн даатгалын хураамжийн хөнгөлөлт үзүүлэх зэрэг байдлаар дэмжлэг үзүүлж байгаа аж.

Монгол Улсын хувьд халдвар авсан иргэдийг улсаас үнэ төлбөргүй эмчилж байгаа ч, иргэд олон хоногоор эмчилгээ, үйлчилгээ авах, тусгаарлагдах шаардлагатайгаас үүдэн зардал гарахаас гадна, тухайн хугацаанд ажил хийх, орлого олох боломжгүйд хүрч байгаа билээ. Иймээс, энэхүү богино хугацааны санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх хүрээнд Мандал даатгалын зүгээс КОВИД санхүүгийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, өөрийн 82,000 даатгуулагчийг үнэ төлбөргүй хамруулаад байна. КОВИД санхүүгийн даатгал нь харилцагч Ковид-19 өвчин туссан тохиолдолд 500,000 - 3,000,000 төгрөгийн мөнгөн тэтгэмжийг нэг удаа олгох нөхцөлтэй даатгалын бүтээгдэхүүн юм.

ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Манай байгууллагын үнэт зүйлсийн нэг бол бидний харилцагч. Бид харилцагчийн мэдрэмж болон үйлчилгээний чанарыг нэн тэргүүнд тавьж, салбартаа харилцагчийн үйлчилгээгээр тэргүүлэх зорилт тавин ажилладаг.

Мандал даатгал нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш харилцагчдаа илүү ойр байж, хурдан шуурхай үйлчлэхийн тулд харилцагчийн болон нөхөн төлбөрийн үйлчилгээнийхээ чанар, хүртээмжийг сайжруулахад тогтмол анхаарч, төсөл, хөтөлбөрүүдийг шат дараатай хэрэгжүүлсээр ирсэн билээ. Мөн харилцагчаа дээдлэгч хамт олныг бүрдүүлэхийн төлөө зорин ажиллаж байна.

2013

Үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэв
2013 оноос эхлэн Үйлчилгээний тусгайлсан алба ажиллуулж, харилцагч нартаа утсаар болон үйлчилгээний төвөөр бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээллийг түргэн, шуурхай хүргэн ажиллаж байна.

2018

Харилцагчдаа улам ойртлоо
Эрүүл мэндийн даатгалын хамгийн их үйлчилгээ үзүүлдэг Интермед эмнэлэг дээр эрүүл мэндийн нөхөн төлбөр болон бусад мэдээлэл, лавлагааны үйлчилгээ үзүүлэх цэг байршин, харилцагч нартаа илүү ойртлоо.



2011–2020

Бүх сувгаар харилцагчтайгаа холбогдож чадна
Харилцагч нарт аппликейшн, чатбот, сошиал болон цахим сувгуудаар мэдээлэл зөвлөгөө хүргэхээс гадна харилцагчийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэн, сэтгэл ханамжийг нь нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.

2019


Илүү тав тухтай үйлчилгээний орчин бүрдүүлээ
Харилцагч нартаа сэтгэл ханамжтай, тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бид 2019 онд шинэхэн үйлчилгээний талбайд нүүж ороод байна. Харилцагч бол МАНАЙ ЗОЧИН гэсэн хандлагаар хүндэтгэн, цай кофегоор дайлж, санал хүсэлтийг нь хүлээн авах, мэргэжлийн түвшинд, чанартай үйлчилгээ үзүүлэхийн тулд уулзалтын хоёр VIP өрөөг үйлчилгээний танхимдаа тусгайлан гаргаж бэлдсэн билээ.



2019 онд ажилтнуудынхаа үйлчилгээний стандартыг сайжруулах, хэвшүүлэх зорилготойгоор “Харилцагчийн мэдрэмжийн менежмент” төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төслийн хүрээнд харилцагч бүрд хурдан шуурхай, мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлэх, байгууллагын талаар эерэг, зөв сэтгэгдлийг төрүүлэх, цаашлаад үнэнч хэрэглэгчийг бий болгохыг зориод байна.

Тус төсөлд нөхөн төлбөр, үйлчилгээний 30 гаруй ажилтан хамрагдаж хувь хүний хандлага, төлөвшил болоод ажлын ур чадвараа дээшлүүлэн ажиллалаа. Мөн төслийн үр дүнд ажлын байр бүрд харилцагчийн үйлчилгээний стандартыг сайжруулан хөгжүүлэх зорилт тавьж, зорилтоо 9,8 хувиар давуулан биелүүлжээ.


ХАРИЛЦАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТЫН ҮНЭЛГЭЭ



ХАРИЛЦАГЧИЙН ХАНДАЛТ

Харилцагчийн дуу хоолойг боломжит бүх сувгаар хүлээн авдаг болсноор 2020 онд харилцагчийн хандалт 49,017 болж өссөн байна. Лавлах төвийн хувьд өмнөх жилээс 18 хувиар өсөж 30,225, үйлчилгээний заалаар үйлчилгээ авсан харилцагчийн тоо 12 хувиар буурч 5,444 болсон бол цахим хандалтын тоо 78 хувиар өсөж 13,348 харилцагчид үйлчилгээ үзүүлсэн байна. Энэ нь харилцагч Үйлчилгээний төвд өөрийн биеэр ирэхгүйгээр даатгалын бүхий л үйлчилгээг авах боломжтой болгох шат дараатай олон ажлуудын үр дүн гарч буйн илрэл юм.

НИЙТ ХАРИЛЦАА ҮҮСГЭСЭН ХАРИЛЦАГЧ, мянган харилцагч



Мөн бид лавлах төв рүү залгаад утас нь тасарсан харилцагч руу эргэн холбогдож харилцагчийн дуудлагыг алдалгүй олон улсын стандартын түвшинд ажиллаж байна.

ЛАВЛАХ ТӨВИЙН ДУУДЛАГА



ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХАРИЛЦАГЧ



Харилцагчийн мэдрэмжийг тодруулах, санал хүсэлтийг хүлээн авах, мэдээллээр хангах зорилготойгоор 2020 онд нийт 21,987 харилцагчтай холбогдон ажилласан байна.

ХАРИЛЦАГЧИЙН ДУУ ХООЛОЙ

Харилцагчийн санал гомдол, харилцагчийн дуу хоолойноос бид компанийнхаа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж, харилцагч төвтэй стратегийн бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Харилцагчийн санал, хүсэлт бүр бидэнд үнэ цэнэтэй.

Тийм ч учраас 2019 онд “Харилцагчийн дуу хоолойг хүлээн авч, шийдвэрлэх журам”-ыг шинэчлэн харилцагчийн санал гомдлыг боломжит бүх сувгаар хүлээн авах, гарч буй гомдлын шалтгааныг бууруулах, дахин гарахаас урьдчилан сэргийлэх ажлууд хийсний үр дүнд харилцагчаас ирэх гомдлын тоо жил ирэх тусам буурсаар байна.

2020 онд харилцагчийн гомдол өмнөх жилээс 38 хувиар буурч, нийт 117 гомдлыг 2,5 хоногт шийдвэрлэж ажилласан.

Мөн бид судалгаа авах замаар харилцагчийнхаа санал, хүсэлтийг сонсдог. 2019 оноос хойш Харилцагчийн замналын судалгаагаар бусад даатгалын компаниудтай үйлчилгээний чанараа харьцуулан судалж, бенчмарк тогтоон ажиллаж байна.

Харилцагчийн замналын судалгаагаар мэдээлэл авах, салбар, онлайн борлуулалтын суваг, хурд, эффорт гэсэн таван бүлэг үзүүлэлтийг бусад даатгалын компанигай харьцуулан судлахад гурван үзүүлэлтээр тэргүүн байранд оржээ.



Харилцагчийн санал хүсэлт, гомдлоор илэрсэн асуудлуудыг Чанарын дэд хорооны хурлаар хэлэлцэж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, процессийг сайжруулах үйл ажиллагаануудыг бүх нэгжүүддээ чанарын даалгавар хүргэх замаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭМЖҮҮР ҮЗҮҮЛЭЛТ

Бид олон улсад харилцагчийн мэдрэмж, сэтгэл ханамжийг тодорхойлоход ашигладаг гол хэмжүүр үзүүлэлтүүд болох Net Promoter Score /NPS/, Customer effort score /CES/, Customer satisfaction score /CSAT/ үнэлгээнүүдийг үйлчилгээний чанарыг хэмжиж, сайжруулах зорилготойгоор нэвтрүүлэн ажиллалаа.

Үүний хүрээнд, Үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн харилцагчдаас NPS буюу Мандал даатгалыг бусдад санал болгох үнэлгээ, лавлах төв болон аппликейшнээр үйлчлүүлсэн харилцагчдаас CES буюу үйлчилгээ авахад хэр хялбар байсан талаарх үнэлгээ авч, харилцагчдынхаа мэдрэмжийг тухай бүр хэмжиж, үйлчилгээгээ сайжруулан ажиллаж байна.

Мөн бид харилцагчийн үйлчилгээний гол хэмжүүр үзүүлэлтүүдийн нэг харилцагчийн асуудлыг эхний хандалтаар шийдвэрлэх үзүүлэлтийг хэмжиж эхлээд байгаа юм.

Эффорт: Харилцагч даатгалын үйлчилгээ авахад гаргаж буй хүчин чармайлт буюу хэр хялбар даатгалын үйлчилгээ авч байгааг хэмжих үзүүлэлт

НӨХӨН ТӨЛБӨР

Бид өнгөрөгч хугацаанд давтагдсан тоогоор 223,000 гаруй харилцагчийн эрсдэлийг удирдаж, 35 гаруй тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгон ажиллалаа.

Мандал даатгал нь 2020 онд нийт 13,604 даатгалын тохиолдолд нийт 7.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгон ажилласан бөгөөд энэ нь өмнөх оноос 44.9 хувиар өссөн үзүүлэлт юм.

Бид 2019 оноос эхлэн даатгалын нөхөн төлбөрийн үйлчилгээг цахим шийдэлд шилжүүлснээр харилцагч үйлчилгээний төвд ирэхгүйгээр нөхөн төлбөрийн үйлчилгээг авах бүрэн боломжтой болсон. Мөн эрх бүхий байгууллагуудын үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж, цагдаагийн газрын тодорхойлолт болон зарим үнэлгээний компанийн тайлан мэдээллийг цахимаар авах боломжтой болсон. Эдгээр технологийн шийдлүүдийн үр дүнд

2013

Нөхөн төлбөрийн алба нь Иргэдийн даатгалын нөхөн төлбөр болон Байгууллагын даатгалын нөхөн төлбөр гэсэн бүтцээр ажиллаж эхэлснээр даатгуулагч нарт тусгайлсан үйлчилгээ үзүүлдэг болов.

2015

Дуудлага мэдээлэл хүлээн авах системтэй болж, харилцагчийн хандалт бүрийг хэмжиж нэгж дуудлага алдалт, дуудуулсан дундаж хугацаа, дуудлагын хугацаа зэрэг нэн шаардлагатай хэмжүүрийг хэмжиж ажилтны гүйцэтгэлтэй уялдуулан үйлчилгээний чанарт анхаарч сайжруулдаг болов.



2019

Харилцагчид зориулан даатгалын үйлчилгээг гар утсаараа авч болох олон үйлдэлт, ухаалаг МАНДАЛ АПП мобайл аппликейшнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.



2017

Салбартаа анх удаа ослын Шуурхай дуудлагын үйлчилгээнд скүүтер ашиглаж эхлэв. Ингэснээр ослын газарт очих хугацааг 50-80 хувиар бууруулж чадсан.



харилцагчид хүрэх нөхөн төлбөрийн үйлчилгээ хүртээмжтэй, хялбар болж, даатгуулагчид нөхөн төлбөрөө цаг тухай бүрд авдаг болсон нь дээрх өсөлтөд тодорхой хэмжээгээр нөлөөлжээ.



Мөн 2020 онд гарсан цар тахлын улмаас орон нутагт чиглэсэн дотоодын аяллын тоо өсч, орон нутгийн замд гарах зам тээврийн ноцтой ослын тоо нэмэгдэж, тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрийн тоо болон дүн өсөхөд тус тус нөлөөлсөн байна.

НӨХӨН ТӨЛБӨР ШИЙДВЭРЛЭХ ХУРД

Нөхөн төлбөр шийдвэрлэх үйл ажиллагааны хурдыг бид өнгөрсөн онуудад хоногоор хэмждэг байсан бол 2020 онд шинэ зорилт дэвшүүлэн, цагаар хэмжиж ажилласан.

2019 оны 4 дүгээр улиралд нөхөн төлбөр шийдвэрлэх хурд дунджаар 5,2 хоног байсан бол дотоод зохион байгуулалт, процессийн өөрчлөлт хийснээр 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар 3,1 хоногт хүрч өнгөрсөн оноос 41 хувиар буурсан амжилттай байна. Мөн 2020 оны 4 улиралд нийт нөхөн төлбөрийн 49 хувийг ажлын 8 цагт шийдвэрлэн ажилласан бөгөөд энэ онд дээрх хувь хэмжээг нэмэгдүүлэн ажиллахаар зорьж байна.


2020 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР



Эрүүл мэндийн нөхөн төлбөр

Жаргалан эрүүл мэндийн даатгалыг 2015 онд зах зээлд нэвтрүүлснээс хойш бид 21,600 гаруй харилцагчид нийт 6.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож, харилцагч нартаа эрүүл мэндийн эрсдэлийг санхүүгийн хүндрэлгүй давах боломжийг олгосон байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН ТОО



Бид эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөрийн материалыг Мобайл АПП, Үйлчилгээний төв болон эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ авдаг сүлжээ 13 эмнэлгийн тусгай нөхөн төлбөрийн материал хүлээн авах хайрцгаар дамжуулан 24/7 хүлээн авдаг. Өнгөрөгч онд бид эрүүл мэндийн даатгалын нөхөн төлбөрийн 70 хувийг Мандал АПП-аар дамжуулан онлайн-аар шийдвэрлээд байна.


ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

Өнгөрөгч онд Мандал АПП мобайл аппликэйшнд хоёр удаагийн сайжруулалт, хөгжүүлэлтийг хийсэн нь бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт удаа дараа шилжсэн хүндхэн цаг үед харилцагчдынхаа өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, нөхөн төлбөрийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэлээ.

2020 онд нийт нөхөн төлбөрийн материалын 70 хувийг цахимаар шийдвэрлэснээс 26 хувийг аппликэйшнээр, бусад цахим сувгаар 44 хувийг хүлээн авсан. Энэ нь харилцагчид цахим үйлчилгээнд шилжиж, нөхөн төлбөрийн материалаа хялбархан илгээж чаддаг болсныг харуулж байна.

2020 оны 11 сарын 12-оос 2020 оны 12 сарын 31-г хүртэл хатуу хөл хорио тогтоосон үед шуурхай дуудлагын алба нь нийт 1,735 даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч, аппликэйшнээр болон цахимаар баримтжуулж, 959 сая төгрөгийн нөхөн төлбөрийг түргэн шуурхай шийдвэрлэж, даатгуулагчийнхаа эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан эрсдэлийг хамгаалан ажилласан билээ.

Цар тахлын улмаас тогтоосон хөл хорионы үед манай ажилтнууд зайнаас ажиллахаар техник технологийн шийдлүүдээ урьдчилан бэлдсэн байсны үр дүнд харилцагчид ямар ч чирэгдэл учруулалгүй үйлчилгээгээ тасралтгүй хүргэж чадсан.



ҮЙЛ АЖИЛЛАГАА BACK OFFICE



“ Бид үйл ажиллагаагаа олон улсын түвшинд хүргэхийн тулд хамтын ажиллагаагаа улам сайжруулж, процессуудаа автоматжуулах, харилцагчдад илүү хялбар болгох, ажилтнуудынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхээр ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм харилцагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч түншүүддээ Мандал даатгалын 10 жилийн ойн мэндийг хүргэж, хамтран ажиллаж буйд талархал илэрхийлье!

Монгол Улсад даатгалын салбарын хөгжлийн түвшин доогуур, удаашралтай байгаа хэдий ч даатгал хөгжсөн бусад улс орнуудаас суралцах, тэдгээрийн туршлагыг нутагшуулж үйлчилгээгээ сайжруулах боломж маш их байгаа нь харагддаг. Тухайлбал, АНУ, Европын орнуудад даатгуулагч даатгалын компани дээр биеэр очилгүй даатгалаа хийлгэж, нөхөн төлбөрийн үйлчилгээ авдаг. Мөн даатгуулагчийн эд хөрөнгөд учирсан хохирлын дүнг хүний оролцоогүйгээр хиймэл оюун ухааны тусламжтайгаар тодорхойлдог болжээ. Олон улсын энэхүү түвшинд хүргэхийн тулд бид хамтран ажилладаг байгууллагуудтайгаа хамтын ажиллагаагаа улам сайжруулж, үйл ажиллагаагаа автоматжуулах, харилцагчдад илүү хялбар болгох, ажилтнуудынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхээр хичээн ажиллаж байна.

2020 он хөл хориотой, эдийн засгийн идэвх муу хэдий ч бид энэ үеийг баг, хамт олныхоо ур чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийн үйл ажиллагаагаа сайжруулахын тулд мэргэшүүлэх, чадавхжуулахад чиглэсэн гадаад, дотоодын нийт 286 цагийн 70 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна.

Мөн хөл хорионы үед харилцагчдад нөхөн төлбөрийн үйлчилгээг цаг алдалгүй

аппликейшнээр дамжуулан үзүүллээ. Аппликейшнээр үйлчилгээ үзүүлж эхэлснээс хойш Үйлчилгээний төвд ирж үйлчилгээ авдаг харилцагчдын тоо хоёр дахин буурчээ.

2020 онд бид борлуулалт, захиргаа, хүний нөөц, нөхөн төлбөр шийдвэрлэлтийн гурван төрлийн дотоод программыг хөгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Үүний үр дүнд тухайн үйл ажиллагаануудын бүтээмж ойролцоогоор 20-30 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Өнгөрөгч онд бид компанийн дотоод үйл ажиллагаа, процессуудаа Чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартад нийцүүлэх ажлыг зохион байгууллаа. Дараагийн жилүүдэд энэ ажлын үр дүн гарч манай дотоод үйл ажиллагааны үр ашиг, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар улам сайжирна гэдэгт итгэлтэй байна.

Бидэнд итгэж эрсдэлээ шилжүүлсэн харилцагчдадаа олон улсын стандартад нийцсэн, чанартай үйлчилгээ үзүүлэхийн төлөө цаашид илүү хичээн ажиллах болно.



П.ОРГОДОЛ

Үйл ажиллагаа хариуцсан захирал


ХҮНИЙ НӨӨЦ

Эерэг хандлага, хичээл зүтгэл, хүсэл эрмэлзэл бүхий бүтээмжтэй ажилтан нь манай компанийн өрсөлдөх чадварын үнэ цэнэтэй хүчин зүйл юм.

Мандал даатгал ХК нь “Өнөөдрөө баталгаажуулсан маргаашийг иргэн бүрд” эрхэм зорилгын хүрээнд нэгдэж, компанийн зорилготой өөрийн зорилгыг уялдуулан хамтдаа, тасралтгүй өсөн дэвжих хүсэл эрмэлзэлтэй, бүтээлч, эрч хүчтэй, чадварлаг хамт олныг бүрдүүлж, тэднийгээ тогтвортой хөгжүүлэн ажиллахыг зорьдог билээ.

Манай компанийн амжилтын үндэс нь чадварлаг, мэргэшсэн, бүтээлч ажилтнууд юм. Бид өдөр тутмын ажилдаа компанийн гол зарчим болох дөрвөн үнэт зүйлс, 24 зарчмаа баримтлан ажилладаг бөгөөд компанийн хүний нөөцийн бодлого, шагнал урамшууллын систем, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа зэрэг нь үнэт зүйлсээ хэрэгжүүлэхтэй уялдсан байдаг.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОО БАРИМТУУД



СУРГАЛТ ХӨГЖИЛ

Нийт


286 > 70

сургалт

цагийн

Сургалтын
дундаж
үнэлгээ

93.3%



Сургалтын нийт
оролцоо

94%

Нэг ажилтанд
ногдох дундаж
цаг

21.8



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, КАРЬЕР ХӨГЖИЛ

Мандал даатгал нь ажил горилогчийг сонгон шалгаруулж, ажилд авахдаа тухайн ажлын байрны ажил үүргийн онцлог, тавигдах шаардлагад тулгуурлан ур чадвар, ажлын туршлагаас гадна ажил хийх хүсэл эрмэлзэл, эерэг, бүтээлч хандлагад тулгуурлан сонгон шалгаруулдаг. Эерэг хандлагатай, өөрийгөө сорих, ирээдүйд өсөн дэвших, тогтвор суурьшилтай ажиллах чин хүсэл эрмэлзэлтэй залууст мэргэжил харгалзахгүйгээр ажилд орох боломж манай компанид үргэлж нээлттэй байсаар ирсэн.

Бид сонгон шалгаруулалтыг явуулахдаа ажил горилогч бүрд тэгш боломж олгохын зэрэгцээ үнэт зүйлсийнхээ үндсэн зарчимд тулгуурлан шударга, ил тод, нээлттэйгээр явуулдаг. Мөн шинээр ажилд орсон ажилтнуудад ажлын анхны өдрийн эерэг сэтгэгдлийг төрүүлэх, ажлаа амжилттай эхлүүлэх, байгууллагын соёл, компанидаа дасан зохицоход нь дэмжлэг болох, чиглүүлэх, дадлагажуулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, туршлагатай зөвлөгч нар сургаж, хамтран ажиллах боломжийг олгож байна.

Мандал даатгал нь ажилтнуудынхаа карьер төлөвлөлтийн замнал, зураглалыг дөрвөн ажлын бүлгээр дэлгэрэнгүй гаргаж, гурав хүртэлх ажлын байран дээр карьер төлөвлөлт хийх боломжийг олгон, ажилтан бие даан суралцах болон хүний нөөцийн бодлогоороо дэмжлэг үзүүлэн, ур чадваржуулах, тусгайлсан програмаар хөгжүүлэх зэргээр ажилтнуудаа хөгжүүлэн, хамтран ажилладаг. Үүний үр дүнд ажилтнуудын мэдлэг, ур чадвар, ажил үүрэгт нь тохирсон цалин, урамшууллыг олгодог нь ажилтнуудын сэтгэл ханамж, бүтээмжид эерэг нөлөө үзүүлсээр иржээ.

ХАМТ ОЛНЫ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Бид ажлын байрны тав тухтай орчин, ажлын цагийн уян хатан нөхцөл, салбартаа өрсөлдөхүйц цалин, урамшуулал, спорт урлагийн арга хэмжээ зэрэг ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшинг ямагт дээшлүүлэхийг зорин, улирал тутам олон нийтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хэрэгжүүлж ажилладаг.

2020 онд Монгол Улсад төдийгүй дэлхий даяар цар тахлаас үүссэн цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч манай компани зайнаас ажиллах боломжийг судлан, ажлын байрны

Э.БАЗАРВААНЬ

Бизнес хөгжил хариуцсан менежер



Анх 2016 онд “Бизнес шинжээч” албан тушаалд ажилд орсон. Ажилд орохдоо “mass hiring” технологийн олон шалгалтыг давж, хэдэн зуун залуусаас арав орчим залуусын тоонд багтаж ажилд орсон. Уг албан тушаалд ажиллаж байхдаа “Монгол улсын эрсдэлийн индекс” анх удаа тооцоолон гаргаж байсан. 2018 оноос Бизнес хөгжлийн менежерийн албан тушаалд дэвшиж байгууллагын зах зээлрүү түлхүү ажиллаж, шинэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Мөн эрүүл мэндийн даатгалыг хариуцан тухайн бүтээгдэхүүний сайжруулалт, шинэчлэлтүүдийг хийж гүйцэтгэн, өдгөө хувийн эрүүл мэндийн даатгалын зах зээлд №1 тоглогч байр суурь хадгалан ажиллаж байна. Үүнтэй адил хэд хэдэн төслийг амжилттай гүйцэтгэсний дараагаар 2020 онд Бизнес хөгжлийн хэлтэс хариуцсан менежер лүү дэвшин ажиллаж байна.

Миний хувьд банкны салбараас карьерын өөрчлөлт хийж, даатгал салбарт тэр тусмаа Мандал даатгал ХК-д ажилласандаа баяртай байдаг. Учир нь манай байгууллага залуучуудад өөрийгөө харуулах, ажлын амжилт үзүүлэх боломжийг бүрэн дүүрэн олгодог. Жишээлбэл, бүтээгдэхүүн хөгжүүлэх, үйлчилгээ сайжруулах зэрэг шинэ санаачлага гаргах боломж бүх хүнд нээлттэй. Тэрхүү боломжийг ашиглаж амжилттай ажилласан ажилтнуудад карьер хөгжил, албан тушаал дэвших асуудлууд нээлттэй байдаг ба үүний илрэл нь манай байгууллагын ихэнх захирал, менежерүүд дотроосоо дэвшсэн байдгаас харагддаг.

уян хатан байдал болон технологийн шийдлийг нэвтрүүлэн ажиллалаа. Үүний үр дүнд ажилтнуудаа 100% зайнаас ажиллах боломжоор ханган, сургалт, хурал, уулзалтыг онлайнар зохион байгуулах техник, програмын боломжуудыг нэвтрүүлсэн. Мөн цаашдаа онлайн оффисыг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Хамт олны уур амьсгал, багийн ажиллагааг сайжруулах зорилгоор уламжлалт урлаг спортын арга хэмжээг цаг үеийн байдалтай уялдуулан амжилттай зохион байгууллаа.

8-11 сарын хугацаанд нийтдээ есөн төрлийн урлаг, спортын арга хэмжээг амжилттай зохион байгуулж, Шилдэг баг хамт олноо шагнаж урамшуулсан байна.

Ажилтнуудын идэвх санаачлага, багийн ажиллагааг дэмжин, клубын системийг нэвтрүүлэн таван клуб идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр клуб нь компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бүтээлч ажлуудыг хийж гүйцэтгэхээс гадна ажилтнуудын идэвх оролцоог сэдэлжүүлэх ажлуудыг зохион байгуулдаг.



А.УНДРАЛ

Санхүүгийн ахлах шинжээч



Манай компани ажилчиддаа сурч хөгжих, өсөж дэвших, ирээдүйдээ итгэлтэй ажиллах боломжийг тэгш олгодог. Жишээлбэл, үндсэн ажлынхаа хажуугаар компанид хэрэгжиж буй төслийн ажлын багт оролцох, урамшуулал авах, хүсэл сонирхлоороо нэгдэн сайн дурын клуб байгуулан үйл ажиллагаа явуулах, ажлын цагаа уян хатан сонгох, өөрийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдах, тушаал дэвшиж карьер ахих гэх мэт олон боломжууд бүх ажилчдад нээлттэй байдаг.

Би анх 2018 онд Мандал даатгал ХК-д Бизнесийн шинжээчээр ажилд орсон ба одоо гурав дахь жилдээ ажиллаж байна. Ажиллах хугацаандаа компанийнхаа олгосон эдгээр боломжуудыг ашиглан олон зүйлсийг сурч, олон талаар өөрийгөө хөгжүүлж Ахлах санхүүгийн шинжээч болон тушаал дэвшсэн. Мөн үндсэн ажлаасаа гадна компанийн хэмжээнд хоёр том төслийн ажлын багт оролцон, амжилттай хэрэгжүүлсэн ба уг ажлуудын үр дүнд 2020 оны шилдэг ажилтнаар шалгаран үнэ цэнэ бүхий шагналыг хүртсэн нь надад маш их урмыг өгсөн. Манай компани бол сурч хөгжих чин хүсэл эрмэлзэлтэй, эрч хүчтэй залуусыг нэг зорилгын доор нэгтгэн, зөв чиглүүлэн бүх талаар нь дэмжин сургаж хөгжүүлж, олон гайхалтай боломжийг олгож ажилладаг маш орчин үеийн, чөлөөтэй, зөв тогтолцоотой компани гэж би боддог.

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2020 онд бид төлөвлөлт, үнэлгээний системийг нэвтрүүлэн, нэгж, ажилтны түвшинд улирал тутамдаа ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг үнэлэн, ажил үүргээрээ манлайлсан шилдэг нэгж, шилдэг ажилтнаа шалгаруулж урамшуулдаг.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд COOL стратегийг хэрэгжүүлэн, Mandal chart онооны системийг нэвтрүүлсэн. Mandal chart нь ажилтнуудын ажлын гүйцэтгэл, санал санаачлага, олон нийтийн ажлын идэвх оролцоо, бүтээмжээр ажилтнуудыг ил тод, нээлттэй онооны системээр өрсөлдүүлэн, жилийн эцэст компанийн үнэт зүйлсийг шингээсэн шилдэг ажилтныг шалгаруулах онооны систем юм. Компанийн үнэт зүйлсийг шингээсэн шилдэг ажилтнуудаа цом, мөнгөн шагнал, гадаадад аялах эрх болон ТОП ажилтнуудаа мөнгөн шагналаар шагнаж урамшуулдаг уламжлалтай.

КОМПАНИЙН ҮНЭТ ЗҮЙЛСИЙГ ШИНГЭЭСЭН ШИЛДЭГ АЖИЛТНУУДЫН ЦОМ

ОНЫ ХАРИУЦЛАГАТАЙ
ГИШҮҮН

ОНЫ ТҮҮЧЭЭ



ОНЫ БАГИЙН ТОГЛОГЧ

ОНЫ SERVICE
EXCELLENCE АЖИЛТАН

2020 онд Борлуулалтын нэгжийн борлуулалтын төлөвлөгөө болон гүйцэтгэлээрээ манлайлсан ажилтнуудаа урамшуулан дотооддоо аялах эрхийг олгон, Хөвсгөл далай, Сайханы хөтөл зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудаар аялуулаад байна.



СУРГАЛТ ХӨГЖИЛ, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО

Сургалт хөгжил

Бид жил бүр “Сургалт хөгжлийн бодлого”-ын хүрээнд байгууллагын зорилтуудыг биелүүлэхэд хаана, хэнд, ямар сургалт хэрэгцээтэй байгааг тодорхойлж түүнд тулгуурлан ажилтнуудаа сургалтанд хамруулдаг нь мэдлэг, ур чадварын түвшинг нэмэгдүүлэх улмаар илүү оновчтой сургалт зохион байгуулахад бодит үр дүн болдог.

2020 онд удирдлагын багийн болон борлуулалтын багийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, мэргэшсэн болон багийн ур чадварыг сайжруулах багц сургалтуудыг амжилттай зохион байгууллаа.

Борлуулалтын багийн борлуулалтын арга техникийг сайжруулах, харилцагчийн үйлчилгээний стандарт, мэдлэгийг дээшлүүлэх багц сургалтыг зургадугаар сарын сүүлээр мэргэжлийн зөвлөх багш нартай хамтран зохион байгуулсан.

Удирдлагын багийн ур чадварыг сайжруулах, хөгжүүлэхтэй холбогдуулан “Шинэ үеийн манлайллын арга барил” сэдэвт гурван өдрийн сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, гурван сарын туршид хувийн ур чадварыг нэмэгдүүлэх гэрийн даалгавруудыг гүйцэтгэн, гэрийн даалгаврын гүйцэтгэлээр сургалтын үр дүнг үнэлэн, өндөр гүйцэтгэлтэй удирдлагуудыг урамшуулан ажиллалаа.



Урамшууллын бодлого

Мандал даатгал нь ажилтнуудаа үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллуулах, олон жил ажилласан ажилтнууддаа компаниас өгөөж хүртээх зорилгоор Хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр, Хуримтлалын нэрийн дансны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр иржээ. Ажилтан ажиллах хугацаандаа хуримтлал үүсгэснээр компаниас тодорхой хэмжээгээр хувь хүртэн, санхүүгийн хэрэгцээт үедээ тус хуримтлалаа ашиглах боломжтой байдаг.

Г.ХЭРЛЭН

Нөхөн төлбөрийн менежер

БНХАУ болон Австри улсад мэргэжил дээшлүүлэх сургалт хөтөлбөрүүдэд хамрагдан суралцаж ирээд, анх 2018 онд Эрүүл мэндийн нөхөн төлбөрийн мэргэжилтнээр ажилд орж, 2020 оны 11-р сараас Нөхөн төлбөрийн менежерээр дэвшин ажиллаж байна. Анх ажилд орохдоо даатгалын салбарын талаар ямар ч мэдлэггүй байсан. Гэхдээ компанийн маань соёл, манлайлал, процессийн ойлгомжтой байдал зэрэг нь нэгэнт бүрэлдэн тогтсон учраас шинэ ажилтны хувьд компаниа ойлгох, хариуцсан ажлаа үр бүтээлтэй хийж гүйцэтгэхэд маань их тус дэм болсон.

Манай хэлтэс эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнүүдийн нөхөн төлбөрийн тооцоолол, харилцагчийн халамж үйлчилгээ зэргийг хариуцан ажилладаг бөгөөд харилцагчдынхаа эрүүл мэнд, сэтгэл ханамжийг эн тэргүүнд тавьж ажилладаг хариуцлагатай, ур чадвар шаардсан ажил. Тиймээс миний ажил бол энгийн нэг менежер бус харилцагчдын маань эрүүл мэнд, тэр бүү хэл амь настай холбоотой чухал шийдвэрүүдийг гаргадаг гэдгийг өглөө ажилдаа ирэх бүртээ санаж, анагаах ухаанд суурилсан мэргэжлийн байх зарчмыг үргэлж баримтлан ажилладаг.



Түүгээр зогсохгүй компанийн түлхүүр ажлын байр болон түлхүүр ажилтнуудад зориулсан тусгайлан дэмжих хөтөлбөр, хангамж урамшууллыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Компанийн үнэ цэнэ нь эрүүл чийрэг, эрч хүчтэй, бүтээмж дүүрэн ажилтан байдаг тул нийт ажилтнуудаа “Жаргалан эрүүл мэндийн даатгал”-д үнэ төлбөргүй хамруулахын зэрэгцээ гэр бүлийн гишүүдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр даатгуулах, Монгол Улсын хувийн томоохон 13 сүлжээ эмнэлэг болон улсын бүх эмнэлгээс эмчилгээ, үйлчилгээ авах, урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд хамрагдах зэрэг боломжоор ханган ажилладаг билээ.

Бид 2020 онд нийт 128 үндсэн ажилтнаа эрүүл мэндийн даатгалд, 60 ажилтнаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдуулсан ба 103 ажилтан томуугийн вакцинд хамрагдсан бол давхардсан тоогоор 73 тохиолдолд нөхөн төлбөр олгосон байна.

Ажилтнуудын бүтээлч хандлага

Ажилтнуудынхаа бүтээмжийг сайжруулах, бүтээлч сэтгэлгээг нь дэмжих зорилгоор шинэ санал санаачлагыг хүлээн авч, хэрэгжүүлэх системийг бий болгоод байна. 2020 онд ажилтнуудаас нийт 50 орчим шинэ санал санаачлага ирүүлснээс гурван шинэ санаачлагыг авч хэрэгжүүлэн, ажлын бүтээмжээ нэмэгдүүлэхээр ажиллаж байна.



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Бид даатгалын салбарын тэргүүлэгчийн хувьд Монгол Улсын даатгалын салбарт дижитал шилжилтийг нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Мандал даатгал нь технологийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж, орчин үеийн технологи дээр суурилсан дата төв, програм хангамж, дэд бүтцийг стандартын дагуу бий болгон үйл ажиллагаандаа ашиглаж ажиллахыг зорьдог. Үүний хүрээнд мэдээллийн аюулгүй байдал, програм хангамжийн чиглэлээр дараах ажлууд хийгдэж байна.

Систем сүлжээний тасалдал
доголдолгүй ажилласан байдал

99.5%



*Программ хангамжийн
тусламжтайгаар
хэмнэсэн хүн цаг*

Дотоод үйл
ажиллагаанд
11,500
хүн цаг



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Байгууллагын үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр харилцагчийн дата мэдээллийг аюулгүй байлгах нь нэн тэргүүнд анхаарах ёстой ажил юм. Үүний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

- Бүх систем, програм хангамж, сүлжээний аюулгүй байдлыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар шат дараалсан шалгалтуудыг хийлгэж, илэрсэн эмзэг байдлуудыг засварласан. Уг шалгалтын үр дүнд бүх систем, програм хангамжууд дээрх харилцагчийн түүхэн мэдээллийн баазыг найдвартай, тасалдалгүй байх ажиллагааг нэмэгдүүлсэн.

- Нийт ажилтнуудад мэдээллийн технологийн аюулгүй байдлын хүрээнд мэдвэл зохих мэдлэгийн сургалтыг тогтмол хийхээс гадна шинэ ажилтнуудын чиглүүлэх сургалтанд мэдээллийн аюулгүй байдлын талаар заадаг болсон. Үүнээс гадна мэдээллийн аюулгүй байдлын сургалтын үр дүнг бодит орчныг бүрдүүлэн, шалгалт авч хэмжиж байна.
- Байгууллагын хэмжээнд гадаад болон дотоод сүлжээгээр дамжиж буй мэдээллийн урсгалаа Next generation firewall төхөөрөмжөөр бүрэн хяналтад оруулж, гадны халдлагаас гадна байгууллага дотор зүй бус үйлдлүүдийн тухай бүрэн илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авдаг болсон.
- Програм хангамжуудын онцлогт тохируулан аюулгүй байдлын шийдлүүд хийгдсэн. Жишээлбэл, вэб дээр суурилсан бүх програм хангамжуудаа “web application firewall”-ыг ашиглан хамгаалж, цахим и-мэйл аюулгүй байдлын “Microsoft online protection” програмыг ашиглан тасалдалгүй найдвартай ажиллагааг хангасан. Мөн програм хангамжийн өгөгдлийн сан болон эх кодуудыг local storage, cloud storage дээр давхар нөөцлөх ажлыг өдөр тутамдаа хийж байна.
- Байгууллагын хэмжээнд 100 хувь зайнаас ажиллах шаардлагатай үед мэдээллийн аюулгүй байдлыг хангасан цогц шийдлийг бүрэн нэвтрүүлж, онлайн хурал уулзалтын шийдлийг Microsoft teams-ыг ашиглан шийдэв.
- Компьютерын аюулгүй байдлын хүрээнд end point security-ын тусламжтайгаар вирус, гадны халдлага, компьютер хард дискны нууцлал, хамгаалалтын шийдлийг нэвтрүүлээд байна.

ПРОГРАМ ХАНГАМЖ

Байгууллагын хэмжээнд дижитал шилжилт хийхийн тулд дараах томоохон ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- Цахим үйлчилгээ төслийн хүрээнд хэрэглэгчийн аппликейшн нэвтрүүлснээр харилцагч ослын үеийн баримтжуулалтыг түргэн шуурхай бүрдүүлэх, гэрээний мэдээллээ лавлах, сунгах, цуцлах, санал хүсэлт өгөх, байгууллагын зүгээс харилцагч руу чиглэсэн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээллүүдийг түргэн шуурхай хүлээн авах боломжтой цогц системийг бий болгосон.
- Онлайн борлуулалтыг нийтийн сүлжээ, fintech дээр суурилсан програм хангамжуудыг ашиглан онлайн даатгал худалдан авах боломжуудыг нэмснээр фэйсбүүк чатбот, Голомт банкны Social pay, Most money апп зэрэг платформуудыг ашиглан даатгалын бүтээгдэхүүнээ шууд худалдан авах боломжоор хангав.
- Даатгалын мэргэжилтнүүд хураамжийн тооцоолуурыг ашиглан харилцагчид түргэн шуурхай цахим андеррайтеринг хийж, даатгалын хураамжийн санал гарган өгөх боломжуудыг нэвтрүүлснээр андеррайтерийн ачааллыг тодорхой түвшинд бууруулж чадлаа.
- Шуурхай дуудлагын ажилтнаас нөхөн төлбөрийг шийдвэрлэх процесс, санхүүгийн гүйлгээ хийх хүртэлх бүх процессууд дээр цахим шийдлийг нэвтрүүлснээр нөхөн төлбөрийн алхам бүрийг хэмжих, шийдвэрлэх хурдыг нэмэгдүүлж чадсан.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Бид бусдын эрсдэлийг шилжүүлэн авч удирдахын суурь чадамж нь өөрийн эрсдэлийг удирдах явдал гэж үзэн, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулдаг.

Мандал даатгал нь урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгохын тулд эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. Даатгалын компани нь бусдын эрсдэлийг өөртөө хүлээн авах, өөрийн дааж чадах хэмжээнээс илүү эрсдэлийг давхар даатгалд шилжүүлэх үндсэн үйл ажиллагаа явуулдгийн хувьд компанийн өөрийн эрсдэлээ удирдах нь бидний зайлшгүй үүрэг, хариуцлагын нэг гэж үздэг.

Solvency ratio

161%

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа

Хохирлын харьцаа

42%

Учирсан хохирлыг орлогод харьцуулсан харьцаа

Дотоод процессийг Чанарын менежментийн



ISO 9001:2015

стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулав.

Мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж

Хангалттай



үнэлгээ авав.

ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн эрсдэлийн бодлогыг хэрэгжүүлэх, эрсдэлийг удирдах соёлыг бий болгоход менежментийн зүгээс анхаарч, чиглүүлэн ажилладаг. Эрсдэлийн удирдлагын бодлогыг ТУЗ баталдаг бөгөөд 2020 онд илүү сайжруулан баталлаа.

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд компанийн удирдлага, ажилтнууд дараах үүрэгтэйгээр оролцдог.

Оролцогч тал

Үүрэг, хариуцлага

01	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ	<ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлагын бодлогыг батлах
02	УДИРДЛАГЫН ХОРОО /УХ/	<ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх нөөц бололцоогоор хангах Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, соёлыг бий болгох Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг тогтмол хянах Улирал бүр эрсдэлийн тайлантай танилцаж компанийн дотоод нэгж, ажилтнуудад зөвлөмж, үүрэг даалгавар өгөх
03	ЭРСДЭЛИЙН МЕНЕЖЕР	<ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлагын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх тасралтгүй сайжруулах Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Эрсдэлийн тайланг нэгтгэж УХ-нд танилцуулах Эрсдэлийн бүртгэлийг нэгтгэж хөтлөх, эрсдэлийн мэдээллийн санг бий болгох Эрсдэлийн удирдлагын талаар ажилтнуудад сургалт орох, ажилтнуудыг эрсдэлийн мэдлэг мэдээллээр хангах
04	НЭГЖИЙН УДИРДЛАГА, МЕНЕЖЕРҮҮД (Газрын захирал, хэлтэс болон функц хариуцсан менежерүүд)	<ul style="list-style-type: none"> Хариуцсан нэгж, үүрэг, функцийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх Хариуцсан нэгж, үүрэг, функцийн эрсдэлийн тайланг УХ-нд танилцуулах Эрсдэлийг таних, мэдээллэх соёлыг бий болгох
05	АЖИЛТАН	<ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлагын бодлого болон процессыг дагаж мөрдөх, төлөвлөгөөг хэрэгжүүлэх Эрсдэлийг мэдээллэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
06	ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦСАН МЕНЕЖЕР	<ul style="list-style-type: none"> Эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийг хянах

ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

Эрсдэлийг компанийн үндсэн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай уялдуулан дараах төрлүүдэд ангилдаг.

ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

Андеррайтингийн эрсдэл	Багцын эрсдэл Бүтээгдэхүүний болон газарзүйн байршлын хувьд хэт төвлөрөх эрсдэл	Нөхөн төлбөрийн эрсдэл Даатгалын бүтээгдэхүүнүүдийн хохирлын харьцаа тохиромжит түвшнээс их гарах эрсдэл	Давхар даатгалын эрсдэл Компанийн өөрийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөх түвшнээс (risk appetite) давсан эрсдэлийг давхар даатгалд байршуулж чадахгүй байх, давхар даатгалын гэрээ ба дотоод гэрээний зөрүү үүсэх, давхар даатгагч төлбөрийн чадваргүй болох зэрэг эрсдэл	
Хөрөнгө оруулалтын эрсдэл	Хөрөнгө оруулалтын өгөөж зорилтот түвшинд хүрэхгүй байх, хөрөнгө оруулалт дефолт болох эрсдэл	Хөрвөх чадвар, хөрөнгийн менежментийн эрсдэл	Компанийн төлбөрийн чадварын харьцаа муудах, мөнгөн хөрөнгийн дутагдлын улмаас үйл ажиллагаа доголдох эрсдэл	
Зах зээл, эдийн засгийн эрсдэл	Эдийн засгийн эрсдэл Гадаад болон дотоод эдийн засгийн орчин, нөхцөл байдал муудах, худалдан авагчдын орлого буурах эрсдэл	Борлуулалт, өрсөлдөөний эрсдэл Борлуулалт буурах, цөөн тооны борлуулалтын сүвгээс хамааралтай болох, цөөн тооны томоохон харилцагчдаас хамааралтай болох, зорилтот харилцагчдаа алдах, өрсөлдөөний улмаас хураамжийн хувь буурах зэрэг эрсдэл		
Үйл ажиллагааны эрсдэл	Үндсэн хөрөнгийн болон үйл ажиллагаа тасалдах эрсдэл Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлс, гадны нөлөө болон бусад хүчин зүйлсийн улмаас оффисын барилга галд өртөх, нурах, эвдэрч гэмтэх, сантехникийн эвдрэл үүсч ус алдах, хөлдөлт үүсэх, хулгайд өртөх болон оффист цахилгааны гэмтэл үүссэний улмаас цахилгаан тасрах, цахилгаан хэрэслүүд шатах зэрэг үйл ажиллагаа түр болон урт хугацаагаар тасалдах эрсдэл	Мэдээллийн технологийн эрсдэл Компанийн програм хангамж, систем, серверийн аюулгүй байдал доголдох, систем нийлүүлэгч компани гэрээгээ цуцлах, систем тодорхой хугацаагаар ажиллахгүй болох, сервер эвдэрч гэмтэх, ажилтны компьютер шатах, компанийн дата, эх код, алдагдах, устах зэрэг эрсдэл	Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл Компанийн "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам" зөрчигдөх буюу ажилтны санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас компанийн дотоод мэдээлэл гадагш алдагдах зэрэг мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэл	Хүний нөөцийн эрсдэл Компанийн эрх бүхий болон түлхүүр ажилтан гэнэт ажлаас гарах, хүндээр өвдөх, ажил эрхлэх боломжгүй болох, мөн нэгэн зэрэг олон ажлын байр ажилтангүй байснаар компанийн өдөр тутмын үйл ажиллагаа доголдох, бүтээмжид нөлөөлөх зэрэг хүний нөөцтэй холбоотой эрсдэл
Хууль, зохицуулалтын эрсдэл	Компани холбогдох хууль, журам зөрчих, бүтээгдэхүүн борлуулах эрхээ алдах, үйл ажиллагаагаа бүр болон түр хугацаагаар хаалгах, компанийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй хууль, журам батлагдах эрсдэл		Нэр хүндийн эрсдэл	Дээрх бусад эрсдэл болон бусад шалтгааны улмаас компанийн нэр хүнд унах, хуурамч цуу яриа олон нийтийн сүлжээгээр тархах, үүний улмаас компанийн орлого буурах, зах зээлд эзлэх байр сууриа алдах эрсдэл

Эрсдэлийг бүтэн дүр зургаар харж тодорхойлох, урьдчилан сэргийлэх, удирдах нь компанийн эрсдэлийн бодлогын гол зорилго юм. Тиймээс дээрх эрсдэлүүдээс гадна шинээр бий болж буй болон гэнэтийн эрсдэлүүдийг тодорхойлж, удирдах нь эрсдэлийн удирдлагын чухал хэсэг байдаг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД

- Компанийн хувьд 2020 оны голлох эрсдэл нь Ковид-19 вирусээс үүдэлтэй эдийн засгийн өсөлт саарч, бизнесийн идэвхжил буурсан явдал байлаа. Ковид-19 дэлхийн улс орнуудад эрчимтэй тархаж эхэлсэн 2020 оны 3-р сараас эхлэн бид энэ эрсдэлээс урьдчилан сэргийлэх, удирдах ажлаа эхлүүлж 4-р сард “Ковид-19 вирусийн үед ажиллах төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж ажилласан. Уг төлөвлөгөөндөө Ковид-19 вирусийн тархалт эдийн засагт ямар нөлөө үзүүлж болох талаар сценар таамаглалуудыг дэвшүүлж, тухай бүрд нь хэрэгжүүлэх арга хэмжээг дотооддоо тодорхойлон ажилласан.
- Даатгалын компанийн хувьд харилцагчаас шилжүүлж авсан эрсдэлийг өөрийн дааж чадах эрсдэлийн түвшингээс давсан хэсгийг давхар даатгалд шилжүүлэх нь эрсдэлийн удирдлагын чухал хэсэг байдаг. Үүний хүрээнд бид 2020 онд трити давхар даатгалын гэрээгээ сунгах, факультатив давхар даатгалуудыг хугацааны хоцрогдолгүйгээр, тухай бүрд нь давхар даатгалд байршуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа. 2020 онд бид эрүүл мэндийн даатгалын чиглэлээр давхар даатгалын хамтын ажиллагаагаа өргөжүүлж АХА компанитай хамтран ажиллах гэрээ байгуулав.
- Даатгалын компанийн хоёр дахь гол эрсдэл нь хөрөнгө оруулалтын эрсдэл байдаг. Компани байгуулагдсан цагаас хойш хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг санхүүгийн хэлтэс хариуцан ажиллаж байсан бол 2020 онд хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хариуцан ажиллах бие даасан нэгж байгуулагдлаа. Тус нэгж нь хөрөнгө оруулалтын бодлогыг сайжруулан батлуулсан бөгөөд бодлогодоо хөрөнгө оруулалт дефолт болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтыг түлхүү тусган ажиллаж байна.

2021 оны хувьд Монгол банкны бодлогын хүү буурч байгаатай холбоотойгоор арилжааны банкуудын хадгаламжийн хүү буурах, хөрөнгө оруулалтын өгөөж буурах эрсдэлтэй.

- Бид санхүүгийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагын хувьд мэдээллийн аюулгүй байдал, ялангуяа харилцагчийн мэдээллийн аюулгүй байдалд анхаарч ажилладаг. 2019 оноос эхлэн мэдээллийн аюулгүй байдлынхаа түвшинг мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэн, аудитаар илэрсэн эмзэг байдлыг яаралтай засварлан ажиллаж байна. 2020 онд хийгдсэн аудитын дүгнэлтээр мэдээллийн аюулгүй байдлын хувьд хангалтай үнэлгээ авсан.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Мандал даатгал нь анх байгуулагдсан цагаас эхлэн эрсдэлийн боловсролыг тасралтгүй түгээх, ард иргэд, албан байгууллагуудад эрсдэлээс урьдчилан сэргийлэх зан төлвийг хэвшүүлэх, эрсдэлгүй нийгмийг бүтээхэд өөрийн хувь нэмрээ оруулах чиглэлд тасралтгүй хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн билээ.

Даатгалын компани фундаментал мөн чанарынхаа хувьд яаж ажиллах ёстой түүгээрээ ажиллахад л нийгмийн маш том хариуцлагыг хэрэгжүүлдэг онцлог бизнес. Гэхдээ бидний бизнес нийгмийн хариуцлагатай гээд хойш суулгүй, өнгөрөгч 10 жилийн хугацаанд нийгмийн эрсдэлийн боловсролыг нэмэгдүүлэх, олон нийтийн эдийн засгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлд олон арван төсөл хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлэн, салбартаа сэтгэлгээний манлайлагч гэдгээ дахин дахин баталсаар байна.

ОЮУНЫ ТОМООХОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД

Purplebook сэтгүүл

Purplebook сэтгүүл нь бизнесмен, менежер, эдийн засагч, түшмэдүүдэд зөв шийдвэр гаргах, улс орон, бизнесээ зөв удирдан залахад шаардлагатай мэдээллийг тогтмол бэлтгэн, үнэ төлбөргүйгээр хүргэх зорилготой бие даасан шинжээч нарын бүтээл юм. Энэхүү эмхтгэл нь олон улс, эдийн засаг, зах зээлийн үйл явдлуудад мэргэжлийн дүгнэлт хийх, үйл явцын мөн чанарыг олж тогтооход чиглэгддэгээрээ онцлогтой. Анх зах зээлд гарсан цагаасаа олон хүний талархлыг хүлээн, тоо баримт, судалгааны үр дүнгүүд нь зөвхөн бизнесийнхний хүрээнд төдийгүй, Улсын их хурал, засгийн газрын уулзалтууд дээр дурдагдсан нь энэхүү бүтээлийн цар хүрээг илтгэх нэг хэмжүүр юм.



Мандал даатгал нь 2011 оноос хойш нийт 8 дугаар гаргасан бөгөөд нийгэм эдийн засгийн асуудлыг хөндсөн 150 гаруй анализ нийтлэлүүд бичиж, 6,000 гаруй төрийн болон хувийн хэвшлийн шийдвэр гаргагч нарт хэвлэмэл байдлаар түгээсэн байна.

Checklist Manifesto ном

Мандал даатгал нь 2011 онд Харвардын Анагаах Ухааны Сургуулийн зөвлөх профессор, зохиолч, мэс засалч Атул Гавандэгийн бестселлер болсон Checklist Manifesto буюу “Хяналтын хуудасны тунхаглал” номыг монгол хэлнээ хөрвүүлэх ажлыг зохион байгуулж, 1,000 ширхэгийг Монголын мэс засалчдын холбоонд үнэгүй хандивласан билээ. Монголын мэс засалчдын холбоонд нийслэлд үйл ажиллагаа явуулдаг 11 төв клиник болон орон нутгийн 21 аймагт хүн ардын эрсдэлийг бууруулахын төлөө өдөр шөнөгүй зүтгэж байдаг мэс засалч эмч нар хамрагддаг байна.



Энэхүү ном нь хяналтын хуудас гэх энгийн боловч чухал хэрэгслийг ашиглан хэрхэн эрсдэлийг бууруулж, аюулгүй байдал болон бүтээмжийг нэмэгдүүлж, ажлаа илүү үр ашигтайгаар зохион байгуулж болох талаар ойлголт өгөх зорилготойгоос гадна хяналтын хуудсыг нийгмийн бүхий л салбарт ашиглах боломжтой. Тэр дундаа хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд амин чухал ач холбогдолтой гэдгээрээ эрүүл мэнд, аж үйлдвэр, тээврийн салбаруудын мэргэжилтнүүдийн хувьд заавал унших ёстой номд зүй ёсоор тооцогдож байна.

Riskbook – Эрсдэлийг удирдахуй ном

Эрсдэлийн удирдлага гэхээр ихэнх хүмүүст сүрдмээр, төвөгтэй ойлголт шиг сонсогддог нь нууц биш. Гэтэл эрсдэл гэдэг зүйлтэй хүн өдөр тутамд нүүр тулдаг. Иймд, Мандал даатгалын зүгээс 2013 онд эрсдэлийн удирдлагын талаар цогц ойлголтыг энгийн үгээр тодорхой тайлбарласан “Riskbook – Эрсдэлийг удирдахуй” номыг боловсруулан нийтэлж, нийт 2,000 хувь хэвлэн үнэ төлбөргүй түгээсэн билээ. Энэхүү ном нь байгууллагын захирлаас эхлээд эрсдэлийн мэргэжилтэн, нягтлан бодогч, борлуулагч, сэтгүүлч, оюутан гээд ямар ч хүн уншаад эрсдэлийн удирдлагын талаар цогц ойлголт авахаар энгийн бичигдсэн гэдгээрээ онцлогтой.

eDoctor.mn – Эрүүл мэндийн нэгдсэн сан

“Эрүүл мэнд гэдэг бол зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхын цогц бүрдэл мөн” гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас томъёолсон байдаг.

Манай улсын иргэдийн дунд хавдар, даралт ихсэлт, чихрийн шижин зэрэг архаг хууч өвчний тархалт өндөр байдаг ба эдгээр халдварт бус өвчний улмаас нас баралт ч өндөр байдаг. Энэ нь нэг талаасаа хүрээлэн буй орчин, хоол хүнсний аюулгүй байдал, эмнэлгийн үйлчилгээнээс хамааралтай хэдий ч, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дутмаг байгаагийн илрэл юм.

Улс орны хувьд ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож хэрхэн өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг мэдлэгийг олгох нь нэн чухал байдаг. Ингэснээр дан ганц эрүүл мэнд бус өөрийн санхүүд учирч болох томоохон эрсдэлүүдийг урьдчилан таньж, зогсоох боломжтой.

Иймд, Мандал даатгалын зүгээс нийгмийн хариуцлагаа ухамсарлан Монгол Улсын эрүүл мэндийн салбарт өөрсдийн хувь нэмрээ оруулж, ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор eDoctor.mn веб сайтыг хөгжүүлээд байна.

Тус вебсайт нь мэргэжлийн эмч нартай хамтран бэлтгэсэн баталгаатай, эх сурвалжтай эрүүл мэндийн мэдээллийг хурдан шуурхай авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд 200 гаруй өвчний шинж тэмдэг, онош зүйн дэлгэрэнгүй мэдээлэл, өвчнийг шинж тэмдгээр нь шүүх ухаалаг хайлтын систем, эмнэлгийн мэдээллийн лавлах, эрүүл амьдралын зөвлөмжүүд зэргийг санал болгож байна.



ЭРСДЭЛИЙН БОЛОВСРОЛ

Эрсдэлийн удирдлагын форум

Улс орны эдийн засаг тэлж, нийгэм хөгжихийн хэрээр хүрээлэн буй орчин өөрчлөгдөж, аж ахуй нэгжүүд тодорхойгүй байдалтай нүүр тулдаг. Үүнийг бид эрсдэл хэмээн нэрлэж болох ч хэрхэн сэргийлэхээ хангалттай сайн мэддэггүй.

Харин энэхүү асуудлыг шийдэх гарцыг эрэлхийлэх, хамтдаа даван туулахын тулд Мандал даатгал 2011 оноос хойш “МОНГОЛ УЛСЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ФОРУМ”-ыг жил бүр санаачлан зохион байгуулж ирсэн. Уг форум нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, бизнесийн салбарт тулгардаг эрсдэлүүдийг судлан шинжилж, тэдгээрийг удирдах арга замуудыг мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хэлэлцэн боловсруулж, эрсдэлээс сэргийлэх, түүнийг бууруулахад тодорхой хувь нэмэр оруулдаг өндөр ач холбогдолтой арга хэмжээ юм.

Уг арга хэмжээ зохион байгуулагдсанаас хойш нийт 3,500 орчим бизнес эрхлэгчид, компанийн удирдлагууд хамрагдаж, 10 жилийн хугацаанд нийт 75 орчим эрсдэлийн талаар илтгэл хэлэлцүүлгүүд хийж, эрсдэлийн 10 тайланг эмхтгэн гаргасан байна. Мөн “Үндэсний суурь эрсдэлийн индекс” тайлан бий болсноор Монгол Улс анх удаа эрсдэлээ дэлхийн стандартын дагуу хэмжиж, сэргийлэх арга хэмжээ авах эхлэл тавигдсан юм.

Түүнчлэн, энэхүү форумын нөлөөгөөр Гаалийн ерөнхий газар, Нийслэлийн татварын алба, Мэргэжлийн хяналт зэрэг байгууллагууд эрсдэлийн тусдаа албыг байгуулсан билээ.



Эрсдэлийн тайлан

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учрах хохирлыг бууруулахын тулд эрсдэлийн түвшинд гарч буй өөрчлөлтийг тодорхойлж, хэмжиж, үнэлэх хэрэгтэй байдаг. Жишээлбэл, олон улсад НҮБ-ын “Дэлхийн эрсдэлийн индекс”, Английн даатгалын зах зээл Ллойдсын “Хотуудын эрсдэлийн индекс” зэрэг улс орнуудыг эрсдэлийн түвшингээр нь үнэлсэн хэд хэдэн судалгаа бий. Харин манай орны хувьд эрсдэлийн нэгдсэн хэмжүүр үзүүлэлт байхгүй байсан нь Мандал даатгалын зүгээс “Эрсдэлийн индекс”-ийг тооцож гаргах гол хөшүүрэг болсон юм.



Эрсдэлийн индекс нь иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө, албан байгууллагын үйл ажиллагаанд хэмжигдэхүйц, бодит хохирол учруулдаг байгалийн гамшигт үзэгдэл, нийгмийн эрсдэлүүдийг нэгтгэн тоон утгаар хэмжиж, эрсдэлийн түвшнийг тодорхойлсон үзүүлэлт юм. Бид бүхний тооцсон индексийг Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэнгээс сайшаан хүлээн авч, 2017 онд индекс тооцох аргачлалыг хамтран сайжруулж, “Үндэсний суурь эрсдэлийн индекс” хэмээн нэрлэхээр болсон билээ.

Индекс нь 1-9 оноогоор үнэлэгдэн, индексийн тоон утга их байх нь эрсдэлийн түвшин өндөр байгааг илэрхийлдэг. Үүнийг нэг жилийн туршид тохиолдсон эрсдэлийн статистик мэдээлэлд тулгуурлан жилд нэг удаа тооцож гаргана.

Эрсдэлийн нэвтрүүлэг

Мандал даатгалын зүгээс эдийн засаг, санхүүгийн зах зээлийн мэдээллийг хэрэглэгч олонд түгээх үүрэг, хариуцлагыг зөвхөн олон нийтийн мэдээллийн байгууллагад даатгах нь мэргэжлийн байгууллагын хувьд хариуцлагагүй үйлдэл гэж үздэг. Тиймээс иргэдэд эрсдэлийн боловсролыг амралт, чөлөөт цагаар нь хүргэх зорилготойгоор Мандал даатгалын мэргэжилтнүүд салбартаа анх удаа эдийн засаг, санхүүгийн зах зээлийн судалгаа дүгнэлт, нийгмийн эрсдэлийн шинжилгээ агуулсан “Шинжээчийн цаг” мэдээллийн хөтөлбөрийг TV5, NTV сувгуудаар 2012, 2013 онуудад бэлтгэн хүргэсэн билээ.

Эрсдэлийн семинар

Мандал даатгалын зүгээс нийгэмд оршин буй эрсдэлийг бууруулах зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудын нэг бол эрсдэлийн удирдлагын семинар юм. Эрсдэлийн семинар нь жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Монгол Улсын Эрсдэлийн Удирдлагын Форум” арга хэмжээний жижигрүүлсэн хувилбар бөгөөд тодорхой салбар, эрсдэлд суурилсан байдгаараа онцлогтой. 2011 оноос хойш Мандал даатгал нийт 10 удаагийн эрсдэлийн семинарыг зохион байгуулж, 800 гаруй мэргэжилтнийг хамруулсан байна.

Энэхүү семинараар эрсдэл, түүний мөн чанар, эрсдэлийг удирдах арга хэрэгслүүдийн талаар заахаас гадна байгууллагад учирч болохуйц эрсдэлийг таних арга хэрэгсэл, удирдах процессыг зааж сургадаг. Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан, Барилга, Уул уурхай, Алт, Иргэний нисэх болон Удирдах албан тушаалтны хариуцлага гэх мэт сэдэвт семинаруудыг амжилттай зохион байгуулж, салбарын мэргэжилтнүүдэд эрсдэлийн талаар нарийвчилсан мэдлэг олгосон билээ.



Хүүхдийн эрсдэлийн онлайн сургууль

Манай Улсын нийт хүн амын гуравны нэгийг 0-19 насны хүүхдүүд эзэлдэг. Эдгээрийн 40 мянга орчим нь жилд гэнэтийн ослын золиос болж, эрүүл мэнд, амь насаараа хохирч байгаа харамсалтай статистик бий. Телевиз, олон нийтийн сүлжээгээр бага насны хүүхдүүд гэмтэж бэртсэн, амь насаа алдсан талаар сэтгэл сэрдхийлгэм мэдээнүүд явах бүрд олон нийт улс орон, эцэг эхчүүдийг буруутгадаг хэдий ч эрсдэлийн боловсрол дутмаг байгаа талаар барагтаа дурддаггүй.

Гэтэл энэ их эрсдэлийг бууруулахад зөвхөн эцэг эхчүүдийн хараа хяналтыг нэмэгдүүлэх, хүрээлэн буй орчныг сайжруулах хангалтгүй. Хүүхдүүд өөрсдөө эрсдэлийг таньдаг, мэддэг, тойрч гарч, удирдаж чаддаг боловсролтой байх ёстой. Иймээс, Мандал даатгалын зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд “Маргааш тохиож болзошгүй эрсдэлээс сэргийлж, хүүхдэдээ эрсдэлийн боловсролыг олгох ажлыг өнөөдрөөс эхлүүлээрэй” хэмээн уриалж, МАНДАЛ ЭРСДЭЛИЙН СУРГУУЛЬ төслийг эхлүүлээд байна.

Одоогийн байдлаар 4-12 насны хүүхдүүдэд түгээмэл тохиолддог эрсдэлийн тухай, тэдгээрийн нас болон сэтгэлзүйн онцлогт тохируулсан есөн цуврал видео хичээл www.mandalschool.mn платформ дээр байршиж байна. Эдгээр хичээлүүд нь хүүхэд бүрд нээлттэй, үнэ төлбөргүй бөгөөд эцэг эхчүүд ердөө имэйл хаягаа бүртгүүлээд видео хичээлүүдийг үзэх боломжтой юм.

Мандал Эрсдэлийн Сургууль нь нээгдсэн цагаасаа хойш ердөө хоёр сарын хугацаанд 5,000 гаруй сурагчтай болсон бөгөөд эцэг эх, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс цаг үеэ олсон, хүүхдэд ээлтэй төсөл гэсэн талархлыг хүлээгээд байна.





ЭЗ

МАНДАЛЫН
ЗАСАГЛАЛ

“ЭРСДЭЛ МИНИЙ НҮДЭЭР” зургийн уралдаан,
Мандал Эрсдэлийн Сургуулийн сурагч Ж.Халиун, 12 настай

МАНДАЛЫН ЗАСАГЛАЛ

Корпорацын сайн засаглалын тэргүүн туршлагуудыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандал даатгалын эрхэм зорилго, алсын харааг биелүүлэхэд чухал үүрэгтэй.

Компанийн засаглал нь компанийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа бөгөөд компанийн стратеги, алсын хараа болон зорилтыг тодорхойлох, тэдгээр зорилтод хүрэх арга зам, гүйцэтгэлийг хянах тогтолцоог бий болгодог хэрэгсэл юм. Корпорацын сайн засаглалын туршлагыг бизнесийн байнгын үйл ажиллагаандаа тусгаж, сайн засаглалтай, сайн удирдлагатай компанийг цогцлоох нь Мандал даатгалын эрхэм зорилго, алсын харааны салшгүй хэсэг билээ.

Корпорацын сайн засаглал гэдэгт:

- Системтэй шийдвэр гаргах үйл явцтай байх,
- Хариуцлагын талаар ойлголт өгөх,
- Ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх,
- Дотоод хяналтын тогтолцоо,
- Эрсдэлийн удирдлага,
- Мэдээллийн ил тод байдлыг хангах зэрэг үйл ажиллагаа багтана.

Компанийн засаглалын тухай хэсэгт Мандал даатгалын хувьцаа эзэмшигчдийн хурал, "Төлөөлөн удирдах зөвлөл"-ийн эрх үүрэг, хариуцлага, санхүүгийн тайлагналтай холбоотой компанийн дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын талаар тусгалаа.

ЭРХ МЭДЭЛ, ХАРИУЦЛАГЫН ХУВААРИЛАЛТ

Компанийн хяналт болон удирдлага нь хувьцаа эзэмшигчид (Хувьцаа эзэмшигчдийн хурлаар), Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал нарт гадаад зохицуулалт болон ТУЗ-өөс тогтоосон дотоод дүрэм, журмаар зохицуулагдан хуваарилагддаг.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Мандал даатгалын эрх барих дээд байгууллага нь "Хувьцаа эзэмшигчдийн хурал" юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн стратегийн чухал шийдвэрүүдийг хэлэлцэн шийдвэрлэх, ногдол ашгийн бодлого тодорхойлох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох, компани дээр хийгдэж буй хэлцлүүдийг хянах, бизнес төлөвлөгөөг батлах түүний хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй.


Мандал даатгалын 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04

сарын 23-ны өдрийн Пүрэв гарагт 17:00 цагаас компанийн албан ёсны фэйсбүүк fb.com/mandalmaatgal хаягаар дамжуулан цахим хэлбэрээр зарлан хуралдсан. Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц, санал хураалт, асуултыг stock.mandal.mn сайтаар хүргэсэн.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн баталсан байна. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
2. Компанийн ТУЗ-ийн нэг гишүүн өөрийн хүсэлтээр ажлаа хүлээлгэн өгч байгаа тул ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг танилцуулж сонгох;

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Мандал даатгалын ТУЗ нь компанийн урт хугацааны амжилтыг ахиулах, хувьцаа эзэмшигчдэд тогтвортой үнэ цэнийг бий болгох, ил тод нээлттэй байдал, эрүүл мэтгэлцээний соёлыг дэмжихийг зорьдог.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц

Мандал даатгал компанийн дүрэмд тусгагдсанаар ТУЗ нь есөн гишүүнтэй байхаас зургаа

нь ердийн гишүүн ба гурав нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь гурван жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх нь үргэлжилнэ.

Компанийн засаглалын кодексын дагуу ТУЗ-д аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага туршлага бүхий хүнийг гишүүнээр сонгон ажиллуулахыг зөвлөсөн байдаг. Түүнчлэн ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь компанийн үйл ажиллагаа, хөгжлийн үе шат болоод бусад нөхцөлтэй уялдсан байх шаардлагатай.

Мандал даатгал компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тодорхойлоход, зөвлөлийн үр ашигтай байдлыг хадгалах, дээшлүүлэх явдлыг ихээхэн анхаардаг.

2018 оны 12 сарын 12-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал болон 2020 оны 4 сарын 23-ны ээлжит хурлын санал хураалтын үр дүнд үндэслэн, Мандал даатгалын ТУЗ-ийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсон байна.

Ердийн гишүүнээр:

- Өлзийбаяр ГАНЗОРИГ
- Шаравпэлжээ ГАНТУЯА
- Очирпүрэв ГАНЖОЛОО
- Амартүвшин АМУНДРА
- Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ
- Батсайхан ЖАВХЛАН

ТУЗ-ийн хараат бус гишүүнээр:

- ЖЭЙМС Бернард Двайер
- Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН
- Нямандэлэг МАНДУУЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, үйл ажиллагаа

Мандал даатгалын ТУЗ нь компанийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавин удирдан чиглүүлж ажилладаг. Жилийн төлөвлөгөө, стратегийн зорилтууд, үйл ажиллагааны хяналт, эрсдэлийн удирдлага, хөрөнгө оруулалт, гүйцэтгэх удирдлага томилох зэрэг асуудал нь ТУЗ-өөр хянагдан, батлагддаг билээ.

ТУЗ нь санхүүгийн болон стратегийн бусад зорилт, бизнесийн гол сорилтууд, эрсдэл, бизнесийн хөгжил, хөрөнгө оруулагч, гадаад харилцааны гүйцэтгэлийн тайланг тогтмол хянах үүрэгтэй. Мөн компани нь ТУЗ-ийн гишүүдийг бүх түвшинд удирдлагуудтай чөлөөтэй, нээлттэй харилцах, холбогдох бүх мэдээлэлд хандах боломжоор ханган ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Засаглалын кодексыг хангах, ТУЗ-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор ТУЗ-ийн дэргэд туслах ажлын хэсгүүдийг байгуулан ажилладаг. ТУЗ-ийн хороодын эрх үүрэг, үйл ажиллагааг тус бүрийн хороодын журмаар тодорхойлсон болно. Хороод нь улирал бүр тогтмол хуралдаж, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнадаг.

Аудит, эрсдэлийн хороо

Мандал даатгалын үйл ажиллагаа нь бүхэлдээ эрсдэлийг хэмжих, үнэлэх, удирдахтай холбоотой. Иймд, ТУЗ дэргэдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, хянах үүрэгтэй "Аудит, эрсдэлийн хороо"-г ажиллуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудит, эрсдэлийн хороо нь компанийн дотоод журам, тушаалын

хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлон хянах үүрэгтэй.

Мөн компанийн дотоод аудитын нэгж, хөндлөнгийн аудитын байгууллагын хоорондын харилцааг зохицуулах, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод, бүрэн бүтэн байдлыг шалгаж батлах, дотоод хяналтын системийг хянах, ТУЗ-д мэдэгдэх үүрэгтэй билээ.

Түүнчлэн компанийн нийт хүлээгдэж буй хариуцлага, түүнд харгалзах нөөцийн сан, эрсдэл даах чадварын шинжилгээтэй улирал бүр танилцаж, зохих заавар зөвлөмжийг гарган ажиллаж байна. Аудит, эрсдэлийн хороо нь 3 гишүүнтэй бөгөөд үүнээс 2 гишүүн нь хараат бус гишүүн байна. Тус хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Бернард Двайер даргалдаг.

Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо

Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, компанийн болон гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын асуудлыг зохицуулах бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх үүрэгтэй.

Засаглалын кодексын дагуу хорооны гишүүд нь компани болон удирдлагын багаас хараат бус байхыг шаарддаг бөгөөд хорооны бүрэлдэхүүн нь энэхүү дүрэмтэй бүрэн нийцэлтэй болно. Мандал даатгалын Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд үүнээс хоёр гишүүн нь хараат бус гишүүн байна. Тус хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Гантуяа даргалдаг.

МАНДАЛ ДААТГАЛ ХК -ИЙН НЭГДСЭН СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭД, ТҮҮНИЙ ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААНЫ ТОО

2020 оны 04 сарын 01-ны өдрийн байдлаарх Мандал даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Нэрс	Тоо ширхэг	Эзэмшил хувь
Голомт Файнэншил Групп ХХК	255,000,000	40,85%
Юу Эм Си Капитал ХХК	227,928,800	36,51%
Олон нийт	141,372,800	22,64%
Дүн	624,301,600	100,00 %

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД




Өлзийбаяр ГАНЗОРИГ | ТУЗ-ийн дарга

Ө.Ганзориг санхүүгийн зах зээл дээр 20 орчим жил ажилласан туршлагатай. Тэрбээр даатгал, банк, хөрөнгийн захаар дагнан мэргэшихдээ Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан мэргэжилтэн билээ.

Өнгөрсөн хугацаанд Голомт банк, Тэнгэр даатгал, Улаанбаатар хотын банк, Голомт капитал, Худалдаа Хөгжлийн банк, Хас банк, Капитрон банк зэрэг байгууллагуудад хариуцлагатай албан тушаал хашихаас гадна Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүн, Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн гишүүн, Татварын ерөнхий газрын бодлогын зөвлөлийн гишүүн, СЗХ-ны бодлогын зөвлөлийн гишүүн, Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн зөвлөлийн гишүүн, Монголын даатгагчдын холбооны дэд ерөнхийлөгч, Монголын банкуудын холбооны ерөнхийлөгчөөр тус тус сонгогдон ажиллаж иржээ.

Ө.Ганзориг нь Мандал даатгалын үүсгэн байгуулагч бөгөөд ТУЗ-ийн дарга юм. Мөн Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгчөөр ажиллаж байна.

Ө.Ганзориг нягтлан бодох бүртгэлийн бакалавр, санхүүгийн удирдлагын диплом, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Мөн Олон улсын санхүүгийн зах зээлийн холбооны дилерийн сертификатыг эзэмшдэг.



ЖЭЙМС БЕРНАРД ДВАЙЕР | ТУЗ-н хараат бус гишүүн

Жэймс Двайер нь Нью Йорк хотод хөрөнгө оруулалтын банкираар 30 гаруй жил ажилласан туршлагатай банкир юм. Тэрээр Shearson Loeb Rhoades болон UBS зэрэг дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын банкуудын M&A нэгжийг удирдан ажиллаж байжээ.

Двайер нь анх 2001 онд Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын асуудлаар Монголын Засгийн газрыг төлөөлөх хөрөнгө оруулалтын банкираар Монголд зочилж байсан бөгөөд Хаан банкны хувьчлалд хөрөнгө оруулалтын зөвлөхөөр мөн ажилласан байна. Тэрээр 2007-2016 онд Монголын Бизнесийн Зөвлөл /VCM/-ийг үүсгэн байгуулж, захирлын албан тушаалыг хашиж байв.

Жэймс Двайер Нотр Дамын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр, Колумбын Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.



Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН | ТУЗ-ийн хараат бус = гишүүн

Ж.Дэлгэрсайхан нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн багш, дэд профессороор ажилладаг. Тэрээр 1996 оноос хойш СЭЗИС-д багшлахын сацуу, олон тооны судалгаа шинжилгээ, эрдмийн бүтээл туурвиж, Монгол Улсын санхүүгийн салбарт үнэтэй хувь нэмэр оруулсан эрхэм билээ.

Ж.Дэлгэрсайхан нь Санхүү банкны тэргүүний ажилтнаар тодорч байсан бөгөөд МХБ, Монголын банкуудын холбоо, СЗХ-нд зөвлөхөөр сонгогдон ажиллаж байсан туршлагатай.

Ж.Дэлгэрсайхан нь Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн эдийн засгийн бакалавр, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн бакалавр, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Санхүүгийн удирдлагын магистрын зэрэгтэй.



Нямандэлэг МАНДУУЛ | ТУЗ-ийн хараат бус гишүүн

Н.Мандуул нь “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Үнэт цаас бүртгэлийн хэлтсийн даргаар ажилладаг.

Тэрээр Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт зөвлөх, Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Төсвийн бодлогын санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн даргаар тус тус ажилласан туршлагатай. Мөн 2016 онд СЗХ-ны орон тооны бус гишүүнээр томилогдон ажиллаж байсан.

Н.Мандуул нь Болгар улсын Америкийн Их Сургуулийг эдийн засаг, бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй, АНУ-ын Брэндиз Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн байна.



Чулуун ВАНЧИН-ЭРДЭНЭ | ТУЗ-ийн гишүүн

Ч.Ванчин-Эрдэнэ нь “Таван Богд Трейд” ХХК-ийн дэд захирлаар ажилладаг. Тэрээр, өмнө нь MCS Холдингид санхүүгийн шинжээч, “Скайтел” ХХК-д Санхүү төлөвлөлтийн хэлтэс хариуцсан захирлаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

Ч.Ванчин-Эрдэнэ нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн.



Очирпүрэв ГАНЖОЛОО | ТУЗ-ийн гишүүн

О.Ганжолоо нь “Голомт Файнэншил Групп”-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр дэлхийн хамгийн том аудитын компани болох Price water house Coopers-н Герман болон Монгол дахь салбаруудад ажиллаж ихээхэн туршлага хуримтлуулсан, туршлагатай мэргэжилтэн юм.

Мөн “Бодь Интернэшнл” ХХК-ийн санхүү эрхэлсэн захирал, Голомт банкны ТУЗ-ийн аудитын хорооны даргаар тус тус ажиллаж байв.

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуулийн эдийн засгийн магистр зэрэгтэй.



Амартүвшин АМУНДРА | ТУЗ-ийн гишүүн

А.Амундра нь хэвлэл мэдээллийн салбарын томоохон төлөөлөгчдийн нэг юм. Тэрээр эгнээндээ Eagle TV, Боловсрол ТВ зэрэг Монголын хамгийн олон үзэгчтэй телевизийн сувгуудыг багтаадаг Монгол Масс Медиа группийн гүйцэтгэх захирлаар 2010-2017 онуудад ажиллаж байв.

А.Амундра 2017 оноос эхлэн “Бодь Интернэшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Шаравпэлжээ ГАНТУЯА | ТУЗ-ийн гишүүн

Хатагтай Ш.Гантуяа нь “Юу Эм Си Капитал” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр өмнө нь “Монгол Ньюс” ХХК-д Маркетингийн хэлтсийн захирал, “Улаанбаатар зочид буудал” ХХК-д Маркетингийн албаны даргаар тус тус ажиллаж байсан туршлагатай.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Мандал даатгалын гүйцэтгэх захирал бизнесийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх үүрэгтэй. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурлуудыг үр дүнтэй зохион байгуулахад ТУЗ-ийн даргатай нягт хамтран ажилладаг.

Мөн гүйцэтгэх захирал нь компани доторх дотоод хяналтын үр ашигтай тогтолцоог боловсруулж, хадгалж байх үүрэгтэй бөгөөд үйл ажиллагаагаа ТУЗ-д тогтмол тайлагнадаг болно.

Удирдлагын хороо

Удирдлагын хороо нь компанийн үйл ажиллагааг сар, улирлаар хянах, гүйцэтгэлийн үр дүнг хэлэлцэх, компанитай холбоотой томоохон шийдвэрүүдийг гаргах, дотоод дүрэм, журам, хэм хэмжээг тогтоох үүрэгтэй.

Удирдлагын хороо нь өөрийн удирдлагад нөхөн төлбөрийн, хөрөнгө оруулалтын, андеррайтингийн, байгууллагын соёл, ёс зүйн, чанарын дэд хороодыг удирдан ажиллуулдаг.

Нөхөн төлбөрийн дэд хороо

Нөхөн төлбөр шийдвэрлэх процессын дагуу нөхөн төлбөрийн шийдвэр гаргах, процесс болон гэрээний андеррайтингийн нөхцөлүүдийг сайжруулахад чиглүүлэх, батлах зорилготой.

Хөрөнгө оруулалтын дэд хороо

Компанийн мөнгөн хөрөнгийг үр ашигтай санхүүгийн хэрэгслүүдэд байршуулж, хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын хяналт хийх болон хөрөнгө оруулалтын зорилтуудыг батлах зорилготой.

Андеррайтингийн дэд хороо

Даатгалын гэрээний стандартчилал болон түүнтэй холбоотой аливаа өөрчлөлтүүдийг батлах, даатгалын бүтээгдэхүүнүүдийн хүрээнд ашиглах эрсдэлийн болон хөрөнгө үнэлгээний аргачлалыг батлах, андеррайтингийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой.

Байгууллагын соёл, ёс зүйн дэд хороо

Байгууллагын соёлыг бүрдүүлэх, ёс зүйн дүрэм стандартыг хэвшүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны бодлого чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтэнд хяналт тавих, ёс зүйн алдаа дутагдлыг сайжруулах арга хэмжээ авах зорилготой.

Чанарын дэд хороо

Байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, чанарын хяналтыг хэрэгжүүлэх, хянах, сайжруулах, чанарын үл тохирлыг залруулах арга хэмжээ авах зорилготой.

УДИРДАГЫН БАГ



П.Оргодол
Үйл ажиллагаа хариуцсан
захирал

Б.Жавхлан
Гүйцэтгэх захирал

Ч.Даваадаш
Ерөнхийлөгч

Г.Халиунаа
Санхүү хариуцсан
захирал

Н.Түмэндэмбэрэл
Гүйцэтгэх захирлын орлогч

З.Одмаа
Бизнес хөгжил, маркетинг
хариуцсан захирал

Ж.Гарваа
Даатгалын бодлого
хариуцсан захирал

Батсайхан ЖАВХЛАН | Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн

Б.Жавхлан Мандал даатгалын гүйцэтгэх захирал бөгөөд тус компанийн иргэдийн даатгалын газар, бизнес хөгжил болон эрсдэлийн удирдлагын газрыг хариуцан ажиллаж байсан, даатгалын салбарт есөн жил ажилласан туршлагатайгаас гадна мэдээлэл технологийн салбарт 2000 оноос хойш ажиллажээ. Мөн Япон Улсын Токио хотод мэдээлэл технологийн төслийн удирдагчаар таван жил ажиллахдаа Японы зах зээлд хэд хэдэн амжилттай шийдэл нэвтрүүлсэн байна.

Б.Жавхлан нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг компьютерын ухааны бакалавр зэрэгтэй дүүргэжээ.

Чүлтэм ДАВААДАШ | Ерөнхийлөгч

Ч.Даваадаш нь 2001 оноос эхлэн Монгол Улсын харилцаа холбоо, нефть хангамж, банк санхүү зэрэг салбаруудад ажиллаж ирсэн туршлагатайгаас гадна сүүлийн 10 гаруй жил компаниудын удирдлагын түвшинд ажиллажээ. 2008 оноос Ньюком, Мобиком группын Ньютел компанийн Гүйцэтгэх Захирал, Петровис группын НИК компанийн дэд Захирал, Гүйцэтгэх Захирал, Скайтел компанийн Дэд захирал, Голомт банкны Газрын захирал, Гүйцэтгэх захирлын орлогчоор тус тус ажилласан туршлагатай.

Мандал даатгал компанийн Ерөнхийлөгчөөр 2019 оны 2-р хагасаас ажиллаж эхэлсэн тэрээр Эдийн засаг, Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй.

Найдандорж ТҮМЭНДЭМБЭРЭЛ | Гүйцэтгэх захирлын орлогч

Н.Түмэндэмбэрэл нь банк санхүүгийн салбарт сүүлийн 10 гаруй жил ажилласан туршлагатайгаас гадна Голомт банкны хэлтэс, газрын захирал, Хас банкны төслийн нэгжийн захирал, АНУ-ын Браунс Группд санхүү, зээлийн үйл ажиллагаа хариуцсан менежер зэрэг хариуцлагатай албан тушаалуудад ажиллажээ.

Тэрээр 2019 оноос эхлэн Мандал даатгалын гүйцэтгэх захирлын орлогчоор томилогдон Байгууллага болон Иргэдийн даатгалын газрыг хариуцан ажиллаж байна.

Н.Түмэндэмбэрэл нь АНУ-ын Либерти Их Сургуулийн шинжлэх ухааны бакалавр зэргийг Санхүүч мэргэжлээр дүүргэснээс гадна, БНХАУ-ын Хонконг ГИФТ институтид төсөл, бүтээгдэхүүн, байгаль орчны судалгаа чиглэлээр мэргэжил дээшлүүлжээ.

Гантулга ХАЛИУНАА | Санхүү хариуцсан захирал

Г.Халиунаа нь Мандал даатгалын Санхүү хариуцсан захирал бөгөөд компанийн санхүүгийн удирдлага, хөрөнгө оруулалтын удирдлагыг хариуцан ажиллаж байна. Тэрээр Голомт банк ХХК-д Удирдлагын мэдээллийн хэлтсийн захирлаар ажиллаж байсан.

Г.Халиунаа нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн сургуулийн Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй.

Ганбат ГАНЗОРИГ | Хөрөнгө оруулалт хариуцсан захирал

Г.Ганзориг нь Мандал даатгалын Хөрөнгө оруулалт хариуцсан захирал бөгөөд өмнө нь Голомт банкны ахлах эдийн засагч, Санхүүгийн зах зээлийн холбооны эдийн засагч, Юу Эм Си Альфа компанийн санхүүгийн шинжээч, Мандал даатгалын эрсдэлийн шинжээчээр ажиллаж байсан. Тэрээр Санхүү эдийн засгийн их сургуулийн санхүү удирдлагын бакалавр, Английн Лийдсийн их сургуулийн эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй.

Г.Ганзориг нь олон нийтийн санхүүгийн боловсролыг сайжруулах зорилгоор эдийн засгийн нийтлэлүүд, нэвтрүүлэг зэргийг тогтмол хүргэдэг.

Зоригт ОДМАА | Бизнес хөгжил, маркетинг хариуцсан захирал

З.Одмаа Мандал даатгалын Бизнес хөгжил, маркетинг хариуцсан захирал бөгөөд компанийн бизнес хөгжил, маркетинг, брэндинг, олон нийтийн харилцааг хариуцан ажиллаж байна.

Тэрээр даатгалын салбарын маркетинг, бизнес хөгжлийн чиглэлээр 11 жил ажилласан туршлагатай. Түүнчлэн маркетингийн зөвлөх үйлчилгээний компанид Ерөнхий менежерээр ажиллаж, томоохон брэндингийн компанид ажлуудыг амжилттай удирдан хэрэгжүүлж байв.

З.Одмаа нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй.

Жамсран ГАРВАА | Даатгалын бодлого хариуцсан захирал

Ж.Гарваа нь Мандал даатгалын Даатгалын бодлого хариуцсан захирал бөгөөд даатгалын андеррайтинг, давхар даатгал, актуар тооцооллын бодлогыг хариуцан ажиллаж байна. Тэрээр өмнө нь тус компанийн Байгууллагын даатгал хариуцсан захирал байсан бөгөөд байгууллагын даатгалын бизнес хөгжил, борлуулалт, харилцагчийн халамжийн албуудыг тус тус хариуцан ажиллаж байсан.

Ж.Гарваа нь Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй ба Мандал даатгалаас гадна М-Си-Эс Эй-Пи-Би ХХК болон Мон Сүү ХХК зэрэг компаниудад маркетингийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай.

Пүрэвдорж ОРГОДОЛ | Үйл ажиллагаа хариуцсан захирал

П. Оргодол нь Мандал даатгалын Үйл ажиллагаа хариуцсан захирал бөгөөд тус компанийн захиргаа, хүний нөөцийн хэлтэс, мэдээллийн технологийн хэлтэс, бизнес процессийн хэлтсүүдийг тус тус хариуцан ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт санхүүгийн төлөвлөлт, эрсдэлийн шинжилгээ, дотоод хяналтын чиглэлээр 5 жил ажилласан туршлагатай.

П.Оргодол нь Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуулийг эдийн засгийн бакалавр зэрэгтэй дүүргэжээ.

MNDL ХУВЬЦАА

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

2018 оны 9 сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO (Initial Public Offering) хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 25 хувийг санал болгон нийт 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан олон нийтийн компани болсон.

ХУВЬЦААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зах зээлийн үнэлгээ

30.0 тэрбум төгрөг

Нийт хувьцааны тоо

624,301,600 ширхэг

Хаалтын ханш 12/31/2019

48 төгрөг

Эх сурвалж: МХБ

EPS 2020	P/E харьцаа	P/B харьцаа	ROA /нийт хөрөнгийн өгөөж/	ROE /өөрийн хөрөнгийн өгөөж/
7.3	6.6	1.3	9%	21%

Эх сурвалж: Компанийн тайлан, МХБ

Мандал даатгал компани 2020 онд олон нийтэд хувьцаа гаргаж байх үеийн санхүүгийн байдлын төсөөллөөс мөнгөн хөрөнгийн гүйцэтгэл 128 хувь, хөрөнгө оруулалтын орлого 155 хувь, цар тахлын нөлөөнөөс үүдэлтэй цэвэр ашиг 83 хувийн гүйцэтгэлтэй ажиллажээ.

Үзүүлэлт, тэрбум төгрөг	2020 IPO төсөөлөл	2020 Гүйцэтгэл	Өсөлт
Мөнгөн хөрөнгө	26.2	33.6	128%
Хураамжийн орлого	33.6	33.2	99%
Хөрөнгө оруулалтын орлого	3.6	5.5	155%
Цэвэр ашиг	5.5	4.6	83%

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА


Мандал даатгалын хувьцаа нь MNDL симболтойгоор Монголын Хөрөнгийн Биржийн I ангилалд арилжаалагдаж байна. Энэ ангилалд сүүлийн жилд 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай, нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх зэрэг чанарын үзүүлэлт хангасан 18 компани багтдаг.

Нийт арилжааны дүн**1.9 тэрбум төгрөг**

Өдрийн дундаж арилжаа	7.7 сая төгрөг
Өдрийн дундаж арилжааны ширхэг	169,510 ширхэг
52 долоо хоног өндөр ханш	52.6 төгрөг
52 долоо хоног бага ханш	38.9 төгрөг


Эх сурвалж: МХБ

Монголын хөрөнгийн биржийн шилдэг 20 хувьцаат компаниар зах зээлийн жишиг болгон тооцдог ТОП-20 индекст MNDL хувьцаа нь багтдаг ба нийт 1.9 тэрбум төгрөгийн арилжаа явагдаж 2020 онд идэвхтэй арилжигдсан 10 үнэт цаасанд багтсан байна.

2020 ОНЫ ТОП-20 ИНДЕКС БА MNDL ХУВЬЦААНЫ ҮНЭ

Эх сурвалж: МХБ

ТОП-20 индекс нь 2020 онд 19,491-ээс эхэлж цар тахлаас үүдэлтэй шокын нөлөөгөөр хоёрдугаар сараас долдугаар сар хүртэл уналттай байжээ. Наймдугаар сараас хагас жилийн санхүүгийн үр дүнгүүд гарснаар өсөлт үзүүлж 2020 оны эцэст 2020 оны эхэн үед дөхөж буюу 19,286 түвшинтэй хаагджээ.

2020 ОНЫ MNDL ХУВЬЦААНЫ ҮНЭ БА АРИЛЖААЛАГДСАН ШИРХЭГ

Эх сурвалж: МХБ

Мандал даатгалын хувьцааны үнийн хувьд ТОП-20 индекс буюу зах зээлийг дагаж (корреляц=0.89) хөдөлсөн ханшийн хөдөлгөөн ажиглагдсан байна. Нэгж хувьцааны үнэ 2020 онд 50 төгрөгөөр эхэлсэн бол оны эцэст 48 төгрөг буюу компанийн зах зээлийн үнэлгээ 30 тэрбум төгрөгөөр үнэлэгдэн хаагдсан байна.

НОГДОЛ АШИГ БА НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Мандал даатгал нь 2019 оны цэвэр ашгаас нэгж хувьцаандаа 4 төгрөг, нийт 2.49 тэрбум төгрөгийг 2020 онд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон хуваарилсан.

Мандал даатгалын Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2-р сарын 18-ны өдрийн №21/001 тоот тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 3 төгрөг буюу нийт 1,8 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргаад байна.

Анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгож хөрөнгө татсанаас хойш санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан жил бүр ногдол ашиг олгож байгаа бөгөөд 2019 болон 2020 оны цэвэр ашгаас тус бүр 43 хувь болон 41 хувийн ногдол ашиг олгох шийдвэр гаргаад байна.

Ногдол ашиг	Нэгж хувьцаанд ногдох ашиг, төгрөг	Хувьцааны тоо, ширхэг	Нийт ногдол ашиг, төгрөг	Татварын дараах ашиг, төгрөг	Ногдол ашиг олголтын хувь, DPR*
2018	100	6,243,016	624,301,600	3,868,257,250	16%
2019	4	624,301,600	2,497,206,400	5,870,586,590	43%
2020	3	624,301,600	1,872,904,800	4,588,055,885	41%

* Dividend payout ratio

Ирээдүйд олгох ногдол ашгийн хэмжээ нь тухайн үеийн эдийн засаг болон санхүүгийн зах зээлийн төлөв байдал, Мандал даатгалын ашиг, санхүүгийн чадавх, хөрөнгө ба төлбөрийн чадварын нөхцөл байдал зэргээс хамаардаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь дээрх нөхцөлүүдийг харгалзан үзэж санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг гаргадаг.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаа улирал бүр цаг алдалгүй олон нийт, хөрөнгө оруулагчдадаа танилцуулж, хувьцаат компаниудын дунд жишиг тогтоон ажиллаж байна. 2020 оны хувьд Ковид-19 өвчний улмаас нөхцөл байдалтай уялдан компанийн мэдээллүүдийг онлайнар видео хэлбэртэй хүргээд байна. Мөн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хагас жил тутамд санхүүгийн тайлан, холбогдох мэдээллүүд тавигддаг. Ийнхүү, бид ил тод байдлаа ханган ажиллаж буй нь хөрөнгө оруулагчдынхаа өмнө хүлээсэн үүрэг билээ. Түүнчлэн зах зээлд институциональ хөрөнгө оруулагчийн ач холбогдлыг таниулах болон үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тодорхой ажлууд хийгдсээр байна.



“ЭРСДЭЛ МИНИЙ НҮДЭЭР” зургийн уралдаан,
Мандал-Эрсдэлийн Сургуулийн сурагч Г.Энхдарь, 5 настай

A child's painting on a blue background. In the upper left, there is a vibrant rainbow with red, orange, yellow, green, and purple bands. Below the rainbow are several white, fluffy clouds. The background is a textured blue with some lighter blue brushstrokes. At the bottom of the page, there is a white horizontal band with a row of black rectangular shapes, resembling a film strip or a decorative border.

04

АУДИТЛАГДСАН
САНХҮҮГИЙН
ТАЙЛАН



“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

Мандал даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид Мандал даатгал ХК (цаашид "компани" гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, Мандал даатгал ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн 2020 оны Сангийн сайдын 132 тоот тушаалаар батлагдсан Даатгалын байгууллагад мөрдөх "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга бэлтгэх заавар"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлагаа гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно. Үүнд:

Санхүүгийн болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын түр зөрүүнээс үүссэн олз болон гарзыг ирээдүйн тайлант хугацааны татвар ногдуулах орлогын дүнд нөлөө үзүүлэх хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй байна.

Уг зөрүүнээс үүссэн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дүн нь материаллаг хэмжээний биш бөгөөд компанийн НББ-ийн программ хангамжийн төвөгтэй байдлаас хамааран аудитаар залруулаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлангаас бусад мэдээллийг хамруулна. Жилийн тайлан нь энэ аудитын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд энэхүү бусад мэдээлэлд баталгаажуулалтын ямар нэгэн төрлийн дүгнэлт өгөөгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага нь дээр тодорхойлсон бусад мэдээлэл нь нээлттэй болсон үед уншиж танилцана. Ингэхдээ бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэгтэй материаллаг хэмжээгээр нийцэхгүй бөгөөд буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх зорилготой.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Байгууллагын удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлага нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг бүрдүүлнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ байгууллагын үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй зэргээс бусад тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол уг зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-д завсны дагуу бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залиланг хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар нуух, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг зөрчих зэргээр үйлдэж магадгүй учир залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн мөн эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, тэдгээрийн тооцооллын үндэслэл болон удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайлан дахь санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Компанийг үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг хамруулан аудитаар илэрсэн томоохон асуудлуудыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд танилцуулдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгдэж, тэдгээртэй бидний хараат бус байдлыг хангахад харгалзах бүх холбоо хамаарал, бусад асуудлууд, шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэргийн талаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдол бүхий асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм, журмвар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад тохиолдолд эдгээр асуудлыг аудиторын тайланд тусгадаг. Маш ховор тохиолдолд аудитор нь ийм мэдээллийг ил тод болгосноор нийгэмд учирах сөрөг үр дагавар нь олон нийтийн хүртэх өгөөжөөс давамгайлна гэж үзэх үл үндэслэлтэй хүлээлт байгаа бол аудитор нь дээрх мэдээллийг аудиторын тайланд мэдээлэхгүй байж болно.

Бүхий хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын тогтоол

Монгол улсад даатгалын үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль тогтоомж нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, СЗХ-ны тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрэм, журмууд байна.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлангах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Эдгээр санхүүгийн тайлан нь 2020 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн Сангийн сайдын 132 тоот тушаалаар батлагдсан "Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал"-ыг баримталж санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.


Төлбөрийн чадварын талаар

Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний бийдлээр төлбөрийн чадварын харьцаа 161.40% (2019: 157.53%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэсний дагуу байна.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

мянган төгрөг	Тодруулга	2019	2020
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	904,137	2,230,334
Даатгалын авлага	6	6,253,418	5,256,775
Бусад санхүүгийн хөрөнгө	7	618,472	376,269
Бусад санхүүгийн бус хөрөнгө	8	867,695	560,599
Хөрөнгө оруулалт	9	27,638,364	31,355,450
Даатгалын хөрөнгө	10	3,857,214	13,748,739
Үндсэн хөрөнгө	11	537,192	1,483,514
Биет бус хөрөнгө	12	69,519	144,057
Нийт хөрөнгө		40,746,011	55,155,737
Өр төлбөр ба эзэмшигчийн өмч			
Өр төлбөр			
Даатгалын өглөг	13	1,850,517	2,913,586
Бусад санхүүгийн өр төлбөр		-	19,074
Бусад санхүүгийн бус өр төлбөр	14	738,085	1,776,045
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	15	12,834,046	21,371,085
Нөхөн төлбөрийн нөөц сан	16	4,594,113	6,421,757
Нийт өр төлбөрийн дүн		20,016,761	32,501,547
Эздийн өмч			
Хувьцаат капитал	17	6,243,016	6,243,016
Нэмж төлөгдсөн капитал		4,441,896	4,441,896
Дахин үнэлгээний нэмэгдэл		(71,096)	(147,148)
Хуримтлагдсан ашиг		10,115,434	12,116,426
Нийт эздийн өмчийн дүн		20,729,250	22,654,190
Нийт өмч ба өр төлбөр		40,746,011	55,155,737

Энэхүү санхүү байдлын тайланг 111-с 143 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

мянган төгрөг	Тодруулга	2019	2020
Даатгалын хураамжийн нийт орлого	18	28,927,212	33,224,744
Даатгалын хураамжийн буцаалт	18	(2,210,956)	(1,599,998)
Давхар даатгалын хураамжийн зардал	18	(10,842,392)	(15,220,697)
Даатгалын хураамжийн цэвэр орлого		15,873,864	16,404,049
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	18	(281,307)	8,537,040
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	18	(267,079)	(9,140,559)
Орлогод тооцсон хураамж		16,422,250	17,007,568
Нийт нөхөн төлбөрийн зардал	18	5,422,537	7,862,275
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	18	674,283	640,962
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	18	384,427	57,144
Нөхөн төлбөрийн цэвэр зардал		4,363,827	7,164,169
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	18	1,683,438	985,026
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	18	415,132	(634,774)
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	18	(472,722)	842,618
Зардалд тооцсон нөхөн төлбөр		5,989,675	8,357,039
Даатгалын гэрээний зардал	19	(1,177,917)	(1,541,836)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	20	82,585	127,740
Хөрөнгө оруулалтын орлого ба олз	21	3,734,284	4,788,912
Даатгалын үйл ажиллагааны ашиг		13,071,527	12,025,345
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		26,127	29,655
Бусад орлого		51,451	344,953

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(үргэлжлэл)

мянган төгрөг	Тодруулга	2019	2020
Ерөнхий ба удирдлагын зардал	22	(5,611,432)	(6,600,523)
Борлуулалт, маркетингийн зардал	23	(1,014,256)	(940,021)
Санхүүгийн зардал	24	-	(254,691)
Бусад зардал	25	(3,104)	(417,554)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз		14,956	824,660
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны гарз		366	-
Бусад алдагдал		(6,535,892)	(7,013,611)
Татварын өмнөх ашиг (алдагдал)		6,535,635	5,011,734
Орлогын татварын зардал	26	665,047	477,666
Татварын дараах ашиг (алдагдал)		5,870,588	4,534,068
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг			
Тайлант үеийн цэвэр ашиг		5,870,588	4,534,068
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		(91,587)	(76,052)
Орлогын нийт дүн		5,779,001	4,458,016
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		0.009	0.007

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 111-с 143 дугаар хуудсан дахь тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

мянган төгрөг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг / (алдагдал)	Нийт
2019 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	6,243,016	4,441,896	20,490	4,869,148	15,574,550
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	5,870,588	5,870,588
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(91,586)	-	(91,586)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(624,302)	(624,302)
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,243,016	4,441,896	(71,096)	10,115,434	20,729,250
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	4,534,068	4,534,068
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	(76,052)	-	(76,052)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	(35,870)	(35,870)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(2,497,206)	(2,497,206)
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	6,243,016	4,441,896	(147,148)	12,116,426	22,654,190

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг 111-с 143 дугаар хуудсан дахь тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

мянган төгрөг	2019	2020
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	26,805,666	33,191,584
Даатгалын хураамжийн орлого	24,985,154	31,390,135
Давхар даатгалын нөхөн төлбөр	731,903	929,034
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	1,421
Бусад мөнгөн орлого	1,088,609	870,994
Мөнгөн зарлагын дүн (-)	(24,073,267)	(29,935,749)
Ажиллагчдад төлсөн	(2,494,071)	(3,438,296)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(621,390)	(361,600)
Бараа материал худалдан авахад төлсөн	-	(35,764)
Ашиглалтын зардалд төлсөн	(12,701)	(20,879)
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж	(10,039,789)	(13,976,368)
Нөхөн төлбөрт төлсөн	(5,335,014)	(7,505,807)
Үүнээс: Сайн дурын даатгалын	(5,069,365)	(7,066,336)
Албан журмын даатгалын	(265,649)	(439,470)
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	(75,725)	(179,477)
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр	(714,760)	(835,086)
Даатгалын хохирол үнэлэгчид төлсөн төлбөр	-	(2,830)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(39,782)	(51,031)
Хүүний төлбөрт төлсөн	-	(254,692)
Татварын байгууллагад төлсөн	(989,476)	(779,585)
Даатгалын төлбөрт төлсөн	(2,834)	(238)
Бусад мөнгөн зарлага	(3,747,725)	(2,494,097)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,732,399	3,255,835
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	37,921,898	44,946,333
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	587	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	34,522,997	42,558,794
Хүлээн авсан хүүний орлого	3,367,923	2,287,228
Хүлээн авсан ногдол ашиг	30,391	100,311
Мөнгөн зарлагын дүн (-)	(42,271,073)	(44,498,686)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(189,342)	(459,823)

мянган төгрөг	2019	2020
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(48,541)	(265,813)
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(42,033,190)	(43,773,050)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,349,175)	447,647
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	-	5,119,684
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	5,100,000
Ханшийн зөрүү	-	19,684
Мөнгөн зарлагын дүн (-)	(561,390)	(7,496,969)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	(5,100,000)
Төлсөн ногдол ашиг	(561,390)	(2,243,347)
Бусад	-	(153,622)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(561,390)	(2,377,285)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(2,178,166)	1,326,197
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,082,303	904,137
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	904,137	2,230,334

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг тодруулгуудын хамт унших бөгөөд 111-с 143 дугаар хуудсан дахь тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Компани нь 2011 оны 4 дүгээр сарын 26-нд “Мандал Женерал” ХХК нэртэйгээр Монгол улсад үүсгэн байгуулагдаж, 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр “Мандал даатгал” гэж нэрээ өөрчилсөн.

Компани нь 2018 онд нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч зах зээл дээр арилжаалж, 2018 оны 9 дүгээр сарын 21-нд хувьцаат компанийн хэлбэрт шилжин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн.

Үйл ажиллагааны чиглэл: Ердийн даатгалын үйл ажиллагааны хүрээнд Гэнэтийн осол, эмчилгээний, Хөрөнгийн, Авто тээврийн хэрэгслийн, Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын, Хариуцлагын, Барилга угсралтын, Ачааны, Санхүүгийн, Агаарын хөлгийн, Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын зэрэг даатгалын төрөл байна.

Компанийн хүний нөөц: Компанийн ажилтнуудын дундаж тоо 2020 оны туршид 145 (2019 онд: 123) байсан

Бүртгэгдсэн хаяг: Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Паркплейс Оффис” барилгын 1, 3, 4, 5 дугаар давхруудад байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани одоогоор 11 хэлбэрийн даатгалын үйл ажиллагаа эрхлэн, 2 салбартайгаар ажиллаж байна.

2. СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагаа

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл (“НББОУСЗ”)–өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)–д нийцүүлэн 2020 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн Сангийн сайдын 132 тоот тушаалаар батлагдсан “Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлалын дагуу бэлтгэсэн.

Эдгээр зааварт санхүүгийн тайлангуудын хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэхийг шаарддаг хэдий ч, СТОУС-ын толилуулга болон тодруулгын шаардлагуудыг дагаж мөрддөггүй. Эдгээр санхүүгийн тайланг Компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангууд болон түүний тодруулгуудыг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Гүйцэтгэх захирал Б.Жавхлан, Ерөнхий нягтлан бодогч Г.Баярцэцэг нар баталсан.

Ковид-19-н санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийн ерөнхий үнэлгээ

НББОУС 1-д заасны дагуу удирдлага нь тайлант хугацаанаас хойш багадаа 12 сарын ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэх асуудлууд байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Ийнхүү үнэлэхдээ одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, боломжит санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадавхи зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ үүсгэх томоохон үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой тодорхойгүй байдал байхгүй байна.

3. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

3.1. 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд

2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх мэдэгдлүүд байгаа бөгөөд тэдгээр нь байгууллагын санхүүгийн үр дүн болон байдалд томоохон нөлөө үзүүлэхээргүй байна. Байгууллагад хамааралтай дараах стандартуудын өөрчлөлт нь 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөгдөж эхэлсэн. Үүнд:

- Бизнесийн тодорхойлолт (СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт)
- Материаллаг байдлын тодорхойлолт (НББОУС 1 болон НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт)
- Хүүгийн түвшний суурь үзүүлэлтийн шинэчлэлт (СТОУС 9, СТОУС 7-ын нэмэлт өөрчлөлт)
- Суурь үзэл баримтлалд хамаарах нэмэлт өөрчлөлтүүд
- Ковид-19 Түрээсийн гэрээний өөрчлөлт (СТОУС 16-ын нэмэлт өөрчлөлт)

3.2. Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУС3-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Байгууллага нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Байгууллагын удирдлага тухайн өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар мөрдөж эхлэхээр төлөвлөж байна. Тайлант онд дагаж мөрдөх шаардлагагүй тухайн өөрчлөлтүүдийг тодруулаагүй ба тэдгээр нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй.

Тайлант онд хүчин төгөлдөр болоогүй стандарт, нэмэлт өөрчлөлтүүд нь:

- СТОУС 17 Даатгалын гэрээ
- Суурь үзэл баримтлалын өөрчлөлт
- Ашиглалтаас өмнөх борлуулалт (НББОУС 16-ын нэмэлт өөрчлөлт)
- (алдагдал)-тай гэрээ – Гэрээг биелүүлэх өртөг (НББОУС 37-ын нэмэлт өөрчлөлт)
- Стандартын жил тутмын шинэчлэлт 2018-2020 Мөчлөг (СТОУС 1, СТОУС 9, СТОУС 16, НББОУС 41-ийн нэмэлт өөрчлөлт)
- Өр төлбөрийн богино болон урт хугацаат ангилал (НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт)

СТОУС 17 Даатгалын гэрээ

СТОУС 17 Даатгалын гэрээ нь түүний цар хүрээнд хамаарах даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга, тодруулгын зарчмуудыг тогтоодог. СТОУС 17-гийн зорилго нь даатгалын гэрээг үнэн зөв илэрхийлэх, холбогдох мэдээллийг аж ахуйн

нэгж бэлтгэдэг эсэхийг ханган магадлахад оршино. Энэ мэдээлэл нь аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээнд тухайн даатгалын гэрээний үзүүлэх үр нөлөөг санхүүгийн тайланг хэрэглэгч нар үнэлэх суурь үндэслэлээр хангадаг.

2019 оны 9 дүгээр сарын 25-нд НББОУСЗ нь тус стандартын хэрэгжилт эхлэх өдрийг 1 жилээр хойшлуулсан бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс стандартыг хүчин төгөлдөр хэрэгжүүлж эхэлнэ.

СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр

Компани нь СТОУС 17-г 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхлэхтэй холбоотой СТОУС 9-өөс түр чөлөөгдөх ба СТОУС 17 хэрэгжүүлэх хүртэл НББОУС 39-ийг мөрдөнө.

Удирдлага нь тухайн стандартын өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх өдрөөс мөрдөх төлөвлөгөөтэй байна.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

4.1. Бүртгэлийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг аккрузель сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

4.2. Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг нь Компанийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдлыг хамгийн тохиромжтой илэрхийлж байгаа учраас төгрөг нь уг Компанийн үйл ажиллагааны валют юм.

Санхүүгийн тайлангуудын хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлага үзэж байгаа учраас эдгээр санхүүгийн тайлангуудыг (өөрөөр заагаагүй бол) Монгол төгрөгөөр толилуулна. Монгол төгрөгөөр илэрхийлсэн санхүүгийн бүх мэдээлэл мянган төгрөгөөр бүхэлтгэн илэрхийлэгдсэн.

4.3. Гадаад валют хөрвүүлэг

Гадаад валютаарх ажил гүйлгээ

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн 1 ам.доллартай харьцах ханш 2,849.51 төгрөг (2019 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,733.52 төгрөг) байв. Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана.

4.4. Даатгалын хөрөнгө

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг тайлагналын өдөр Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) болон Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)-ийн тайлант хугацаанд давхар даатгагчид ногдох хэсгийг актуарчийн тооцоолсон дүнгээр бүртгэдэг.

Давхар даатгалын хойшлогдсон хураамж нь давхар даатгалын хураамжийн давхар даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг юм.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдлийг давхар даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр давхар даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа давхар даатгалын гэрээ тус бүрийн хувьд гэрээний үлдэх хугацаанд хувь тэнцүүлэх аргаар тооцдог.

Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал нь даатгалын гэрээг олж бэлтгэхтэй холбогдон гарсан зардлын тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг байдаг.

Тухайлбал зуучлагч болон төлөөлөгчийн даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал, даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан даатгалын гэрээний хойшлогдсон бусад зардлаас бүрддэг.

4.5. Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Бараа материалын өртөг эхэлж авснаа эхэлж зарлагдах зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон одоогийн байршил, нөхцөлд авчрахтай холбоотой гарсан бүх зардал багтана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно.

4.6. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө нь түүхэн өртгөөс элэгдлийг хассан дүнгээр илэрхийлэгдэнэ. Түүхэн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан бүртгэнэ. Санхүүгийн түрээсийн хөрөнгүүд нь компьютер дагалдах хэрэгслийн адил бүртгэгдэнэ. Ажил үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн зорилгоор ашиглаж буй үндсэн хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхлэнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Биет хөрөнгийн ангилал	Санхүүгийн тайлангаар	Татварын тайлангаар
Автомашин	- 5 жил	- 10 жил
Тавилга, эд хогшил	- 10 жил	- 10 жил
Бусад	- 10 жил	- 10 жил
Компьютер, дагалдах хэрэгсэл	- 2 жил	- 2 жил

Ашиглах эрхийн хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлохдоо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчлэнэ.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

4.7. Биет бус хөрөнгө

Дотооддоо хөгжүүлсэн программ хангамж

Мэдээлэл технологийн, харилцаа холбооны системийн зорилгоор шинээр хөгжүүлж буй программ хангамжийн судалгааны зардлыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хөгжүүлэлтийн үе шатанд гарсан зардлыг дараах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд биет бус хөрөнгөд хуримтлуулан бүртгэнэ. Үүнд:

- Хөгжүүлэлтийн зардлыг бодитоор хэмжиж болох
- Төслийн техникийн болон арилжааны үр дүн амжилттай болох нь тодорхой
- Компани нь тухайн төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай хангалттай нөөцтэй
- Тухайн программыг ашиглах эсвэл борлуулах боломжтой
- Тухайн программаас ирээдүйн эдийн засгийн өгөөж ирэх нь тодорхой

Дээрх капиталжуулалтын шаардлагыг хангаагүй зардлууд нь зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Холбогдох зардлуудад программ хөгжүүлэхтэй холбоотой гарсан ажилчдын зардал, зээлийн өртөг болон нэмэгдэл зардлууд нь хөгжүүлэлтэд хамаарах хэмжээгээр хуваарилагдана.

Дараа үеийн хэмжилт

Ашиглах хугацаа нь тодорхой дотооддоо хөгжүүлэн капиталжуулсан программ зэрэг биет бус хөрөнгүүдийг өртгийн аргаар бүртгэх ба ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна. Үлдэх өртөг болон ашиглах хугацааг тайлант жил бүр дахин тооцно. Мөн үнэ цэнийн бууралтын тест хийнэ. Биет бус хөрөнгүүдийн ашиглах хугацаа нь: 3 жил байна.

Капиталжуулж буй хөгжүүлэлт нь дуусаагүй программ хангамжийг хорогдуулахгүй боловч үнэ цэнэ бууралтын тест хийнэ.

Хорогдуулсан зардал нь санхүүгийн бус хөрөнгийн элэгдэл, хорогдол, үнэ цэнэ бууралтын дансанд бүртгэгдэнэ.

4.8. Түрээсийн хөрөнгө

Тодруулга 3-т тусгагдсаны дагуу Компани нь СТОУС 16-г цаашид гүйцээж мөрдөнө. Иймд зэрэгцүүлсэн мэдээлэл нь НББОУС 17 болон СТОУТХ-ны тайлбар 4-н дагуу илэрхийлэгдэнэ.

Түрээслэгчийн түрээсийн тооцоолол болон бүртгэл

Түрээс эхлэх өдрөөр Компани нь санхүү байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээс өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхийн хөрөнгийг өртгөөр нь хэмжих ба энэ нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилт, Компанийн зарцуулсан аливаа шууд зардал, түрээсийн хугацааны эцэст хөрөнгийг буулгах, нураахтай холбоотой тооцоолсон зардал болон түрээс эхлэх өдрөөс өмнө хийгдсэн урьдчилгаа төлбөрийн нийлбэр юм.

Компани нь ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нөхцөл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар элэгдүүлнэ. Мөн ашиглах эрхийн хөрөнгөд үнэ цэнэ буурах нөхцөл бүрдсэн бол үнэ цэнийг бууруулна.

Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцохдоо Компани нь ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүний түвшинг (тодорхойлох боломжгүй бол зээлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг) ашиглан дискаунтчилан тооцно.

Түрээсийн өр төлбөрийн тооцоололд тогтмол төлбөрүүд, индекс эсвэл ханш дээр суурилсан хувьсах төлбөрүүд, гэрээт хугацааны эцэст төлөх нь тодорхой болсон бусад төлбөрүүд хамаарна.

Дараа үеийн хэмжилтийн үед өр төлбөр нь төлсөн төлбөрөөр буурч, тооцоолсон хүүгээр өснө. Өр төлбөр нь гэрээлсэн тогтмол төлбөрт өөрчлөлт орох үед болон аливаа бусад төлбөрийн тооцоололд өөрчлөлт орох үед дахин тооцоологдоно.

Түрээсийн өр төлбөр дахин тооцоологдоход түүнд хамаарах ашиглах эрхийн хөрөнгөд тохируулга хийгдэх ба хэрэв ашиглах эрхийн хөрөнгө үлдэгдэлгүй болсон бол ашиг алдагдалд тохируулга хийгдэнэ.

Санхүүгийн байдлын тайланд ашиглах эрхийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөр, түрээсийн өр төлбөрийг дансны болон бусад өглөгөөр илэрхийлнэ.

Компани нь богино хугацааны түрээс, бага өртөг бүхий хөрөнгийн түрээсийг өөрийн практик туршлагад үндэслэн ангилан бүртгэнэ. Тэдгээр хөрөнгүүдийг ашиглах эрхийн хөрөнгө болон түрээсийн өр төлбөр гэж бүртгэхгүй ба харин холбогдох төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар ашиг, алдагдалд зардлаар хүлээн зөвшөөрнө.

4.9. Биет бус хөрөнгө болон үндсэн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын тест

Хөрөнгүүдийг үнэ цэнийн бууралтын зорилгоор тусдаа мөнгөний урсгал (мөнгө бий болгогч нэгж)-д суурилан боломжит хамгийн жижиг бүлгүүдэд хуваадаг. Үүний үр дүнд зарим хөрөнгийн үнэ цэнийн бууралт дангаараа хийгддэг бол зарим хөрөнгүүд мөнгө бий болгогч нэгжийн түвшинд үнэлэгддэг.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан дүнгийн аль өндрөөр тодорхойлогдоно. Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо удирдлага нь мөнгө бий болгогч нэгж бүрийн ирээдүйн мөнгөн урсгалыг тооцох ба тухайн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцохын тулд зохих дискаунтын түвшинг тодорхойлдог. Үнэ цэнийн бууралтын тестэд ашигласан мэдээлэл нь ирээдүйд гарах зохион байгуулалтын өөрчлөлт, хөрөнгийн сайжруулалтын үр нөлөөг хамруулаагүй компанийн хамгийн сүүлд батлагдсан төсөвт үндэслэдэг. Мөнгө бий болгогч нэгж бүрт дискаунтын хүчин зүйлсийг тодорхойлох бөгөөд мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон хөрөнгийн тусгайлсан эрсдэлийн хүчин зүйлсийг тусгасан зах зээлийн үнэлгээнд суурилдаг.

Мөнгө бий болгогч нэгжид үнэ цэнэ бууралтын гарзыг хуваарилахдаа тухайн нэгжид хамаарах гүүдвэлийн үлдэгдлийг хамгийн эхэнд бууруулна. Үлдсэн гарзыг нь мөнгө бий болгогч нэгжид хамаарах хөрөнгүүдэд тэнцүүлсэн хэмжээгээр хуваарилна.

4.10. Санхүүгийн хэрэглүүр

Компани нь СТОУС 17-г 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхлэхтэй холбоотой СТОУС 9-өөс түр чөлөөгдөх ба СТОУС 17 хэрэгжүүлэх хүртэл НББОУС 39-ийг мөрдөнө.

Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, шагнал шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр анхлан хэмжсэн бөгөөд ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлснээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртөгийг нэмсэн дүнгээр хэмжинэ.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Дараа үеийн хэмжилтийн зорилгоор хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгө анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр дараах категорит хуваагдана.

- Зээл ба авлага
- Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд хэрэглүүрийн шинж чанар, зорилгоос шалтгаалан анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр өөр өөр категорит ордог. Санхүүгийн хэрэглүүрийн категори нь түүний хэмжилт, санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал хамааралтай. Компанийн категорилсон санхүүгийн хөрөнгийн хураангуйг Тодруулга №30-аас харна уу.

Компани ерөнхийдөө бүх санхүүгийн хөрөнгөө төлбөр тооцоо хийх өдрийн бүртгэлээр хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэх талаарх үнэлгээг ядаж тайлант хугацааны эцэс бүрт хийнэ. Бусад зардалд толилуулсан даатгалын авлагын үнэ цэнийн бууралтаас бусад ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого, зардлыг санхүүгийн зардал, санхүүгийн орлого эсвэл бусад санхүүгийн зүйлсэд толилуулна.

I. Зээл ба авлага

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм. Зээл, авлагад даатгалын ба бусад авлага, гар дээрх бэлэн мөнгө болон банкин дах мөнгө багтана

Даатгалын авлага

Даатгалын авлага нь даатгалын бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүссэн бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн нэхэмжлэх дүн байна. Үүнд: даатгалын хураамжийн авлага, буруутай этгээдээс авах авлага, давхар даатгагчаас авах авлага хамаарна.

Сангийн сайдын 2020 оны 132 тоот тушаалаар баталсан Даатгалын компанид мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн зааврын 3.2 Даатгалын авлага хэсэгт "Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно" гэж заасны дагуу авлагын шууд аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл авлага төлөгдөх найдваргүй гэдэг нь тогтоогдсон үед авлагыг данснаас хасдаг.

Бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл

Компанийн бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкин дах дансад болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

II. Ашиг, алдагдын дараах бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгийг худалдах зорилгоор эзэмшиж буй эсвэл анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг ашиг алдагдлаар тусгадаг гэж ангилна. Уг тодорхойлолтын дагуу хейджийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй бүх дериватив санхүүгийн хэрэглүүр энэ категорит багтана.

Дериватив санхүүгийн хэрэглүүрээс үүсч буй аливаа олз, гарз нь бодит үнэ цэнийн өөрчлөлтөд суурилдаг. Уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг идэвхтэй зах зээлийн ажил гүйлгээг, идэвхтэй зах зээл байхгүй бол үнэлгээний аргачлалт ашиглан тодорхойлно.

III. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба дараа үе дэх өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз, гарзыг зөвхөн борлуулагдсан эсвэл тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнэ буурсан тохиолдолд өмнө нь бусад орлогод хүлээн зөвшөөрсөн аливаа алдагдлыг ашиг алдагдалд шилжүүлнэ. Орлогын тайлангийн өмчийн хэрэглүүрт хүлээн зөвшөөрсөн алдагдлыг орлогын тайлангаар дамжуулж буцаахгүй харин өмчийг тохируулна. Дараах үеийн өсөлт нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дараа үүсэх үйл явдалд бодитоор холбогдох боломжтой бол өрийн үнэт цаасны үнэ цэнийн бууралтын дүнд бий болсон өмнөх тайлант хугацааны орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн гарзыг орлогын тайлангаар дамжуулж буцаана.

IV. Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө нь тогтоосон эсвэл тодорхойлж болох төлбөртэй, тогтоосон дуусах хугацаатай дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд арилжааны банкууд дах хадгаламж үүнд орно. Компанийн удирдлага хөрөнгө оруулалтыг хугацаа нь дуустал эзэмших зорилготой бол түүнийг хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалтаар ангилна.

Хадгаламжийг дараах үед үр ашигт хүүний арга ашиглан хорогдсон дүнгээр хэмжинэ. Мөн хадгаламжийн үнэ цэнэ буурсан гэсэн бодитой нотолгоо байвал санхүүгийн хөрөнгийг урьдчилан тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ. Хадгаламжийн дансны дүнд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт даатгалын ба бусад өглөг орно. Компанийн санхүүгийн өр төлбөрийн категорилсон хураангуйг Тодруулга №30-д харуулав.

VI. Зээл ба зээллэг

Зээлийг түүнтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг тухайн зээллэгийг эзэмшигчээс авснаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Тийм тохиолдолд бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг өмчид нэмэлт капиталаар хүлээн зөвшөөрнө. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээл ба зээллэг нь өртөг

болон үр ашигт хүүгийн сууриарх зээллэгийн хугацааны турш ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн төлөх үеийн үнийн зөрүүний хамт хорогдлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Хөрөнгийн нэг хэсэг болгон капиталжуулсан бэлтгэл шаардлагатай хөрөнгийн худалдан авалт, барилга эсвэл үйлдвэрлэлд шууд холбоотой зээлийн өртгөөс бусад зээллэгтэй холбоотой үүссэн хүү болон бусад зардлыг санхүүгийн зардлын хэсгээр хүлээн зөвшөөрнө.

VII. Даатгалын ба бусад өглөг

Даатгалын ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртөгөөр илэрхийлнэ.

Даатгалын өглөг

Даатгалын өглөгт даатгалын үйл ажиллагаатай холбоотой өглөгүүд хамаарна. Үүнд: даатгалын хураамжийн буцаалтын өглөг, даатгалын гэрээний шимтгэлийн өглөг, давхар даатгагчид өгөх өглөг хамаарна.

4.11. Эздийн өмч

Эздийн өмч нь компанийн бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө юм. Хувь нийлүүлсэн хөрөнгө гэж даатгалын компаниас гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг хэлнэ.

Нэмж төлөгдсөн капитал нь хувьцааны нэрлэсэн үнээс илүү төлөгдсөн зөрүүг хэлнэ.

Хуримтлагдсан ашиг гэж үйл ажиллагаа эхэлсэн үеэс хуримтлагдаж, ногдол ашиг хуваарилах буюу сан байгуулсны дараа үлдэж буй цэвэр ашиг юм.

Эздийн өмчийн бусад хэсэг нь тусгай зориулалтын сан, хувьцаанд суурилсан төлбөр, хувьцаа эзэмшигчдээс оруулсан бусад хөрөнгө, гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц, бусад өөрийн хөрөнгөөс бүрдэнэ.

Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

4.12. Нэгж хувьцаанд ногдох ашиг

Компани энгийн хувьцааны хувьд нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог. Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах цэвэр ашиг, алдагдлыг тайлант хугацааны туршид эргэлтэнд байсан энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоонд хуваах замаар нэгж хувьцаанд ногдох суурь ашгийг тооцоолдог.

4.13. Нөөц, болзошгүй хөрөнгө, өр төлбөр

Бүтээгдэхүүний баталгаа, шүүхийн маргаан, алдагдалтай гэрээ, амралтын цалингийн нөөц, үр дүнгийн цалин гэх зэрэг бусад төлбөрийг үүрэг өнгөрсөн үйл явдлын үр дүнд бий болж, уг үүрэг хариуцлагыг барагдуулахад эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал шаардагдах магадлалтай бөгөөд мөнгөн дүнг найдвартай хэмжих боломжтой болсон үед нөөцөөр зөвшөөрнө.

Бүтцийн өөрчлөлтийн нөөцийг өөрчлөлтийн талаар албан ёсны төлөвлөгөө гарсан ба удирдлага нь төлөвлөгөөний гол мэдээллийг холбогдох ажилтнуудад мэдээлсэн тохиолдолд хүлээн зөвшөөрнө. Ирээдүйд хүлээх алдагдалд нөөц байгуулахгүй.

Нөөцийг тайлангийн өдрөөр мэдэгдэж буй хамгийн найдвартай нотолгоонд үндэслэсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зардлын мэдээлэлд суурилан тооцно. Хэд хэдэн ижил төстэй үүрэг үүссэн үед, үүрэг хариуцлагын төрлөөр нь тэдгээрийг

барагдуулахад шаардлагатай гарах урсгалын магадлалыг тооцдог. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөө үзүүлэхүйц бол нөөцийн өнөөгийн үнэ цэнийг дискаунтчлан тооцдог.

Компанийн гуравдагч талаас авах нь тодорхой болсон нөхөн олговрыг тусад нь хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Тус дүн нь холбогдох нөөцийн дүнгээс ихгүй байна.

Тухайн үүргийг барагдуулахтай холбоотой эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь магадлалтай биш үед өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй. Эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь бага дүнтэйгээс бусад үүссэн нөхцөлийг болзошгүй өр төлбөрөөр санхүүгийн тайланд тодруулна.

4.14. Даатгалын нөөц сан

Нөөц сангуудыг даатгалын төрөл тус бүрээр байгуулна. Үүнд: Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН), Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС).

ОТХН-д даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсэг ордог.

УБМХНС-г тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнгээр хэмждэг.

УБХНС-г тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц сангаар хэмждэг.

МБТХНС-г даатгалын тохиолдол болсон тухай даатгагч мэдэгдсэн боловч төлөөгүй байгаа нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнгээр тодорхойлдог.

4.15. Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг хүлээн авсан мөнгө эсвэл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Даатгалын орлогод даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг багтдаг.

Даатгалын гэрээний үндсэн дээр даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг Даатгалын хураамжийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Давхар даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулсны төлөө давхар даатгагчаас төлөх шимтгэлийг Давхар даатгалын шимтгэлийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Давхар даатгалын гэрээний дагуу давхар даатгагчаас авсан буюу авахаар тохиролцсон даатгалын нөхөн төлбөрийг Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Даатгалын зүйлд даатгалын эрсдэл тохиолдож даатгагчаас нөхөн төлбөрийг даатгуулагчид төлсөн бөгөөд тухайн нөхөн төлбөрийн зарим хэсгийг эсвэл бүхэлд нь буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн хэмжээг Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Нөөц сангийн хөрөнгө, дүрмийн сангийн хөрөнгө болон тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан сул чөлөөтэй хөрөнгийг арвижуулах зорилгоор байршуулснаар олсон орлого, олзыг Хөрөнгө оруулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэдэг

4.16. Даатгалын зардал

Давхар даатгалын хураамж нь давхар даатгалын гэрээний үндсэн дээр даатгагч өөрийн даатгалын эрсдлийг давхар даатгагчид шилжүүлсний төлөө төлөх төлбөр байна.

Даатгалын хураамжийн буцаалт нь даатгалын гэрээ цуцлагдахад гэрээний үлдэх хугацаанд ногдох хураамжаас гэрээнд заасны дагуу даатгуулагчид өгөх даатгалын хураамж байна.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт нь ОТХНөөцийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. ОТХНөөцийг нэмж байгуулах үед зардал, бууруулж байгуулах үед орлого утгатай байна.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт нь Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Нөхөн төлбөрийн зардал гэж даатгалын зүйлд даатгалын гэрээнд заасан эрсдэл тохиолдож даатгагчаас хохирлыг барагдуулахаар олгож буй төлбөр байна.

Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт нь УБМХНС болон МБТХНС-г байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. УБМХНС болон МБТХНС-г нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Нөхөн төлбөрийн нөөцийн Давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт нь УБМХНС болон МБТХНСангийн давхар даатгагчид ногдох хэсгийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Даатгалын нөөцийн Давхар даатгагчид ногдох УБМХНС болон МБТХНСанг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт нь УБХНС-г байгуулахад зориулсан зардлын данс байна.

Даатгалын гэрээний зардал гэж даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан зардал байна.

4.17. Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тооцооллын тодорхойгүй байдалд удирдлагын шийдлийг ашиглах нь

Компанийн удирдлага санхүүгийн тайлан бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардал хүлээн зөвшөөрөхтэй холбоотой шийдэл, тооцоолол, таамаглал ашигладаг.

Удирдлагын томоохон тооцоолол, таамаглал

Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо баримтлахад үүсдэг санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхүйц удирдлагын тооцоолол, таамаглалыг доор харуулав. Үүнд:

Даатгалын нөөц сангийн тооцоолол

Компанийн актуарч нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос гаргасан Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын дагуу даатгалын хураамжийн нөөц болон даатгалын нэхэмжлэлийн нөөц сангуудыг тооцоолдог.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг (ОТХН) даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд "хувь тэнцүүлсэн арга"-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлдог. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг (УБМХНС) даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистикт тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд (МБТХНС) тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, и-мэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг (УБХНС) даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

Аудитын явцад нөөц сангийн тооцооллыг хөндлөнгийн шинжээч-актуарч давтан тооцоолж, шалгасан.

Хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрөлт

Хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө шилжүүлсэн татварын алданги болон хасагдах түр зөрүү нь ирээдүйн татвар ногдох орлогоор нөхөгдөх магадлалын үнэлгээнд үндэслэнэ. Мөн татварын орчин дахь хууль эрх зүйн болон эдийн засгийн хязгаарлалт, тодорхойгүй байдлын нөлөөллийг үнэлж дүгнэдэг.

Элэгдэх хөрөнгийн ашиглагдах жил

Удирдлага нь элэгдэх хөрөнгөд ашиглагдах жилийг хөрөнгийн ашиглалттай уялдуулан тайлант хугацаа бүрт тооцдог. Компьютер дагалдах хэрэгсэлтэй холбоотой үүсч болзошгүй технологийн хоцрогдол нь тус тооцооллыг тодорхойгүй болгож болно.

Бодит үнэ цэнийн хэмжилт

Удирдлага нь санхүүгийн хэрэглүүр болон санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлгээний арга ашигладаг. Зах зээлд оролцогчид уг хэрэгслийг хэрхэн үнэлж байгаатай уялдаатайгаар тооцоо, таамаглалыг боловсруулдаг. Удирдлага нь таамаглалыг байнга нээлттэй байдаггүй боломжит мэдээллүүдэд үндэслэдэг. Тооцоолсон бодит үнэ цэнэ нь тайлагналын өдрөөрх холбоогүй талуудын гүйлгээний бодит үнээс өөр байх магадлалтай.

4.18. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцооллод ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө

бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг ерөнхийдөө түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст эргэж харах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээ (болон татварын хууль)-нд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст Компани хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагаас үүсэх татварын үр дагаварт нөлөөлдөг.

4.19. Ажилчдын богино хугацааны тэтгэмж

Богино хугацааны ажилчдын тэтгэмж

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд дараахийг багтаана. Үүнд:

- (a) цалин урамшуулал;
- (b) ээлжийн амралтын мөнгө, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
- (c) нийгмийн даатгалын шимтгэл болон бусад нийгмийн төлбөрүүд;
- (d) сайн дурын эрүүл мэндийн даатгал.

Ажилчид Компанид тайлант жилд үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд Компани уг үйлчилгээний төлбөрт төлөх ажилчдын богино хугацааны тэтгэмжийн дискаунтлаагүй дүнг хүлээн зөвшөөрдөг. Ингэхдээ:

- (a) Аль хэдийнэ төлсөн дүнг хассаны дараа өр төлбөрөөр (хуримтлагдсан зардал). Аль хэдийнэ төлсөн дүн тэтгэмжийн дискаунтлаагүй дүнгээс давсан бол Компани уг давсан дүнг урьдчилгаа төлбөр нь ирээдүйд хийх төлбөрийг бууруулна эсвэл буцаалт авна гэсэн утгаар хөрөнгөөр (урьдчилж төлсөн зардал) хүлээн зөвшөөрнө.
- (b) Уг дүн нь хөрөнгийн өртөгт ороогүй бол зардлаар.

Цалинтай чөлөө

Цалинтай чөлөө хэлбэрээр олгох ажилчдын богино хугацааны тэтгэмжийн хүлээгдсэн өртгийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:

- (a) Ажилчдын үзүүлж буй үйлчилгээ ирээдүйд цалинтай чөлөө авах эрхийг нэмэгдүүлж байгаа үед хуримтлуулсан цалинтай чөлөөгөөр.
- (b) Чөлөө авах үед хуримтлуулаагүй цалинтай чөлөөгөөр.

Урамшуулал

Компани зөвхөн өнгөрсөн үйл явдлын үр дүнд мөн үүрэг хариуцлагын найдвартай тооцоолол хийх боломжтой тохиолдолд тийм төлбөр хийх өнөөгийн хууль ёсны болон үүсмэл үүрэг хүлээсэн бол урамшууллын төлбөрийн хүлээгдсэн өртгийг хүлээн зөвшөөрнө.

Өнөөгийн үүрэг хариуцлага зөвхөн тухайн аж ахуйн нэгжид төлбөр хийхээс өөр бодитой хувилбар байхгүй тохиолдолд л оршино.

4.20. Санхүүгийн тайлангийн дахин тайлагнал

Компани алдаа илрүүлсний дараа нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт болон өмнөх үеийн алдааны залруулгыг анх баталсан санхүүгийн тайланд буцаж хэрэгжүүлдэг ба ингэхдээ алдаа гарсан өмнөх хугацаанд толилуулсан харьцуулагдах дүнг дахин тайлагнах, эсвэл толилуулсан хамгийн эхний хугацаанаас өмнө алдаа гарсан бол уг толилуулсан хамгийн эхний хугацааны хөрөнгө, өр төлбөр ба өмчийг дахин тайлагнадаг. Санхүүгийн тайланг өмнөх хугацааны харьцуулагдсан мэдээллийн хамт залруулга хийх шаардлага гарсан хугацаандаа хийгдсэн мэтээр толилуулна. Тийм учраас толилуулсан хугацаа бүрт холбогдох залруулгын дүн нь тухайн хугацааны санхүүгийн тайланд багтана.

5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Компани нь мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол Компани нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

мянган төгрөг	2019	2020
Бэлэн мөнгө	3,519	2,652
Банкан дах харилцах данс - Төгрөг	823,117	2,225,531
Банкан дах харилцах данс - Ам доллар	77,403	2,056
Банкан дах харилцах данс - Фунт	98	95
Нийт	904,137	2,230,334

6. Даатгалын авлага

мянган төгрөг	2019	2020
Даатгалын хураамжийн авлага	5,308,773	5,047,246
Буруутай этгээдээс авах авлага	494,020	165,559
Давхар даатгалаас авах авлага	450,625	43,970
Нийт	6,253,418	5,256,775

Даатгалын авлагын насжилт

мянган төгрөг	2019	2020
Хэвийн /30 хүртэл хоног/	5,290,551	4,691,350
Хугацаа хэтэрсэн /31-60 хоног/	109,348	40,798
Хэвийн бус /61-90 хоног/	184,484	128,379
Эргэлзээтэй /91-120 хоног/	127,577	4,006
Муу /121-ээс дээш хоног/	541,458	392,242
Нийт	6,253,418	5,256,775

Компани нь Найдваргүй авлагын нөөц байгуулах бодлогын дагуу авлагыг төлөгдөөгүй хугацаанд үндэслэн ангилж нөөц байгуулдаг байна. Мөн авлагыг эргэн төлөгдөх нь найдваргүй болсон үед авлагын данснаас шууд хасах бодлого баримталдаг ба тайлант хугацаанд 51.1 сая төгрөгийн авлагыг данснаас хасаж, 351.3 сая төгрөгийн нөөц байгуулсан байна.

7. Бусад санхүүгийн хөрөнгө

мянган төгрөг	2019	2020
Ажиллагсдаас авах авлага	11,827	16,941
Цалингийн авлага /урамшуулал/	199,900	223,694
Бусад авлага	406,745	135,634
Нийт	618,472	376,269

Цалингийн авлага /урамшуулал/ дансанд даатгалын гэрээний борлуулсан ажилчдад олгосон урамшууллыг даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хорогдуулан бүртгэсэн байна.

8. Бусад санхүүгийн бус хөрөнгө

мянган төгрөг	2019	2020
НДШ авлага, бусад татварын авлага	2,368	3,315
ААНОАТ-ын авлага	51,964	-
Бараа материал	23,018	37,364
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	790,345	519,920
Нийт	867,695	560,599

9. Хөрөнгө оруулалт

мянган төгрөг	2019	2020
Банкинд байршуулсан хөрөнгө хадгаламж, хадгаламжийн сертификат	14,962,578	23,808,113
Банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө оруулалт	10,118,044	4,756,487
Хувьцаагаарх хөрөнгө оруулалт	1,947,414	1,290,850
Компанийн бонд	610,328	1,500,000
Нийт	27,638,364	31,355,450

10. Даатгалын хөрөнгө

мянган төгрөг	2019	2020
Давхар даатгалын хойшлогдсон хураамж	3,124,174	12,264,734
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг-УБМХНС	21,724	180,597
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг-МБТХНС	111,365	587,267
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал-Даатгалын зуучлагч	503,029	590,545
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал-Даатгалын төлөөлөгч	96,922	125,596
Нийт	3,857,214	13,748,739

*УБМХНС - Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийн сан

**МБТХНС - Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөцийн сан

11. Үндсэн хөрөнгө

мянган төгрөг	Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Ашиглах эрхтэй хөрөнгө/ түрээс/	Нийт дүн
Өртөг						
Эхний үлдэгдэл	130,932	271,292	410,398	138,402	-	951,024
Нэмэгдсэн дүн	333,825	16,273	90,926	21,961	883,059	1,346,044
Худалдаж авсан	333,825	16,273	90,926	21,961	883,059	1,346,044
Хасагдсан дүн (-)	-	-	-	-	-	-
- Худалдсан						
Үндсэн хөрөнгө дахин ангилсан	-	-	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	464,757	287,565	501,324	160,363	883,059	2,297,068
Хуримтлагдсан элэгдэл						
Эхний үлдэгдэл	25,801	80,845	292,400	14,786	-	413,832
Нэмэгдсэн дүн	32,267	28,419	91,294	11,698	236,044	399,722
Байгуулсан элэгдэл	32,267	28,419	91,294	11,698	236,044	399,722
Хасагдсан дүн	-	-	-	-	-	-
Данснаас хассан хөрөнгийн элэгдэл						
Эцсийн үлдэгдэл	58,068	109,264	383,694	26,484	236,044	813,554
Дансны цэвэр дүн						
Эхний үлдэгдэл	105,131	190,447	117,998	123,616	-	537,192
Эцсийн үлдэгдэл	406,689	178,301	117,630	133,879	647,015	1,483,514

Компани Парк плэйс оффисын барилгын 1,3,4,5 давхруудыг 2-5 жилийн хугацаатайгаар оффисийн зориулалтаар түрээслэдэг. СТОУС-16 "Түрээс"-ийн дагуу түрээсийн хөрөнгийн түрээсийн гэрээний төлбөрт төлөх төлбөрийг ӨҮЦ-ээр нь тооцож, ашиглах хугацаанд нь хорогдуулан бусад хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

12. Биет бус хөрөнгө

мянган төгрөг	Компьютерийн програм хангамж	Нийт
Өртөг		
Эхний үлдэгдэл	259,617	259,617
Нэмэгдсэн дүн	185,100	185,100
Хасагдсан дүн (-)	-	-
Эцсийн үлдэгдэл	444,717	444,717
Хуримтлагдсан хорогдуулга		
Эхний үлдэгдэл	190,098	190,098
Нэмэгдсэн дүн	110,562	110,562
Хасагдсан:	-	-
Эцсийн үлдэгдэл	300,660	300,660
Дансны цэвэр дүн		
Эхний үлдэгдэл	69,519	69,519
Эцсийн үлдэгдэл	144,057	144,057

13. Даатгалын өглөг

мянган төгрөг	2019	2020
Нөхөн төлбөрийн өглөг	30,798	25,704
Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	36,118	88,721
Давхар даатгагчид өгөх өглөг	1,783,601	2,799,161
Нийт	1,850,517	2,913,586

14. Бусад санхүүгийн бус өр төлбөр

мянган төгрөг	2019	2020
Орлогын татварын өглөг	-	121,134
Цалингийн өглөг	115,703	289,089
Бусад өглөг	469,462	322,067
НДШ-ийн өглөг	17	10,373
Урьдчилж орсон орлого	152,903	331,503
Богино хугацаат түрээсийн өглөг	-	203,974
Урт хугацаат түрээсийн өглөг *	-	497,905
Нийт	738,085	1,776,045

* Ирээдүйд төлөх түрээсийн төлбөрийг өнөөгийн үнэ цэнээр бэлтгэсэн.

15. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц

мянган төгрөг	2019	2020
Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	5,555,818	5,284,571
Хөрөнгийн даатгал	1,593,673	1,830,681
Авто тээврийн хэрэгслийн даатгал	3,289,162	3,306,673
Ачааны даатгал	7,156	409,480
Барилга угсралтын даатгал	17,846	7,183,826
Мал амьтдын даатгал	1,025	-
Агаарын хөлгийн даатгал	366,794	551,127
Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	28,125	14,151
Хариуцлагын даатгал	1,218,809	1,724,149
Санхүүгийн даатгал	189,704	110,241
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	3,583	-
Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	327,762	451,766
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	234,589	504,420
Нийт	12,834,046	21,371,085

Актурчийн нөөц сангийн тооцооллын тайланд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

ОТХНС нь даатгалын компанийн идэвхтэй байгаа гэрээ бүрээр тооцогдох бөгөөд тайлант хугацаанд даатгалын компанид орлогод хүлээн зөвшөөрөгдөөгүй хураамжийн дүнгээр гэрээний үлдэх хугацаанд ашиглахад зориулсан нөөц бөгөөд уг нөөц сангийн тооцоололд “хувь тэнцүүлэх аргачлал” буюу 365-тын аргыг ашиглан, даатгалын гэрээ бүрээр тооцоолсон.

Хүчинтэй даатгалын гэрээнд үндэслэн тооцоолол хийхэд “Мандал даатгал” ХК-ийн орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан нь 2020 онд нийт 21,371,085 мянган төгрөг (2019 онд 12,834,046 мянган төгрөг) байсан.

16. Нөхөн төлбөрийн нөөц сан

мянган төгрөг	2019	2020
Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан	2,325,582	2,489,888
Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан	819,291	1,640,012
Учирч болзошгүй хохирлын нөөц сан	192,950	1,035,567
Тусгай нөөц сан	1,256,290	1,256,290
Нийт	4,594,113	6,421,757

17. Эздийн өмч

17.1. Өмч

мянган төгрөг	Эргэлтэнд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа		Давуу эрхтэй хувьцаа	Өмчийн дүн
	Тоо ширхэг	Дүн		
Эхний үлдэгдэл	6,243,016	6,243,016	-	6,243,016
Нэмэгдсэн	-	-	-	-
Хасагдсан (-)	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	6,243,016	6,243,016	-	6,243,016

Тайлант хугацааны эцсийн байдлаар 1,359 хувьцаа эзэмшигчтэй байна.

17.2. Дахин үнэлгээний нэмэгдэл

мянган төгрөг	Үнэт цаасны дахин үнэлгээний нэмэгдэл
Эхний үлдэгдэл	(71,096)
Нэмэгдсэн дүн	250,011
Дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	250,011
Хасагдсан дүн (-)	(326,063)
Дахин үнэлгээний хорогдсон зөрүү	(326,063)
Эцсийн үлдэгдэл	(147,148)

18. Даатгалын орлого болон борлуулалтын өртөг

МЯНГУУН ТӨВРӨГ	2019														
	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого	Орлогд тооцогүй хураамжийн өөрчлөлт	Хойшуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	Орлогд тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Нөхөн төлбөрийн цэвэр зардал	Нөхөн төлбөрийн өөрчлөлт	Нөхөн төлбөрийн өөрчлөлт	Нөхөн төлбөрийн өөрчлөлт	Учирч болохгүй хөдөө ажээгээр өөрчлөлт	Зардал тооцсон нөхөн төлбөр	Даатгалын гэрээний зардал
Гэнцгийн өсөл, өнчилгээний зардалын даатгал	8,165,410	424,643	87,671	7,653,096	(375,109)	(199,631)	7,828,574	2,275,176	2,069,653	76,709	60,990	-	-	2,206,952	315,056
Хөрөнгийн даатгал	3,711,482	21,218	1,317,936	2,372,328	1,761	60,787	2,431,354	273,376	180,021	247,892	7,175	-	-	435,088	403,265
Автозэвчийн хэрэгслийн даатгал	6,095,129	516,707	1,192,101	4,398,321	833,712	796,510	4,349,119	1,929,551	1,632,900	54,498	7,917	(121,333)	(1,519)	1,573,982	404,815
Ачааны даатгал	347,929	266,927	7,691	73,311	2,575	(319)	70,417	9,505	9,505	35,030	2,804	(1,519)	(1,519)	45,820	3,735
Барилга угсралтын даатгал	6,377,268	15,452	6,287,764	74,052	(236,590)	(240,082)	70,560	99,528	1,991	1,585,168	124,160	(328,252)	(328,252)	1,383,067	268
Мал ажгайн даатгал	22,000	-	-	22,000	1,025	-	20,975	-	-	1,107	-	-	-	1,107	-
Агаарын хөдлийн даатгал	1,085,192	188,387	806,950	89,855	105,392	87,464	71,927	-	-	(1,296)	-	-	(1,296)	-	-
Автозэвчийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	48,303	37,352	-	10,951	(54,047)	-	64,988	-	-	(1,888)	-	-	(1,888)	-	-
Хариуцлагын даатгал	1,234,057	463,460	177,628	592,969	(647,298)	(321,889)	918,378	560,784	195,240	(305,678)	204,369	-	-	93,931	26,838
Санхүүгийн даатгал	284,555	-	167,916	116,637	11,103	18,254	123,788	-	-	7,110	-	-	-	7,110	-
Зээлийн даатгал	3,764	-	-	3,764	-	-	3,764	-	-	(14,444)	6,291	-	-	(8,159)	-
Төмөр замын болон усан замын гэрээний хэрэгслийн даатгал	50,302	-	12,575	37,727	(76)	(19)	37,764	-	-	(1,636)	-	-	-	(1,636)	-
Агаарын хөдлийг өмчлөх, эзэмшээгүй хэрэгслийн хариуцлагын даатгал	1,011,722	221,687	784,180	5,855	62,252	66,004	9,607	-	-	(1,309)	-	-	-	(1,309)	-
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	490,099	55,123	(22)	434,998	13,993	-	421,005	274,617	274,317	2,175	2,026	(21,618)	-	256,900	23,920
2019 оны нийт дүн	28,927,212	2,210,956	10,842,392	15,873,864	(281,307)	267,079	16,422,250	5,422,537	4,363,827	1,683,438	415,132	(472,722)	-	5,989,675	1,177,917

18. Даатгалын орлого болон борлуулалтын өртөг (үргэлжлэл)

Мянган төгрөг	2020												
	Даатгалын хураамжийн нийт орлого	Даатгалын хураамжийн буцаалт	Давхар даатгалын хураамжийн зардал	Даатгалын хураамжийн цэвэр орлого	Орлогод тооцогүй хураамжийн өөчлөлт	Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт	Орлогод тооцсон хураамж	Нийт нөхөн төлбөрийн зардал	Нөхөн төлбөрийн цэвэр зардал	Нөхөн төлбөрийн өөчлөлт	Учирч болошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	Зарлагд тооцсон нөхөн төлбөр	Даатгалын гэрээний зардал
Гэнэтийн осол, Эмчилгээний зардлын даатгал	8,223,905	873,076	963,455	6,387,374	(271,247)	790,298	7,448,919	2,944,317	2,931,046	706,716	283,469	3,932,000	343,246
Хөрөнгийн даатгал	4,209,187	49,363	1,338,078	2,821,746	237,008	95,288	2,680,026	1,222,075	766,344	79,929	-	786,644	537,020
Автозөврийн хэрэгслийн даатгал	6,472,059	492,754	1,145,018	4,834,287	17,511	(41,658)	4,775,118	2,940,073	2,891,327	628,017	(498,825)	3,536,016	506,462
Ачааны даатгал	972,935	-	708,581	264,354	402,324	291,330	153,360	37,694	37,694	(43,450)	-	(57,56)	814
Барилга угсралтын даатгал	6,685,207	55,780	6,574,894	(45,467)	7,165,982	7,166,376	(45,073)	-	-	(497,650)	(93,209)	(590,859)	132
Мал амьддын даатгал	-	-	-	-	(1,025)	-	1,025	-	-	(1,107)	-	(1,107)	-
Агаарын хөлийн даатгал	1,275,411	-	1,159,552	115,859	184,333	169,279	100,805	-	-	-	-	-	-
Автозөврийн хэрэгслийн жолоосний хариуцлагын даатгал	36,207	325	-	35,882	(13,975)	-	49,857	-	-	248	-	248	-
Хариуцлагын даатгал	3,235,719	35,668	2,300,447	899,604	505,340	672,509	1,066,773	254,326	739,688	90,654	(87,089)	771,533	76,537
Санхүүгийн даатгал	153,881	-	6,270	147,611	(79,463)	(111,945)	115,129	-	-	(7,679)	-	(7,679)	7
Зээлийн даатгал	-	-	-	-	-	-	-	-	-	(2,578)	-	(2,578)	-
Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал	-	14,147	-	(14,147)	(3,583)	(896)	(11,460)	-	-	-	-	-	-
Агаарын хөлийг өмчлөх эзэмшигч ашиглагчтай холбоотой хариуцлагын даатгал	1,060,150	-	1,024,402	35,748	124,003	109,978	21,723	-	-	-	-	-	7,791
Жолоосчийн хариуцлагын албан журмын даатгал	1,000,083	78,885	-	921,198	269,832	-	651,366	463,790	463,790	31,926	136,861	632,577	69,827
2020 оны нийт дүн	33,224,744	1,599,998	15,220,697	16,404,049	8,537,040	9,140,559	17,007,568	7,862,275	7,164,169	985,026	842,618	8,357,039	1,541,836

19. Даатгалын гэрээний зардал

мянган төгрөг	2019	2020
Даатгалын зуучлагчийн шимтгэл	1,104,091	1,332,453
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл	73,826	209,383
Нийт	1,177,917	1,541,836

20. Давхар даатгалын шимтгэлийн орлого

мянган төгрөг	2019	2020
Факультатив давхар даатгал	82,585	36,584
Гэрээт давхар даатгал	-	91,156
Нийт	82,585	127,740

21. Хөрөнгө оруулалтын орлого

мянган төгрөг	2019	2020
Банкинд байршуулсан хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын орлого	2,413,045	1,521,220
ББСБ-д байршуулсан итгэлцлийн хөрөнгө	262,274	301,540
Үнэт цаасны хүүний орлого болон бусад	1,058,965	2,966,152
Нийт	3,734,284	4,788,912

22. Ерөнхий ба удирдлагын зардал

мянган төгрөг	2019	2020
Ажиллагчдын цалингийн зардал	2,829,859	3,681,995
Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	303,906	431,164
Тэтгэмж, урамшууллын зардал	-	69,969
Автомашины зардал	52,376	55,120
Ашиглалтын зардал	14,191	22,490
Бичиг хэрэг, хангамжийн зардал	120,223	92,520
Даатгалын зардал	3,784	238
Албан татвар, төлбөр хураамжийн зардал	5,000	270
Засвар, үйлчилгээний зардал	79,638	102,624
Мэргэжлийн үйлчилгээний зардал	1,138,263	985,878
Сургалтын зардал	61,302	46,889

Томилолтын зардал	67,301	46,631
Түрээсийн зардал	375,536	236,050
Уулзалт, арга хэмжээний зардал	289,419	167,027
Шуудан холбооны зардал	151,029	191,969
Элэгдлийн зардал	119,605	469,689
Нийт	5,611,432	6,600,523

23. Борлуулалт маркетингийн зардал

мянган төгрөг	2019	2020
Бизнес уулзалтын зардал	23,574	24,038
Борлуулалтын үеийн идэвхжүүлэлт	84,919	-
Маркетинг, сурталчилгааны зардал	493,591	428,983
Харилцагчийн халамжийн зардал	412,172	487,000
Нийт	1,014,256	940,021

24. Санхүүгийн зардал

мянган төгрөг	2019	2020
Зээлийн хүүгийн зардал	-	139,264
Түрээсийн хүүгийн зардал	-	115,427
Нийт	-	254,691

25. Бусад зардал

мянган төгрөг	2019	2020
Найдваргүй авлагын зардал	575	402,404
Алданги, торгууль	1,029	15,150
Хандив	1,500	-
Нийт	3,104	417,554

26. Орлогын татварын зардал

мянган төгрөг	2019	2020
Тайлант жилийн татвар	665,047	477,666
Хойшлогдсон татвар	-	-
Нийт	665,047	477,666

Үр ашигт татварын хүүгийн тохируулга дараах байдалтай байна:

мянган төгрөг	2019	Үр ашигт хүү (%)	2020	Үр ашигт хүү (%)
Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу)	6,535,635		5,011,734	
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцох татвар ногдох орлого	(3,859,581)		(3,252,655)	
Бусдад суутгуулсан орлого	(33,768)		(113,038)	
Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн	(12,442)		(488,821)	
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	329,906		1,170,977	
Хойшлогдсон татварын хөрөнгө/өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөгдөөгүй түр зөрүү	(17,024)		(804,193)	
Нийт татвар ногдох орлого	2,942,726	45%	1,524,004	30%
Нийтлэг хувь хэмжээгээр ногдох орлогын албан татвар (2020: 10%)	294,273		152,400	
Тусгайлсан хувь хэмжээгээр тооцох орлогын албан татвар (2020: 10%)	370,774		325,266	
Хойшлогдсон орлогын албан татварын зардал	-		-	
Орлогын албан татварын зардал/ (нөхөлт)	665,047	10%	477,666	10%

27. Ногдол ашиг

Тайлант онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрээр хувьцаа эзэмшигчддээ нэгж хувьцаанд 4 төгрөг буюу нийт 2,497,206 мянган төгрөгийн ногдол ашиг хуваарилаж, хуримтлагдсан ашгийг бууруулсан байна.

28. Санхүүгийн хэрэгсэл

28.1. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлого зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн хэрэгслийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, арга зэргийг Тодруулга 4.9-д дэлгэрэнгүй харуулсан болно.

28.2. Санхүүгийн хэрэгслийн ангилал

Санхүүгийн байдлын тайланд тайлагнасан дансны үнэ нь дараах хөрөнгө, өр төлбөрийн ангилалтай холбоотой:

Санхүүгийн өр төлбөр

мянган төгрөг	2019	2020
Зээл, авлага	618,472	376,269
Даатгалын авлага	6,253,418	5,256,775
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	904,137	2,230,334
Даатгалын хөрөнгө	3,857,214	13,748,739
Хөрөнгө оруулалт	27,638,364	31,355,450
Нийт	39,271,605	52,967,567

Санхүүгийн өр төлбөр

мянган төгрөг	2019	2020
Даатгалын өглөг	1,850,517	2,913,586
Бусад санхүүгийн өр төлбөр	-	19,074
Нийт	1,850,517	2,932,660

29. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явцад зарим эрсдэлүүдтэй тулгарч байна. Үүнд зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл зэрэг байна.

Компани нь арилжааны зорилгоор санхүүгийн хөрөнгийг ч мөн опцион ч худалдаалдаггүй байна.

Санхүүгийн эрсдэлийн хүчин зүйлс*а) Зах зээлийн эрсдэл*

Компани санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл үүсдэг. Үүнд: үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна.

Гадаад валютын эрсдэл

Компани нь гадаад валютаар зарим ажил гүйлгээг хийдэг. Иймд гэрээний нөхцөлөөс хамаарч харилцан адилгүй гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэлд өртдөг байна. Компанийн ихэнх гүйлгээ Монгол төгрөгөөр хийгддэг. Гадаад валютын ханшийн эрсдэлд өртөх нь анх ам.доллаар хийгдсэн Компанийн гадаадад хийсэн даатгалын гэрээний харилцаанаас үүдэн бий болдог байна.

Валютын эрсдэлд өртөж буй гадаад валютаар хийгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дор харуулав. Доорх дүнг хаалтын ханшаар монгол төгрөг рүү хөрвүүлж удирдлагадаа тайлагнасан байна:

Ангилал	Валют	2020 оны 12 дугаар сарын 31	Ашиг, алдагдалд нөлөөлөх 2021 - 10%	
			Ханш өсвөл	Ханш буурвал
Санхүүгийн хөрөнгө				
Банканд байршуулсан мөнгөн хөрөнгө	USD	721.58	205.61	(205.61)
Банканд байршуулсан мөнгөн хөрөнгө	GBP	24.55	9.47	(9.47)
Давхар даатгалын авлага	USD	17,726.91	5,051.30	(5,051.30)
Хөрөнгө оруулалт, хүүгийн авлага	USD	902,143.57	257,066.71	(257,066.71)
Хөрөнгө оруулалт, хүүгийн авлага	CNY	16,757,806.10	730,858.20	(730,858.20)
Санхүүгийн өр төлбөр				
Давхар даатгалын өглөг	USD	163,373.13	(46,553.34)	46,553.34
Дансны өглөг	USD	1,082.71	(308.52)	308.52

Ангилал	Валют	2019 оны 12 дугаар сарын 31	Ашиг, алдагдалд нөлөөлөх 2021 - 10%	
			Ханш өсвөл	Ханш буурвал
Санхүүгийн хөрөнгө				
Банканд байршуулсан мөнгөн хөрөнгө	USD	28,316.24	7,740.30	(7,740.30)
Банканд байршуулсан мөнгөн хөрөнгө	GBP	27.32	10.54	(10.54)
Давхар даатгалын авлага	USD	49,459.77	13,519.93	(13,519.93)
Урьдчилж төлсөн зардал	USD	15,558.90	4,253.06	(4,253.06)
Санхүүгийн өр төлбөр				
Давхар даатгалын өглөг	USD	33,530.99	(9,165.76)	9,165.76
Дансны өглөг	USD	778.34	(212.76)	212.76

Валютын эсрэг төгрөгийн 10%-ийн өсөлт ба бууралтад үзүүлэх Компанийн мэдрэмжийг дээрх хүснэгтээр харуулав. Мэдрэмжийн шинжилгээнд тайлант оны хугацааны эцэст хөрвүүлэлтийн тохируулга хийсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийг хамруулсан.

а) Зээлжих эрсдэл

Зээлжих эрсдэл нь Компанид санхүүгийн эрсдэл үүссэний улмаас гэрээний үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдлийг харуулдаг. Компанийн хувьд энэхүү эрсдэлийн нөлөөлөл нь дансны авлага, хугацаат хадгаламж, гэрээний хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалт, санхүүгийн байгууллагын дансны өр гэх мэт өөр өөр санхүүгийн хэрэгслээс үүсдэг. Дараах санхүүгийн хэрэгслийн дансны үнээр хамгийн их зээлжих эрсдэлийг харуулав.

мянган төгрөг	2019	2020
Санхүүгийн хөрөнгө	1,486,167	936,868
Хөрөнгө оруулалт	27,638,364	31,355,450
Даатгалын авлага	6,253,418	5,256,775
Банкны үлдэгдэл	900,618	2,227,682
Нийт	36,278,567	39,776,775

Тайлант хугацаанд даатгалын авлагатай холбоотой зээлжих эрсдэлийн томоохон асуудал байхгүй байна. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нөөц байгуулах хугацаа хэтэрсэн авлага үүсээгүй.

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсээрх банкны үлдэгдэл болон хөрөнгө оруулалтын тухайд мөнгөн сан байршиж буй банкуудын зарим нь Moody's Investors Service/Standard & Poor's-ийн В зээлийн жагсаалтад багтсан дотоодын банкууд байна. Компани нь СТОУС 17-г хэрэгжүүлж эхлэх хүртэл СТОУС 9-ийг хэрэгжүүлэхээс чөлөөлөгддөг ба зээлийн эрсдэлийг тайлант онд тооцоолоогүй болно.

30. Бодит үнэ цэнийн хэмжилт

Компани нь бодит үнэ цэнийг ажиглан, зэргээр нь 1-3 түвшинд хуваан бодит үнэ цэнийг анх хүлээн зөвшөөрөхөд ашигладаг санхүүгийн хэрэгслийн шинжилгээг хийдэг. Эдгээр түвшин нь:

- Түвшин 1: Ижил төрлийн хөрөнгө болон өр төлбөрийн идэвхтэй зах зээл дэх зарласан (тохируулаагүй) үнийг ашиглан тодорхойлно;
- Түвшин 2: Хөрөнгө болон өр төлбөрийн хувьд боломжит өгөгдлийг ашиглан шууд (үнэ) болон шууд бусаар (үнээс гаралтай) бодит үнэ цэнийг тодорхойлох аргачлалыг 2-р түвшинд хэрэгжүүлнэ;
- Түвшин 3: Зах зээлийн ашиглаж болох өгөгдөлд тулгуурлахгүйгээр (ашиглагдахгүй өгөгдөл) бодит үнэ цэнийг тодорхойлно. Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшинг ашигладаг.

2020 оны 12 сарын 31, мянган төгрөг	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		2,230,334	
Даатгалын авлага		5,256,775	
Хөрөнгө оруулалт			
Банкинд байршуулсан хөрөнгө хадгаламж, хадгаламжийн сертификат		23,808,113	
ББСБ-д оруулсан хөрөнгө оруулалт			4,756,487
Хувьцаагаарх хөрөнгө оруулалт	1,290,850		
Өрийн бичиг		1,500,000	
Бусад санхүүгийн хөрөнгө		376,269	
Даатгалын хөрөнгө		13,748,739	
Бусад санхүүгийн бус хөрөнгө			560,599
Үндсэн хөрөнгө			1,483,514
Биет бус хөрөнгө			144,057
Даатгалын өглөг		2,913,586	
Бусад санхүүгийн өр төлбөр		19,074	
Бусад санхүүгийн бус өр төлбөр			1,776,045

2019 оны 12 сарын 31, мянган төгрөг	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		904,137	
Даатгалын авлага		6,253,418	
Хөрөнгө оруулалт			
Банкинд байршуулсан хөрөнгө хадгаламж, хадгаламжийн сертификат		14,962,578	
ББСБ-д оруулсан хөрөнгө оруулалт			10,118,044
Хувьцаагаарх хөрөнгө оруулалт	1,947,414		
Өрийн бичиг		610,328	
Бусад санхүүгийн хөрөнгө		618,472	
Даатгалын хөрөнгө		3,857,214	
Бусад санхүүгийн бус хөрөнгө		867,695	
Үндсэн хөрөнгө			537,192
Биет бус хөрөнгө			69,519
Даатгалын өглөг		1,850,517	
Бусад санхүүгийн өр төлбөр			
Бусад санхүүгийн бус өр төлбөр			738,085

31. Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь цаашид тасралтгүй ажиллах боломжийг хангахын тулд өөрийн хөрөнгөө удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь гаргасан капитал, нөөц, хуримтлагдсан ашгийг багтаасан эздийн өмчөөс бүрдэнэ.

Санхүүгийн хараат байдлаас зайлсхийх үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага Компанийн капиталын шаардлагыг үнэлнэ. Компани капиталын бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, хөрөнгийн эрсдэлийн шинж чанарыг харгалзан залруулга хийдэг. Капиталын бүтцийг бий болгож, залруулга хийхийн тулд Компани хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашгийн дүнд залруулга хийж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг буцаах, шинээр хувьцаа гаргах, эвсэл өр төлбөрөө бууруулахаар хөрөнгө борлуулна.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав:

мянган төгрөг	2019	2020
Нийт эздийн өмч	20,729,250	22,654,190
Хасах: мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	(904,137)	(2,230,334)
Капитал	19,825,113	20,423,856
Нийт эздийн өмч	20,729,250	22,654,190
Зээллэг	-	-
Бүх санхүүжилт	20,729,250	22,654,190
Нийт санхүүжилт дэх капиталын харьцаа	96%	90%

32. Үүрэг

32.1. Капиталаас хүлээх үүрэг

Компани нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар даатгалын нөхөн төлбөртэй холбоотой 255,673.9 мянган төгрөгийн нэхэмжлэлийн маргаантай байгаа бөгөөд уг нэхэмжлэлтэй холбоотой шүүхийн ажиллагаа хараахан дуусаагүй байна.

32.2. Үйл ажиллагааны түрээсээс хүлээх үүрэг

Голлох үйл ажиллагааны түрээс нь оффисын талбайн 2-5 жилийн хугацаагаар байгуулсан түрээстэй холбоотой юм. Компани нь түрээсийн хугацаа дуусахад түрээслэсэн хөрөнгийг худалдан авах эрхгүй байна. Тус түрээсийн гэрээнүүд нь 2022-2024 дуусгавар болох бөгөөд түрээсийн гэрээ дуусвар болох хүртэл төлөх үүрэгтэй түрээсийн төлбөрийг Тодруулга 14-өөс харна уу.

32.3. Холбоотой талуудын тодруулга

Толгой компани, хамгийн дээд хяналт тавигч компани, хувь хүний талаарх мэдээлэл Компанийн 40.85%-ийг "Голомт Файнаншил Групп" ХХК, 36.51%-ийг "Юу Эм Си Капитал" ХХК, 22.64%-ийг олон нийт эзэмшиж, хянаж байна.

“Голомт Файнэншил Групп” ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хөрөнгө оруулалтын компани юм. Ноён Д. Баясгалан нь тус группийн ихэнх хувийг эзэмшдэг бөгөөд “Мандал даатгал” ХК-д хамгийн дээд хяналт тавигч хувь хүн юм.

Холбоотой талын нэр	Ажил гүйлгээний утга	Өмнөх онд	Тайлант онд
Юу Эм Си Капитал ХХК	Ногдол ашиг олгов.	204,138	911,715
Голомт файнэншил групп ХХК	Даатгал борлуулав	6,899	7,474
Голомт файнэншил групп ХХК	Нөхөн төлбөр олгов	300	140
Голомт файнэншил групп ХХК	Ногдол ашиг олгов.	229,500	1,020,000
Голомт банк ХХК	Зуучлан борлуулалтын дүн	4,478,921	3,751,481
Голомт банк ХХК	Зуучлагчийн шимтгэлийн дүн	749,126	855,362
Голомт банк ХХК	Даатгал борлуулав / Өөрийнх/	595,346	356,893
Голомт банк ХХК	Даатгалын хураамжийн буцаалт хийв	17,867	4,762
Голомт банк ХХК	Нөхөн төлбөр олгов	71,398	106,827
Голомт банк ХХК	Кастодианы үйлчилгээ авав	16,000	2,981
Голомт капитал ХХК	Даатгал борлуулав	-	2,683
Голомт капитал ХХК	Даатгалын буцаалт	-	73
Мандал лайф ХХК	Тэтгэврийн сангийн авлага	20,605	28,528
Мандал лайф ХХК	Тэтгэврийн сангийн өглөг	7,766	-

Удирдах гол албан тушаалтнууд нь Гүйцэтгэх захирал болон нэгжүүдийн захирлууд юм. Захирлууд болон бусад удирдлагын голлох ажилтнуудын тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна

мянган төгрөг	2019	2020
Цалин, НДШ	734,939	958,918
Бусад тэтгэмж	16,389	41,193
Нийт	751,328	1,000,111

34. Төлбөрийн чадварын харьцаа

Компанийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 161.40% (2019:157.53%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан “Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино” гэсний дагуу төлбөрийн чадварын шаардлагыг хангаж байна.

Үзүүлэлт	Дүн	Тооцох хувь	Тооцсон дүн
1	2	3	4
1. Зайлшгүй байх хөрөнгө / $1 = \max(1.1, 1.2, 1.3)$ /			5,510,452
1.1 Даатгалын хураамжид үндэслэх /Тухай тайлант хугацааны нийт орлогод тооцсон хураамж / $(1.1.1 (4)+1.1.2 (4))$			5,510,452
1.1.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн орлогод тооцсон хураамж	10,544,692	40%	4,217,877
1.1.2 Бусад хэлбэрийн орлогод тооцсон хураамж	6,462,876	20%	1,292,575
1.2 Даатгалын нэхэмжлэлд үндэслэх / Сүүлийн 3 жилийн дундажид үндэслэн/ $(1.2.1 (4)+1.2.2 (4))$			3,034,838
1.2.1 Агаарын хөлөг, авто тээврийн хэрэгсэл, бүх төрлийн хариуцлагын даатгалын хэлбэрийн нэхэмжилсэн хохирлын дундаж дүн	4,874,611	50%	2,437,305
1.2.2 Бусад хэлбэрийн нэхэмжилсэн хохирлын дундаж дүн	2,987,665	20%	597,533
1.3 Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээ			5,000,000
2. Нийт хөрөнгө			42,123,139
3. Зөвшөөрөгдөхгүй хөрөнгө			3,392,258
4. Зөвшөөрөгдөх хөрөнгө / $4 = (2) - (3)$ /			38,730,881
5. Өр төлбөр / $5 = \text{Нийт өр төлбөр} - \text{ОТХН} * 10\%$ /			18,486,699
6. Төлбөрийн чадварын зохистой харьцаа			161.40%

35. Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр

Болзошгүй хөрөнгө ба өр төлбөрийн мөн чанар, хэрэв практик боломжтой бол тэдгээрийн санхүүгийн нөлөөний тооцооллыг тодруулна.

36. Тайлагналын үеийн дараах үйл явдал

Дэлхий даяар тархаад байгаа Ковид-19 цар тахал нь Монгол улсад илэрсэнтэй холбоотойгоор Улсын онцгой комиссын шийдвэрээр 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн хэсэгчилсэн хугацаатайгаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжсэн билээ.

Илэрсэн вирусын голомтыг тогтоож, бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг Монгол орон даяар хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэний улмаас 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 06 цагаас эхлэн хатуу хөл хорионы дэглэмийг бууруулж, Монгол улсын эдийн засгийг идэвхжүүлж, бизнесийн үйл ажиллагааг нээн, амьдралын хэвийн горимд шилжихээр болсон байна.

Мандал даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 2-р сарын 18-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрээр 2020 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 3 төгрөг буюу нийт 1,872,904.8 мянган төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн байна.

37. Орчуулга

Эдгээр санхүүгийн тайланг Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн бөгөөд Монгол болон Англи хувилбар хооронд зөрүү гарвал, Монгол хувилбарыг дагах болно.

38. Санхүүгийн тайлангийн баталгаажуулалт

2020 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болсон санхүүгийн тайланг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр удирдлага батлав.



www.mandal.mn